


# ДОРНОД АЙМГИЙН ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ОРОЛЦООНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

**Гүйцэтгэсэн хугацаа:** 2020 оны 10 сарын 20-ноос 2021 оны 02 сарын 10-ыг хүртэл

**Тайлан боловсруулсан**:

Д.Бужин, ЛЭОС-ийн Дорнод аймаг дахь салбар зөвлөлийн тэргүүн
Н.Алтанцэцэг, Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
Б.Оюун-Эрдэнэ, “Талын Сувдан гүүр” ТББ-ын тэргүүн
Р. Жаргалсайхан, Дорнод аймгийн Ажил олгогч эздийн холбооны тэргүүн
Б.Оюундэлгэр, ЛЭОС-ийн Дорнод аймаг дахь салбар зөвлөлийн УЗ-ийн гишүүн
Д.Оюунхүү, Нүүдлийн номын сан сургалтын төвийн менежер

**2021 он**

**Агуулга**


1. Товчилсон үгийн жагсаалт 2
2. Хүснэгтийн жагсаалт 3
3. Графикийн жагсаалт 4
4. Талархал 5
5. Хураангуй 6
6. Удиртгал 9
   - 1.1 Үндэслэл 9
   - 1.2 Зорилго, зорилтууд 9
   - 1.3 ОХШҮ-ний хамрах хүрээ 10
7. ОРОЛЦООТ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ 11
   - 2.1 Мэдээлэл цуглуулах аргууд 11
   - 2.2 Түүвэрлэлт 13
   - 2.3 Мэдээлэл цуглуулалтын үйл ажиллагаа 14
   - 2.4 Зөвлөлдөх уулзалт 16
8. ОРОЛЦООТ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН 18
   - 3.1 Оролцоот хяналт шинжилгээний үр дүн 18
   - 3.2 Оролцоот үнэлгээний үр дүн 37
9. Дүгнэлт 63
10. Зөвлөмж 67
11. Ашигласан материал 70
12. Хавсралтын жагсаалт 72

## Товчилсон үгийн жагсаалт

ААН-Аж Ахуйн Нэгж
БОЭТ- Бүсийн Оношилгоо, Эмчилгээний Төв
БЗДХ-Бэлгийн Замаар Дамжин Халдварлах
ГБХЗХ- Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын Хөгжлийн Газар
ЕБС- Ерөнхий Боловсролын Сургууль
ЖҮХ-Жендэрийн Үндэсний Хороо
ЖЭТБ-Жендэрийн Эрх Тэгш Байдал
ЖЭТБХ-Жендэрийн Эрх Тэгш Байдлыг Хангах
ЗДТГ-Засаг Даргын Тамгын Газар
ИТХ- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИНБ-Иргэний Нийгмийн Байгууллага
ИНБЗ-Иргэний Нийгмийн Байгууллагуудын Зөвлөл
МОНЭС-Монголын Эмэгтэйчүүдийн Сан
НБХ-Нийгмийн Бодлогын Хэлтэс
НҮБ- Нэгдсэн Үндэсний Байгууллага
ОСХШҮ-Оролцоонд Суурилсан Хяналт Шинжилгээ Үнэлгээ
ОХШҮ- Оролцоот Хяналт Шинжилгээ Үнэлгээ
ОУБ-Олон Улсын Байгууллага
ТББ-Төрийн Бус Байгууллага
ХХААНБ-Хувийн хэвшил, аж ахуйн нэгж, байгууллага
ХХК-Хариуцлагатай Хувьцаат Компани
ХЭҮК-Хүний Эрхийн Үндэсний Комисс
ҮЭХ-Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо
ЭЕШ-Элсэлтийн Ерөнхий Шалгалт

**Хүснэгтийн жагсаалт**


Хүснэгт 1. Баримт бичиг судлах аргаар цуглуулсан мэдээллийн хүрээ.
Хүснэгт 2. Түүврийн хэмжээ.
Хүснэгт 3. Мэдээлэл цуглуулах үйл ажиллагааны төлөвлөлт.
Хүснэгт 4. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн зорилт ба үйл ажиллагааны чиглэл
Хүснэгт 5. ЖЭТБХ дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, төсөв. 2018-2020 он
Хүснэгт 6. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөлт ба хэрэгжилт /оноор/
Хүснэгт 7. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд өгсөн төрийн байгууллагын үнэлгээ ба ОХШҮ-ний багийн үнэлгээ
Хүснэгт 8. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд өгсөн төрийн байгууллага ба ОХШҮ-ний багийн үнэлэгээ
Хүснэгт 9. Дорнод аймгийн сумдын ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчид /2012-20124/
Хүснэгт 10. Дорнод аймгийн ИТХ-ийн эмэгтэй төлөөлөгчид. /2012-2024/
Хүснэгт 11.ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэнд өгсөн төрийн байгууллага ба ОХШҮ-ний багийн үнэлгээний харьцуулалт
Хүснэгт 12. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд өгсөн төрийн байгууллага ба ОХШҮ-ний багийн үнэлгээний харьцуулалт /3.1.4/
Хүснэгт 13. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд өгсөн төрийн байгууллага ба ОХШҮ-ний багийн үнэлгээний харьцуулалт /3.1.5/
Хүснэгт 14. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд өгсөн төрийн байгууллага ба ОХШҮ-ний харьцуулалт / 3.2.1/
Хүснэгт 15.ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд өгсөн төрийн байгууллага ба ОХШҮ-ний багийн үнэлгээний харьцуулалт /3.2.2/
Хүснэгт 16. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд өгсөн төрийн байгууллага ба ОХШҮ-ний багийн үнэлгээний харьцуулалт /3.2.3/
Хүснэгт 17. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд төрийн байгууллага ба ОХШҮ-ний багийн үнэлгээний харьцуулалт /3.2.4/
Хүснэгт 18. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд төрийн байгууллага ба ОХШҮ-ний багийн үнэлгээний харьцуулалт /3.2.5/
Хүснэгт 19. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд төрийн байгууллага ба ОХШҮ-ний багийн үнэлгээний харьцуулалт /3.3.1/
Хүснэгт 20. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд төрийн байгууллага ба ОХШҮ-ний үнэлгээний харьцуулалт /3.3.2/
Хүснэгт 21. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд төрийн байгууллага ба ОХШҮ-ний багийн үнэлгээний харьцуулалт /3.3.3/
Хүснэгт 22. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд төрийн байгууллага ба ОХШҮ-ний багийн үнэлгээний харьцуулалт /3.3.4/
Хүснэгт 23. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд төрийн байгууллага ба ОХШҮ-ний багийн үнэлгээний харьцуулалт /3.3.5/
Хүснэгт 24. Боловсролын түвшин ба эрхэлж буй ажил /хүйсээр/
Хүснэгт 25. Насны ангилал ба ам бүлийн тоо/хүйсээр/
Хүснэгт 26. Ажил эрхэлж буй салбар ба албан тушаал /хүйсээр/Хүснэгт. Ажил эрхэлж буй салбар ба албан тушаал/хүйсээр/
Хүснэгт 27. Жендэрийн тухай ойлголт/хүйсээр/
Хүснэгт 28. Хөдөлмөрийн харилцаан дахь ЖЭТБ хангаж буйг үнэлсэн байдал
Хүснэгт 29. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам дахь ЖЭТБХ хэм хэмжээ

Хүснэгт 30. Байгууллагын хамтын гэрээ, хэлэлцээрт туссан ЖЭТБХ хэм хэмжээ/албан байгууллагаар/
Хүснэгт 31. Байгууллагын хөдөлмөрийн харилцаанд гардаг зөрчил /хүйс, насаар/
Хүснэгт 32. Уул уурхайн салбарт ажиллаж буй ажилчдын ажил амралтын хугацаа /хувиар/
Хүснэгт 33. Ажлын байрны нөхцөл, эрхэлж буй ажлаас хамаарах асуудал /хүйс, насаар/
Хүснэгт 34. Ажлын байрны нөхцөл, эрхэлж буй ажлаас хамаарах асуудал/байгууллага, хүйс, хувиар/
Хүснэгт 35. Жендэрийн мэдлэг, чадвар, хандлага олгох үйл ажиллагаанд хамрагдсан
Хүснэгт 36. Орон нутгийн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд оролцох үйл ажиллагааны чиглэл, хэлбэр
Хүснэгт 37. Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн боловсролын түвшин ба ажиллаж буй салбар /хувиар/
Хүснэгт 38. Эрэгтэйчүүдийн боловсролыг эрхэлж буй ажил, албан тушаалаар нь
Хүснэгт 39. Эрэгтэйчүүдийн жендэрийн тухай ойлголт, мэдлэгийн түвшин/хувиар/
Хүснэгт 40. Нийгэмд ЖЭТБХ нь хувь хүний амьдралд үзүүлэх нөлөөллийн талаарх төсөөлөл /боловсролын түвшин, хувиар/

**Графикийн жагсаалт**

График 1. Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцаа /хувиар/
График 2. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн зорилтуудыг хангах үйл ажиллагааны чиглэлийн хэрэгжилт /тоогоор/
График 3. Иргэдийн жендэрийн тухай ойлголт
График 4. Нийгэмд ЖЭТБХ нь хувь хүний амьдралд үзүүлэх нөлөөллийн талаарх төсөөлөл
График 5. Байгууллагын хамтын гэрээ, хэлэлцээрт туссан хэм хэмжээ
График 6. Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн боловсролын түвшин /хувиар/
График 7. Эрэгтэйчүүдийн жендэрийн тухай ойлголт, мэдлэгийн түвшин ба ажил эрхлэлтийн салбар/хувиар/
График 8. Эрэгтэйчүүдийн жендэрийн хандлага /хувиар/
График 9. Нийгэмд ЖЭТБХ нь хувь хүний амьдралд үзүүлэх нөлөөллийн талаарх төсөөлөл /хувиар/
График 10. Сүүлийн 2 жил эрүүл мэндийн үйлчилгээ авсан байдал /төрөл, хувиар/
График 11. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ аваагүй шалтгаан/хувиар/
График 12. Эрүүл мэндийн үйлчилгээ авч буй эрүүл мэндийн байгууллагын шатлал/хувиар/
График 13. Эрүүл мэндийн үйлчилгээ ба үнэлгээ /хувиар/
График 14. Эрүүл мэндийн үйлчилгээ авахад төвөгтэй байдаг шалтгаан/хувиар/
График 15. Эрэгтэйчүүд өөрийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг сонгосон байдал /хувиар/
График 16. Амь эрсдэхээр ямар нэгэн тохиолдолд өртөж байсан /төрөл, тоо/
График 17. Эрэгтэйчүүдийн эрхэлж буй ажлын эрүүл мэндэд нөлөөлөх эрсдлийн түвшин /хувиар/
График 18. Эрэгтэйчүүд БОЭТ-өөр үйлчлүүлж буй байдал
График 19. Цэрэг татлагт хамрагдсан иргэдийн эрүүл мэндийн үзүүлэлт
График 20. Цэрэг татлагт ирсэн эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үзүүлэлт /2018-2020/
График 21.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн байдлын үнэлгээ /хувиар/

## Талархал

"Иргэний нийгмийн байгууллагын оролцоотойгоор жендэрийн тэгш байдлыг хангах нь" төслийн хүрээнд "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн явцад олон улсын "Оролцоот хяналт шинжилгээ үнэлгээний аргачлал"-аар хяналт шинжилгээ үнэлгээ хийх боломж нөхцлөөр хангасан Жендэрийн Үндэсний хороо болон Азийн Хөгжлийн Банкны хамт олонд гүнээ талархал илэрхийлье!

Дээрх төслийн хүрээнд Дорнод аймгийн "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн явцад оролцоот хяналт шинжилгээ, үнэлгээ (ОХШҮ)-ний ажлыг хийхэд үнэтэй санал, зөвлөгөө өгч, техник арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлсэн Жендэрийн зөвлөх үйлчилгээний багийн ахлагч, МУБИС-ийн багш, доктор, дэд профессор С.Түмэндэлгэр, МУИС-ийн багш, доктор, профессор Т.Бүрэнжаргал, "Нийгмийн бодлого хөгжлийн судалгааны хүрээлэн"-гийн гүйцэтгэх захирал Ц.Одгэрэл нарт талархаж байгаагаа илэрхийлж байна.

Энэхүү ОХШҮ-ний ажлыг цаг зав, хүч хөдөлмөр гаргаж гардан зохион байгуулсан орон нутгийн ИНБ-уудын ОХШҮ-ний багийн гишүүдийн хүчин зүтгэлийг зориуд тэмдэглэхийг хүсч байна. ОХШҮ-ний ажилд оролцож үнэтэй мэдээлэл өгч хамтран ажилласан орон нутгийн удирдлага, төрийн болон хувийн хэвшил, аж ахуйн нэгж байгууллагын ажилтан нарт онцгойлон талархал илэрхийлье!

## Хураангуй

Сүүлийн жилүүдэд Монгол улсад жендэрийн эрх тэгш байдлыг хангах эрх зүй, бодлогын орчин сайжирч үндэсний тогтолцоо амжилттай хөгжиж ирлээ. 2011 онд ЖЭТБХ тухай хуультай болж, хуулийн хэрэгжилтийг дэмжих зорилгоор Засгийн газрын дунд хугацааны стратеги /2013-2015/ болон Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж ирсэн нь төр, ИНБ-уудын хамтын ажиллагааны үр дүн юм. Өнөөдөр Монгол улсын Ерөнхий сайдаар ахлуулсан Жендэрийн үндэсний хороо болон ажлын алба, аймгуудад жендэрийн салбар хороод ажиллаж, жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй болж орон нутгийн хэрэгцээнд суурилсан жендэрийн бодлого төлөвлөлтийг амжилттай хэрэгжүүлж байна.

ЖЭТБ хангах тухай хууль, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан ЖЭТБХ үндэсний хөтөлбөр /2017-2021/, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус үндэслэн Дорнод аймгийн ЖЭТБХ дэд хөтөлбөр боловсруулагдаж, 2018 оноос эхлэн хэрэгжиж эхэлсэн.

Аймгийн ЖЭТБ-ыг хангах дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд “Оролцоот хяналт шинжилгээ үнэлгээний аргачлал”-аар үнэлгээ хийж, санал зөвлөмж боловсруулан, иргэд, олон нийттэй зөвлөлдөх үйл ажиллагааг зохион байгуулах зорилгоор “Иргэний нийгмийн оролцоотой жендэрийн тэгш байдлыг хангах” (TA9750-MON) техник туслалцааны төслийг Жендэрийн Үндэсний хорооны удирдлагаар Дорнод аймгийн ИНБ-уудаас хэрэгжүүлэв. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр ажиллаж буй төрийн байгууллага, түүний удирдах ажилтан, мэргэжилтнүүд болон хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий бодлого тодорхойлогч, бодлогыг хэрэгжүүлэгч нарын зүгээс орон нутгийн бодлогын бичиг баримт, холбогдох хууль дүрэм журмын хүрээнд 2018-2020 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлантай танилцаж ЖЭТБ-ыг хангах дэд хөтөлбөрийн хэрэгжилтэнд үнэлгээний ажлыг хийлээ. Төсөл хэрэгжсэнээр жендэр болон ЖЭТБ-ын талаар иргэдийн ойлголт мэдлэг дээшилж, орон нутгийн Иргэний нийгмийн байгууллагуудын төртэй бүтээлчээр хамтран ажиллах, хяналт тавих оролцооны түвшин нэмэгдэж, ОХШҮ-ний аргачлалаар үнэлгээ хийх чадварт суралцсан.

Орон нутгийн шийдвэр гаргах түвшинд ажиллаж буй болон удирдах ажилтнуудын жендэрийн талаарх мэдлэг ойлголт нэмэгдэж, жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, төсвийг жил бүр нэмэгдүүлж байна. Тухайлбал: “Аз жаргал” төв, “Нэг цэгийн үйлчилгээ”-ний төв болон “Хохирогчийг хамгаалах байр”-ны тогтвортой байдлыг хангах зорилгоор жил бүр орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлэх, бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх болон өсвөр үеийнхний эрүүл мэндийг дэмжих чиглэлээр төсөл хөтөлбөр амжилттай хэрэгжсэн байна. Мөн ЖҮХ-ны дэмжлэгээр хэрэгжиж буй "Иргэний нийгмийн байгууллагын оролцоотойгоор жендэрийн тэгш байдлыг хангах нь" техник туслалцааны төслийн ОХШҮ-ний ажлын явцад орон нутгийн ИНБ-уудын зөвлөл болон төслийн багийн гишүүдээс “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөр” боловсруулсныг төрийн байгууллагын зүгээс дэмжиж 2021 оны 01-р сард аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар баталж шийдвэрлэсэн байна.

Дэд хөтөлбөрийн зорилтуудыг хангах чиглэлийн хүрээнд хийгдээгүй ажил 20 хувийг эзэлж байна. Үүнд: “Жендэрийн судалгаанд тулгуурлаж эрэгтэйчүүд болон хөвгүүдэд зориулсан кабинетыг байгуулан эрүүл мэндийн үзлэг, оношлогоо, сэтгэл зүйн үйлчилгээг нэмэгдүүлэх, “Уул уурхайн салбар болон улирлын шинжтэй ажил, хөдөлмөр эрхэлж буй иргэдийн эрүүл мэнд, ахуй нөхцөл, гэр бүлийн амьжиргаа, тогтвортой байдалд жендэрийн дүн шинжилгээ хийж, зөвлөмжийг оролцогч талуудад өгөх, “Төр, хувийн хэвшлийн ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгох, иргэдийг ажилд авахад хүйсээр ялгаварлахгүй байх, ажлын байран дахь хүчирхийллээс сэргийлэх ажлыг төр, ИНБ-тай хамтран хэрэгжүүлэх гэсэн ажлууд орж байна.

ОХШҮ-ний ажлын дүн шинжилгээнд тулгуурлан ОНЖДХ дэд хөтөлбөрт тусгагдсан ”Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн ажил олгогч болон ажиллагсдын ЖЭТБ-ын талаарх

ойлголт мэдлэг болон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, ажлын байрны нөхцөл байдал" болон "Эрэгтэйчүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх" гэсэн 2 асуудлыг орон нутгийн жендэрийн тулгамдсан асуудал хэмээн үзэж ОХШҮ-ний багаас тодруулан судалсан байна. Жендэрийн тулгамдсан асуудлын хүрээнд Дорнод аймгийн Хэрлэн сумын 11 багийн 261 хүнээс асуулга судалгаа авч, төр, ИНБ-уудын удирдах ажилтан 20 хүнтэй ганцаарчилсан ярилцлага, төр, хувийн хэвшил, ИНБ-уудын төлөөлөл 29 хүнтэй 3 удаагийн бүлгийн ярилцлага, 2 удаагийн зөвлөлдөх уулзалтын ажиллагааг тус тус зохион байгуулсан.

Орон нутагт төрийн байгууллагын зүгээс эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн онцлог хэрэгцээнд зориулсан эмнэлгийн тусламж үйлчилгээний хүрээнд нарийн мэргэжлийн эмч бэлтгэх, шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авах, урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ хийх ажлуудыг эхлүүлсэн боловч энэ нь урологийн тусламж үйлчилгээ болон БЗХӨ-өөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд чиглэгдэж, андрологийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх боломжгүй байна. Одоогийн байдлаар эрэгтэйчүүдэд үзүүлэх андрологийн болон сэтгэл зүйн тусламж үйлчилгээ тус аймагт хөгжөөгүй байна.

Эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйл архи, тамхины хэрэглээ эрэгтэйчүүдийн дунд өндөр байгаа ба сэтгэл зүйн хямралын тусламж үйлчилгээнд хамрагдалт хангалтгүй, "Нөхөн үржихүйн асуудал" асуудлын хүрээнд эмэгтэйчүүдийг илүү анхаарч, эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал хангалтгүй, энэ талаар зөвлөгөө мэдээлэл өгөх, үзлэг шинжилгээ хийх нөхцөл бүрдээгүй, эрэгтэйчүүдийн эмч, эмнэлэг, кабинет, нэгж орон нутагт дутагдалтай байна.

Хувийн хэвшлийн болон ААН байгууллагад ажиллаж буй удирдах ажилтан, ажиллагсдад жендэрийн талаар сургалт, мэдээллийн үйл ажиллагаа хийдэггүйгээс тэнд ажиллаж буй ажилтан албан хаагчдын жендэрийн талаарх ойлголт болон ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар сайн мэдэхгүй байгаагаас байгууллагын хөдөлмөрийн гэрээ, дотоод журам, бодлогын бичиг баримтууд жендэрийн мэдрэмжгүй боловсруулагдаж байна. Мөн уул уурхай болон газрын тосны салбарт ажлын байрны дарамт, ажлаас шалтгаангүй халагдах, ажилчдын хүйсийн харьцаа алдагдсан, гадаад дотоодын ажилчдын дунд хөдөлмөрийн хөлсний зөрүү их байна.

Байгууллагын хөдөлмөрийн харилцаанд "Хүний нөөцийн бүртгэл судалгаа, хувь хүний ур чадвар, амжилтыг үл харгалзан ажилтныг албан тушаал дэвшүүлэх, шагнаж урамшуулах, шаардлагатай ажлын байр, нөхцөлд ажилтан авахдаа хүйсийн харьцааны тэнцвэртэй байдлыг харгалзахгүй байх, ажлын байрны орон тооны зар мэдээнд нас, хүйс заах, мэдээлэл хүртээмжтэй авах боломжоор хангахгүй байх, хөдөлмөрийн харилцаанд гарсан хүний эрхийн зөрчлийн талаарх өргөдөл, гомдлыг барагдуулахгүй байх, үл ойшоох, цалингийн шатлалд ялгавартай хандах, хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн харилцаанд жендэрээр ялгаварлан гадуурхах, эрэгтэй, эмэгтэй хүйсийн аль нэгэнд давуу эрх олгох, хязгаарлалт тогтоох, жирэмсэн, хүүхэд асарсан болон гэр бүлийн байдлын шалтгаанаар ажилтныг ажлаас халах" гэсэн зөрчлүүд түлхүү гардаг байна.

ОХШҮ- ний ажлын үр дүн, дүгнэлтэнд үндэслэн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт зориулан ОХШҮ-ний багаас бодлогын зөвлөмж гаргасан. Үүнд: ЖЭТБ-ыг хангах дэд хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт, хяналт шинжилгээ үнэлгээний ажлын хэрэгжилтийг сайжруулах талаар **Жендэрийн Үндэсний хороонд хандаж** "Төрийн байгууллагын салбар, нэгжүүдэд жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтнийг ажиллуулах, ажил үүргийн тэнцвэрт байдлыг хангуулах талаар зөвлөмж, зааварчилгаа өгөх", "Орон нутгийн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний тайлан мэдээнд санал зөвлөмж өгөх, техник арга зүйн дэмжлэг үзүүлэх", **Аймаг, сумын ИТХ, ЗДТГ, хэлтэс, агентлагийн удирдах ажилтан нарт хандаж:** Дэд хөтөлбөрийн зорилтуудын хэрэгжилтийг хангахуйц төсвийг төлөвлөж батлах, Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын

салбарын жендэрийн нэгдсэн бодлогыг үндэсний болон орон нутгийн дэд хөтөлбөрийн зорилтуудтай уялдуулж төлөвлөх, ажлын гүйцэтгэлд хяналт тавих, дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулахдаа хөтөлбөрийн үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлттэй уялдуулж, биелэлтийг түүнд нийцүүлэн үнэлж байх, Орон нутгийн төрийн байгууллагын бодлого боловсруулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, тайлан мэдээ гаргах, хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүдийг жендэрийн асуудлаар чадавхжуулах, Орон нутгийн салбар, нэгжүүд өөрсдийн гаргаж буй хүйсээр ангилсан статистик мэдээллийн нэр төрлийг нэмэгдүүлэхэд тусгайлсан төлөвлөгөө, төсвийг гаргаж ажиллах, ЖЭТБ-ыг хангах дэд хөтөлбөр болон бусад нийгмийн чиглэлийн төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг тогтмолжуулах, ОХШҮ-ний аргачлалыг нутагшуулах зэрэг асуудлыг оруулсан байна.

**“Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн ажил олгогч, ажиллагсдын жендэрийн талаарх ойлголт мэдлэг болон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, ажлын байрны нөхцөл байдлыг сайжруулах талаар зөвлөмжинд**: “Байгууллагын ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгоход чиглэсэн бодлого төлөвлөлтийг орон нутгийн үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтран боловсруулж, мөрдүүлэх, Хувийн хэвшлийн байгууллагын удирдах ажилтан болон ажиллагсдад жендэрийн асуудлаар сургалт мэдээллийн ажиллагаа зохион байгуулах, Байгууллагын дотоод журам, бодлогын бичиг баримтуудыг жендэрийн агуулгатай болгох, Жендэрийн аудитыг хийж эхлэх, “Байгууллагын хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн тулгамдсан асуудал болон хөдөлмөрийн нөхцөл байдлын талаар судалгаа хийх зэрэг асуудлыг тусгасан.

**“Эрэгтэйчүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж”-ийг сайжруулах ажлын талаар зөвлөмжид:** Шийдвэр гаргагчдад эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, түүнд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар нөлөөллийн үйл ажиллагаа явуулах, Нийгмийн амьдралын бүх хүрээнд эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг таниулж оролцоог нэмэгдүүлэх, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчдэд эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн онцлог хэрэгцээг ойлгуулахад чиглэсэн сургалт, сурталчилгаа зохион байгуулах, Эрэгтэйчүүдэд үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж, сэтгэл засалын зөвлөгөө өгөх болон андрологийн тусламж үзүүлэх эмч мэргэжилтнийг БОЭТ болон сум, өрхийн эрүүл мэндийн төвийн түвшинд бэлтгэх, чадавхжуулах, Хувийн хэвшлийн аль нэг үүдэн эмнэлгийг түшиглэн эрэгтэйчүүдийн үүдэн эмнэлэг байгуулах, Эрэгтэйчүүдийн амьдралын эгзэгтэй мөчүүдэд тулгарах сэтгэл зүй, эрүүл мэндийн асуудлуудад зөвлөгөө өгөх бүтцийг төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагаанд түшиглэн хөгжүүлэх, Жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөнийг өрнүүлэх, Цэргийн насны эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн онцлог асуудлаар судалгаа хийх, “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд ажлын хэсэг байгуулан, хэрэгжилтийг ханган ажиллах зэрэг асуудлууд орсон.

ОХШҮ-ний ажлын тайлан, бодлогын зөвлөмжийг бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт хүргэж зохих шийдвэр гаргахад нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулахаар орон нутгийн ИНБ-уудаас төлөвлөөд байна.

## НЭГ. УДИРТГАЛ

### 1.1 Үндэслэл

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн Зорилт 1-ийн хүрээнд “Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн ажил олгогч болон ажиллагсдын ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг болон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, ажлын байрны нөхцөл байдлыг тодорхойлох” чиглэлээр бүх нийтэд жендэрийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн цогц арга хэмжээ хангалтгүй хэрэгжсэн байна. Мөн хувийн хэвшлийн байгууллагуудын ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгох, эрэгтэй эмэгтэй ажилтанд

адил хэмжээний цалин хөлс олгох, иргэдийг ажилд авахад хүйсээр ялгаварлахгүй байх, ажлын байран дахь хүчирхийллээс сэргийлэх ажлыг орон нутагт төр, ИНБ-уудтай хамтран хэрэгжүүлсэн ажлууд дутмаг байна.

Дэд хөтөлбөрийн Зорилт 3-ын хүрээнд "Эрэгтэйчүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг тодорхойлох" зорилгоор эрэгтэйчүүд болон хөвгүүдэд зориулсан кабинетыг байгуулан эрүүл мэндийн үзлэг оношилгоо, сэтгэл зүйн зөвлөгөө бусад үйлчилгээг нэмэгдүүлэх; Эрэгтэйчүүд судлал, эрэгтэйчүүдэд үзүүлэх цогц үйлчилгээний эхлэл тавигдсан байна гэсэн заалтууд хэрэгжээгүй болох нь баримт бичгийн шинжилгээгээр илэрхий болсон.

Иймд баримт бичгийн шинжилгээний үр дүнд үндэслэн дараах 2 асуудлыг жендэрийн тулгамдсан асуудал хэмээн тодорхойлж оролцоонд суурилсан хяналт шинжилгээ үнэлгээний аргачлалын дагуу үнэлгээ хийлээ. Үүнд:

- Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн ажил олгогч болон ажиллагсдын ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг болон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, ажлын байрны нөхцөл байдал;
- Эрэгтэйчүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж;

Төр, ИНБ-ын 7 хүний бүрэлдэхүүнтэй ОХШҮ-ний багийн гишүүд дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч болон үр шимийг хүртэгчидтэй ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийх, зөвлөлдөх уулзалтыг цахимаар зохион байгуулах, ЖЭТБХ тухай хууль, дүрэм, журам энэ чиглэлээр орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлийн тайлан мэдээ, иргэдийн жендэрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт, хандлагыг судлан тодорхойлох, цуглуулсан тоон мэдээллийг боловсруулах, судалгааны дүнг нэгтгэн тайлан бичих ажлуудыг 2020 оны 10 сарын 20-ноос 2021 оны 1 сарын 25-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

### 1.2 Зорилго, зорилтууд

Энэхүү ОХШҮ-ний ажлын зорилго бол Дорнод аймгийн Жэндэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн 2018-2020 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хэрэгжилтэнд үнэлгээ хийхэд оршино.

**Зорилт 1**: Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн ажил олгогч болон ажиллагсдын ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг болон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, ажлын байрны нөхцөл байдлыг тодорхойлох

**Зорилт 2** Эрэгтэйчүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг тодорхойлох

**Зорилт 3** ОХШҮ-ний ажлын тайлан, бодлогын зөвлөмжийг орон нутгийн удирдлагад хүргэх, зохих шийдвэр гаргуулахад нөлөөлөх

### 1.3 ОХШҮ-ний хамрах хүрээ

*Орон нутгийн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн үйл ажиллагааны ОХШҮ-г хийх чиглэл:*

2019 онд хувийн компаний эзэмшил газарт түрээсээр хөдөлмөр эрхэлж буй 200 иргэдээс санамсаргүй түүврийн аргаар авсан асуулга судалгаа, 65 иргэдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлага, 15 хүнтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагад оролцогчдын зүгээс эрүүл ахуй, ажлын байрны шаардлага хангаагүй, стандартын бус барилга байгууламжинд үйл ажиллагаа явуулах, нөхцөл байдлаа сайжруулах талаар тавьсан саналыг хүлээж авдаггүй, бүдүүлэг үг яриагаар доромжлох, түрээслэгч нарын зүгээс шаардлага тавихад хувийн өмчийг хураан авч лангуу чөлөөлүүлэх зэрэг зөрчлүүд байгааг илрүүлсэн байна. (ИНБЗ-Дорнод, 2019). Дорнод аймгийн төвийн 9 сургууль, 5 цэцэрлэгийн 210 багш ажилтан хамрагдсан "Ажлын байран дахь хүний эрхийн зөрчил" судалгаанд хамрагдсан төрийн үйлчилгээний албан хаагчдын 51 хувь нь

ямар нэгэн байдлаар ажлын байрны дарамтад өртдөг, 64.5 хувь нь байгууллага дээрээ ажилтан албан хаагчдын сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөх удирдах ажилтны дарамт байдаг, үүнд илүү өртдөг гэж хариулжээ. Байгууллагын ажилчдын эрх зөрчигдөх нь хүний эрхэд хамаарах асуудал мөн гэж 62.2 хувь нь үзжээ. (ЛЭОС-Дорнод, 2018). Иймээс төр, хувийн хэвшлийн байгуулагуудад ажлын байран дахь хөдөлмөрийн харилцаа, хүний эрхийн зөрчлийг арилгах цаашдын хэрэгцээг бодитойгоор тодорхойлох нь чухал байна.

Дорнод аймгийн хувьд 2012-2016 оны хооронд эрэгтэй хүний дундаж нас 2.86 насаар, эмэгтэй хүний нас 2.95 насаар тус тус нэмэгдсэн байна. 2016 оны байдлаар эмэгтэйчүүдийн дундаж наслалт улсын дунджаас 2.15 насаар бага, эрэгтэйчүүдийн дундаж нас 0.85 насаар бага байсан байна. Шинээр хорт хавдраар өвчлөгчид 2016 онд 165 тохиолдол байгаагийн 101 нь эрэгтэй буюу 84,7 хувь, хорт хавдраар нас барагчид 160 тохиолдол байгаа нь нийт нас баралтын 28.4 хувийг, хорт хавдраар нас барсан хүний 61.8 хувь нь эрэгтэйчүүдийн нас баралт эзэлж байна. 10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчид 227.4 байгаа нь улсын дундажтай харьцуулахад 104,1-ээр зөрүүтэй байна. (ИНБЗ, 2017). Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үзүүлэлт бүхий эдгээр тоо баримтууд нь эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудал орон нутгийн жендэрийн тулгамдсан асуудлуудын нэг болсон байгааг харуулж байна.

Орон нутгийн түвшинд ИНБ-уудын хийсэн тоон болон чанарын судалгааны үр дүн, Үндэсний статистик тоон үзүүлэлтэд тулгуурласан шинжилгээ зэрэг нь ОХШҮ-г хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн ажил олгогч болон ажиллагсдын ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг; Жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, төсөвлөлт болон ажлын байрны нөхцлийг тодорхойлох; Эрэгтэйчүүд судлал, эрэгтэйчүүдэд үзүүлэх цогц үйлчилгээний өнөөгийн байдлыг тодорхойлоход чиглүүлсэн.

***ОХШҮ-ний чиглэлийн хүрээнд дэвшүүлсэн асуудал:***

**Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн ажил олгогч болон ажиллагсдын ЖЭТБ- ын талаарх ойлголт мэдлэг болон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, төсөвлөлт болон ажлын байрны нөхцлийг тодорхойлох**. (Хувийн хэвшлийн байгууллагын ажил олгогч нар бизнесийн ашиг орлого олохыг чухалчилж, ажил хөдөлмөр эрхэлж буй ажилтнуудын ажиллах нөхцөл, эрүүл мэндийн асуудлыг хайхарч үзэхгүй байна. Иймээс тэдний жендэрийн талаарх ойлголт мэдлэг, хандлага, ямар байгаа болон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, төсөвлөлтийг ажлын төлөвлөгөөндөө тусгадаг эсэх талаар мэдээлэл авах шаардлагатай байна).

**Эрэгтэйчүүд судлал, эрэгтэйчүүдэд үзүүлэх цогц үйлчилгээний өнөөгийн байдлыг тодорхойлж гаргах**. (Эрэгтэйчүүдийн ихэнх хувь нь эмнэлгийн анхан шатны эмчилгээ үйлчилгээ авч чадахгүй, өвчнөө хүндрүүлж ирснээс болж чимээгүйгээр эрт нас баралтанд өртөж байгаа нь нууц биш юм. Эрэгтэйчүүд хүнд хүчир ажил эрхлэх, стресс болон сэтгэл гутралд орох, архи тамхи хэтрүүлэн хэрэглэх, хоол хүнсний зохисгүй хэрэглээ, хөдөлгөөний хомсдолд орох, өвчин эмгэгээ нуух, үзлэг шинжилгээнд үл хамрагдах зэрэг олон хүчин зүйлүүдээс шалтгаалан өвчилдөг.

Эрэгтэйчүүдийн хөгжлийн талаар төрийн нэгдсэн бодлого байхгүй, эрэгтэйчүүд өөрийнхөө эрхийн төлөө тэмцэх мэдлэг, идэвх санаачлага сул, хувь заяатайгаа эвлэрэх хандлага давамгайлсан зэргээс болж эрэгтэйчүүдийн үнэлэмж жилээс жилд буурч биеийн эрүүл мэнд болон оюун санааны хөгжил доройтож байна.

Ажил хөдөлмөр эрхлээгүй, архи тамхи хэтрүүлэн хэрэглэдэг, өвчин эмгэгтэй, гэмт хэрэг зөрчилд холбогдсон, гэр бүл нь салж сарнисан эрчүүд олширч байгаа нь өнөөгийн нийгмийн эмгэнэл болж байна. “Нөхөн үржихүйн асуудал” гэдэг сэдэвт эмэгтэйчүүдийг илүү анхаарч эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд гэдэг үгийг сонсож хэвшээгүй, энэ талаар зөвлөгөө мэдээлэл өгөх, үзлэг шинжилгээ хийх нөхцөл бүрдээгүй, эрэгтэйчүүдийн эмч, эмнэлэг, кабинет

орон нутагт дутагдалтай байна. Мөн эрэгтэйчүүдийн өвчлөлд зүрх судасны эмгэгүүд, элэг, уушиг, хавдар, осол гэмтэл илүү их байна. Иймээс эрэгтэй эмэгтэй хүмүүсийн тэгш боломж, эрхийг хангахын тулд тэдний хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэж, эрэгтэйчүүд судлалыг хөгжүүлэх, жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, төсвийг цаг алдалгүй хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна).

***ОХШҮ-ний хамрах хүрээ ЖЭТБХ дэд хөтөлбөртэй уялдаж буй байдал:***
Дорнод аймгийн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн зорилтуудад дараах арга хэмжээнүүд туссан байна. Үүнд:

- нэг, гуравдугаар зорилтуудад “Орон нутгийн хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дахь хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлын тухай мэдлэг, хандлага, түүнийг хангаж буй өнөөгийн байдал, Хувийн хэвшил, аж ахуйн нэгж байгууллагын дотоод журам, хамтын гэрээ болон хөдөлмөрийн гэрээний ЖЭТБХ хангаж буй байдлыг тодорхойлно;
- гуравдугаар зорилтод “Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн онцлог хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн төрөөс үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмж, Эрэгтэйчүүдийн дунд зонхилон тохиолдож буй өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг илрүүлнэ” хэмээн заасан байна.

Орон нутгийн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн нэг, гуравдугаар зорилтуудад туссан тулгамдаж буй асуудлын хүрээнд ОХШҮ-ний ажлыг чиглүүлж хөтөлбөрийн хэрэгжилтийн бодит байдалд шинжилгээ хийхийг зорьж ажилласан.

## ХОЁР. ОРОЛЦООНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

ОХШҮ-ний зорилго, зорилтын хүрээнд орон нутгийн жендэрийн тулгамдсан хоёр асуудлыг тодорхойлохдоо баримт бичгийн шинжилгээ, асуулгын арга, чанарын судалгааны арга /Бүлгийн ярилцлага болон ганцаарчилсан ярилцлага/, ажиглалтын аргуудыг ашигласан.

### 2.1 Мэдээлэл цуглуулах аргууд

*2.1.1 Баримт бичигт дүн шинжилгээ хийх арга:*

**Зорилго**: Орон нутагт хэрэгжиж буй хууль тогтоомж, бодлогын баримт бичиг болон төрийн байгууллага болон хувийн хэвшлийн байгуулагуудын дүрэм, журам, тайлан мэдээнд жендэрийн эрх тэгш байдал хангагдаж буй байдлыг тодорхойлно. ОХШҮ хийх хоёр асуудалд хамаарах дараах баримт бичгүүдэд агуулгын болон гүйцэтгэлийн нөхцөл байдалд шинжилгээ хийв. Үүнд:

1. Захиргааны хэм хэмжээний акт, бичиг баримт [код-2]
    - *1.1.* ЖЭТБХ дэд хөтөлбөр;
    - 1.2. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2018-2020;
    - 1.3. Хөтөлбөрийн санхүүгийн тайлан;
    - 1.4. Аймгийн ИТХ-ын нийгмийн чиглэлийн хөтөлбөрүүдэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, 2018-2020;
    - 1.5. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын тайлан: 2018,2019 оны ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэнд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний тайлан;
    - 1.6. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэнд хийсэн хөндлөнгийн үнэлгээний тайлан, 2018-2020;
    - 1.7. Засаг даргын мөрийн хөтөлбөрийн биелэлт 2016-2020 он
    - 1.8. Аймгийн 2018, 2019 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт;
2. Байгууллагын дүрэм, журам, тайлан [код-3]

2.1. ЭМГ, БОЭТ-н жилийн ажлын төлөвлөгөө, тайлан мэдээ (2018-2020 он);
2.2. Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн талаарх мэдээлэл (2018-2020 он);
2.3. Хувийн хэвшлийн болон ААН, байгууллагын дүрэм, дотоод журам, төлөвлөгөө, хүйсийн тэнцвэртэй байлын тухай тайлан (2018-2020 он);
2.4. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан талаарх тайлан, мэдээ;
2.5. “Аз жаргал” төвийн үйл ажиллагаа, төсвийн тайлан мэдээ;
2.6. Өргөдөл гомдол шийдвэрлэсэн мэдээлэл (Аймаг, сумын ИТХ-ын нутгийн удирлага, өргөдөл. гомдол, хяналт үнэлгээний бодлогын хороо, аймаг, сумын ЗДТГ, ХЭҮК-ийн аймгийн салбар зөвлөл, аймгийн ҮЭХ, аймгийн Ажил олгогчдын эздийн холбоо);
2.7 Ажлын байран дахь хүний эрхийн зөрчлийг шийдвэрлэсэн талаарх мэдээлэл. (Хууль хяналтын байгууллага);

3. Тайлан мэдээ
3.1. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн тайлан-2018, 2019, 2020. (ЗДТГ-н НБХ-ийн Жендэрийн салбар хороо)
3.2. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн тайлан. (ЗДТГ-н НБХ)
3.3.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан. (2018-2020. ГБХЗХГ);

Хүснэгт 1. Баримт бичиг судлах аргаар цуглуулсан мэдээллийн хүрээ.

| ОХШҮ-ний чиглэл | ОХШҮ-ний чиглэлийн хүрээнд илрүүлэх асуулт | Судлах баримт бичиг, эх сурвалжуудын код |
|---|---|---|
| Асуудал 1: Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн ажил олгогч болон ажиллагсдын ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг болон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, ажлын байрны нөхцөл байдлын өнөөгийн байдлыг тодорхойлох | | |
| ЖЭТБ-ын талаарх мэдлэг, хандлага | •Байгууллагын дүрэм журам жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт<br>•Ажлын байрны нөхцөл ба жендэрийн тулгамдсан асуудал | 2.1-2.8<br>3.3<br>3.6<br>3.7 |
| Асуудал 2: Эрэгтэйчүүд судлал, эрэгтэйчүүдэд үзүүлэх цогц үйлчилгээний өнөөдрийн түвшинг тодорхойлох. | | |
| Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн нийгмийн үйлчилгээг тэгш, хүртэх боломжийг нэмэгдүүлэх | •Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үзүүлэлт, тулгамдсан асуудал<br>•Эрэгтэйчүүдэд зориулсан нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж | 2.1-2.8<br>3.1<br>3.2<br>3.4<br>3.5 |

*2.1.2. Асуулгын арга*

ОХШҮ-ний ажил нь ЖЭТБХ дэд хөтөлбөрийн зорилтуудын хүрээнд дэвшүүлсэн үйл ажиллагааны өмнө тулгамдаж буй тодорхой асуудлын түвшинг тодорхойлох зорилготой хоёр өөр агуулга бүхий санал асуулгын хуудас боловсруулсан. Үүнд:

- Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн ажил олгогч болон ажиллагсдын ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг болон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, ажлын байрны нөхцлийг илрүүлэхийн тулд “Хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжийн хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөдөлмөрийн харилцаа нь жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байж, ажлын байранд жендэрийн эрх тэгш байдал хангагдаж буй

байдлыг үнэлэн тодорхойлох зорилго бүхий 24 асуултын хүрээнд мэдээлэл цуглуулсан байна.

Анкетын судалгааны асуулт нь жендэрийн тухай мэдлэг, хандлага, байгууллагын хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдал, орон нутгийн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн тухай ойлголт, хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай, хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн харилцаанд гарч буй жендэрийн тулгамдсан асуудлыг хэрхэн шийдвэрлэх санал санаачилгуудыг тодорхойлох чиглэлийн асуултууд байв.

- Эрэгтэйчүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг зорилтот бүлгээр үнэлүүлж жендэрийн тулгамдсан асуудлыг тодорхойлох зорилготой 31 асуултаар мэдээлэл цуглуулсан байна. Эдгээр асуултуудыг чиглэлээр нь авч үзвэл жендэрийн тухай мэдлэг, хандлага, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдал, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж, сэтгэл ханамж, орон нутгийн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн тухай ойлголтыг тодорхойлоход чиглэсэн байна.

*2.1.3.Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага:*

Хувийн хэвшлийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдийн удирдах ажилтан, ажилчдын ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг болон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, ажлын байрны нөхцөл байдал, эрэгтэйчүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн тухай фокус бүлгийн хэлэлцүүлэг болон ганцаарчилсан ярилцлага хийж, асуудлын учир шалтгаан, түүнийг шийдвэрлэх боломжуудын талаар тодруулан судалсан.

Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагын хүрээнд төрийн албан хаагч, ИНБ, иргэдийн төлөөлөл 46 иргэд 23 удаагийн ярилцлагаар 30 асуултын хүрээнд мэдээлэл солилцож асуудлаа хамтдаа тодорхойлсон байна. ОХШҮ-ний сонгож авсан хоёр асуудлын хүрээнд ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагыг зохион байгуулахдаа төрийн бодлого, үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлыг харилцан ярилцлаа. Мөн ярилцлагын үеэр сонгож авсан сэдэв, асуудлыг хэлэлцэх шаардлагатай тулгамдсан асуудал хэмээн үзэж санал солилцон, тодорхой шийдвэрүүдэд санал нэгдлээ.

Тухайлбал уул уурхайн салбарын байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд ЖЭТБХ, ялгаварлан гадуурхалтыг арилгах, хүний эрхийн зөрчлийг бууруулахад чиглэсэн үнэлгээний ажил болон зөвлөн туслах үйлчилгээг төр, ИНБ болон бусад хүний эрхийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх, эрэгтэйчүүдэд чиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад төр, олон нийтийн дэмжлэгийг авах боломжтой гэж үзсэн байна.

## 2.2 Түүвэрлэлт

Зорилтот түүврийн аргачлалыг ашиглан анкетын аргаар мэдээлэл цуглуулж, ярилцлагуудыг зохион байгууллаа.

**Хүснэгт 1. Түүврийн хэмжээ.**

| | Сонгосон эх сурвалжууд |
|---|---|

| Сонгосон аргууд | 1. Аймгийн ИТХ | 2. Аймгийн ЗДТГ-ын харьяа байгууллагын удирдлага, мэргэжилтэн | 3.БОЭТ ЭМГ Хувийн эмнэлэг | 4. Хүний эрхийн байгууллагууд | 5. Хувийн хэвшил, Аж ахуйн нэгж | 6. Иргэд, олон нийт | Бүгд |
|---|---|---|---|---|---|---|---|
| Асуулга | | | | | | 219 | 219 |
| Ганцаарчилсан ярилцлага | 2 | 4 | 5 | 2 | 3 | 4 | 20 |
| Бүлгийн хэлэлцүүлэг | 2 | 2 | 2 | 1 | 6 | 9 | 22 |
| Нийт | 4 | 6 | 7 | 3 | 9 | 232 | 261 |

*График 1. Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцаа /хувиар/*




Тоон болон чанарын судалгаанд нийт 261 хүн оролцсон бөгөөд үүний 61.7 хувь нь эрэгтэй, 38.3 хувь нь эмэгтэй хүйсийн төлөөлөл байна. Анкетын аргаар 219 хүнээс мэдээлэл цуглуулсан бөгөөд үүний 38.3 хувь нь эмэгтэй, 61.6хувь нь эрэгтэй; ганцаарчилсан ярилцлагад 20 хүн хамрагдсанаас 45 хувь нь эмэгтэй, 55хувь нь эрэгтэй; бүлгийн ярилцлагад 26 хүний 24.1хувь нь эмэгтэй, 75.8хувь нь эрэгтэйчүүд байлаа.

### 2.3 Мэдээлэл цуглуулалтын үйл ажиллагаа

**Хүснэгт 3. Мэдээлэл цуглуулах үйл ажиллагааны төлөвлөлт.**

| № | · Үйл ажиллагаа | Хугацаа | Хариуцах эзэн |
|---|---|---|---|
| 1 | ЖЭТБ-ыг хангах ажиллагааг зохицуулж буй хууль, хөтөлбөр, бодлогын бичиг баримт, тайлан мэдээг олох, цуглуулах, анализ хийх | 2020.11.25-12.05 | ОХШҮ-ний баг |
| 2 | Хувийн хэвшлийн байгууллага болон эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудалтай холбоотой бичиг баримт, тоон мэдээлэл авах талаар холбогдох байгууллагуудад бичиг явуулах, хариу авах | 2020.11.25-12.01 | ОХШҮ-ний баг |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | Судлах асуудлуудын шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах, асуулга судалгааны асуумжийг боловсруулах, урьдчилсан асуумж (pre-test) авч сайжруулах, багийн гишүүдэд танилцуулах, батлах | 2020.11.25-12.01 | ОХШҮ-ний баг |
| 4 | Асуулга судалгаа авах хүмүүст зааварчилгаа өгөх, урьдчилсан байдлаар судалгаа авч үзэх | 2020.11.25-28 | ОХШҮ-ний баг |
| 5 | Асуулга судалгаа авах /Сонгогдсон иргэдээс/ | 2020.12.01-12.10 | ОХШҮ-ний баг |
| 6 | SPSS-д мэдээллийг оруулах, Судалгааны дүнг нэгтгэх | 2020.12.10-12.20 | ОХШҮ-ний баг |
| 7 | Чанарын судалгааны удирдамж боловсруулах, бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын чиглэл, асуултууд боловсруулах | 2020.11.17-11.23 | ОХШҮ-ний баг |
| 8 | Ганцаарчилсан ярилцлагуудыг хийх талаар албан бичиг явуулах эсвэл утсаар хугацаар товлох, ярилцлага хийх хүмүүсийг тодорхойлох, ярилцлага авах гишүүдэд зааварчилгаа өгөх | 2020.11.23-11.25 | ОХШҮ-ний баг |
| 9 | ОХШҮ-ний багийн гишүүдээс санал авах, Чанарын судалгааны чиглэл, асуултуудыг эцсийн хувилбараар боловсруулах | 2020.11.21-23 | ОХШҮ-ний баг |
| 10 | Ярилцлага, бүлгийн хэлэлцүүлгийг хийх, баримтжуулах /диктофонд бичих, фото зураг авах | 2020.11.25-12.15 | ОХШҮ-ний баг |
| 11 | Судалгааны мэдээлэл цуглуулах, шивэх | 2020.11.25-12.15 | ОХШҮ-ний баг |
| 12 | Чанарын судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийх, нэгдсэн тайлан бичих | 2020.12.20-12.30 | ОХШҮ-ний баг |

#### *2.3.1 Судалгааны ёс зүйн хэм хэмжээ*

Судлаач нь судалгааны ёс зүйн хэм хэмжээний үндсэн зарчмуудыг баримтлах ба судалгаанд оролцогчдын өмнө болон судалгааг санхүүжүүлэгчдийн өмнө хариуцлага хүлээнэ.

1. Судалгаанд оролцогчдод хохирол учруулахгүй байх: Бидний хийж буй энэхүү судалгаанд оролцогчдын тусын тулд ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үр нөлөөг сайжруулах хүрээнд хийгдэх бөгөөд судалгааны явц, үр дүн нь оролцогчдыг биеийн болоод сэтгэл зүйн эрсдэлд оруулахгүй байхаар зохион байгуулна.

2. Судалгаанд оролцогчид сайн дураараа оролцох:

Судалгаанд оролцогчид бусдын эрхээр биш сайн дураараа оролцох ба ямар судалгаанд, яагаад оролцох болсныг нь дэлгэрэнгүй тайлбарлаж өгнө. Зорилтот бүлгийн иргэдээс судалгаа авахдаа заавал хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс зөвшөөрөл авна.

3. Судалгаанд оролцогчдын талаарх судалгааны нууц: Судалгаанд оролцогчийн нэр төр, эрхийг хамгаалах үүднээс зохих боловсруулалт хийхээс өмнө судалгааг эрхлэн гүйцэтгэж байгаа хүмүүсээс өөр бусад хүмүүст судалгааны нарийн мэдээллийг өгөхгүй. Судалгаанд оролцогчийг хүндэтгэн нэрийн нууцлалыг хадгална.

### 2.4 Зөвлөлдөх уулзалт

#### *2.4.1 Зөвлөлдөх уулзалт -1*

ОХШҮ-НИЙ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛЫГ ТАНИЛЦУУЛАХ

Дорнод аймгийн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд ОХШҮ хийх үйл явцын талаарх мэдээллийг оролцогч талуудад танилцуулах зорилгоор цахим зөвлөлдөх уулзалтыг 2020.11.21-ны өдөр амжилттай зохион байгууллаа.

Зөвлөлдөх уулзалтыг орон нутгийн ОХШҮ-ний багийн гишүүд зохион байгуулж зочин оролцогчоор ОХШҮ-Жендэрийн зөвлөх багийг төлөөлж Т.Бүрэнжаргал, Ц.Одгэрэл багш нар, урилгаар аймгийн нутгийн удирдлага, төрийн захиргаа, хүний эрхийн байгууллага, ОУ-ын төсөл хөтөлбөрийн нэгж, уул уурхай, нийтийн хоол, хүнсний худалдаа үйлчилгээний хувийн хэвшил, аж ахуйн нэгж байгууллага, ИНБ, иргэдийг төлөөлсөн 40 хүн хамрагдсан байна.

ОХШҮ-ний чиглэсэн асуудлын талаар харилцан санал солилцох, үнэлгээний арга зүйд оролцогчдын саналыг тусгах зорилгоор 2 бүлэгт хуваагдан тус тусдаа цахим өрөөнд хэлэлцүүлгийг өрнүүллээ. Үүнд:

I бүлгийн өрөөнд: (Чиглүүлэгч Д.Бужин)

- Оролцооны хяналт шинжилгээ үнэлгээний ажлын зорилго, зорилтын хүрээнд тодорхойлсон асуудал орон нутгийн жендэрийн тулгамдсан асуудал болох талаар;
- Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн ажил олгогч болон ажиллагсдын ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг болон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, ажлын байрны нөхцөл байдлыг тодорхойлох арга зүй, аргачлалын талаар;

II бүлгийн өрөөнд:(Чиглүүлэгч Б.Оюун-Эрдэнэ)

- Эрэгтэйчүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг тодорхойлох нь орон нутгийн жендэрийн тулгамдсан асуудал болох талаар;
- Эрэгтэйчүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг тодорхойлох арга зүй, аргачлалын талаар оролцогч бүр саналаа хэлж бүтээлчээр оролцлоо.

Бүлгийн хэлэлцүүлгийн дараа оролцогчид нэг өрөөнд дахин цугларч шийдвэрүүдээ танилцуулснаар ОХШҮ-ний чиглэсэн асуудал нь орон нутагт жендэрийн тулгамдсан асуудал гэдгийг санал нэгтэйгээр хүлээн зөвшөөрч, үнэлгээний арга зүйн хэсэгт дараах саналуудыг өгсөн байна. Үүнд:

Хувийн хэвшлийн байгууллагад ажиллаж буй иргэдэд жендэрийн тухай ойлголт мэдлэг олгох сургалт, мэдээллийн үйл ажиллагаа хангалтгүй хийгддэг, хувийн хэвшилд ажил олгогч, ажилтны хооронд хийсэн хөдөлмөрийн гэрээнд ажил олгогчийн эрх ашгийг хамгаалсан заалтууд илүү тусдаг, ажлын байрны нөхцөл болон хөдөлмөрийн харилцааны талаар санал гомдол, өргөдөл шийдэгдэхгүй байх, шүүмжлэл, санал гомдол гаргаснаар ажилтан хохирох, ажлын байранд хүйсийн тэнцвэрт байдлыг хадгалах, орон нутгаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх явцад хойрго ханддаг, ажилтан авахдаа шаардлагагүй тохиолдолд хүйс зааж байгаа нь жендэрийн асуудал хөдөлмөрийн харилцаанд байна гэж үзэж байв.

Иймд хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад жендэрийн эрх тэгш байдлын талаар сургалт, мэдээллийн ажиллагааг зохион байгуулах хэрэгтэй байна.

Энэ талаар сургалт, мэдээллийн ажиллагааг өөрийн байгууллагадаа авах саналыг оролцогчид төслийн багт тавьсан байна.

Хоёрдугаар асуудлын хүрээнд судалгааны түүвэрт малчин эрэгтэйчүүд, өсвөр насны хөвгүүдийг хамруулах, цаг үеийн нөхцөл байдалтайгаа уялдуулан цахим орчинд судалгаанд хамрагдах, хамтран ажиллахад бэлэн байгаа тухайгаа илэрхийлж, төслийн багийн гишүүдээс өгсөн мэдээллийг ач холбогдолтой байж чадлаа гэж үнэлсэн. Зөвлөлдөх уулзалтад аймгийн ИТХ-ын 3 төлөөлөгч оролцсон бөгөөд ОХШҮ-ний үр дүнг ИТХ-д танилцуулах нь зүйтэй гэсэн саналыг тавьсан байна.

### *2.4.2 Зөвлөлдөх уулзалт-2*

"ОРОЛЦООНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ"-НИЙ ҮР ДҮН ТАНИЛЦУУЛАХ

"Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн дунд хугацааны явцад хийсэн "Оролцоот хяналт шинжилгээ үнэлгээ"-ний ажлын үр дүн танилцуулах "Зөвлөлдөх уулзалт"-ын ажиллагааг ОХШҮ-ний багаас 2021 оны 02-р сарын 05-ны өдөр зохион байгуулсан. Зөвлөлдөх уулзалтанд Төр, хувийн хэвшил болон ААН, ИНБ-уудын төлөөлөл болох 20 хүн оролцлоо. Зөвлөлдөх уулзалтын зорилго, хөтөлбөр болон төслийн талаар ЛЭОС-ийн Дорнод аймаг дахь салбар зөвлөлийн тэргүүн Д.Бужин танилцуулга хийсэн.

Оролцоот хяналт шинжилгээний үр дүнгийн талаар ЛЭОС-ийн Дорнод аймаг дахь салбар зөвлөлийн тэргүүн Д.Бужин, Оролцоот үнэлгээний үр дүнгийн талаар "Талын сувдан гүүр" ТББ-ын тэргүүн Б.Оюун-Эрдэнэ нар тус тус танилцуулж оролцогчдын асуусан асуултанд хариулсан. Уулзалтын төгсгөлд ОХШҮ-ний ажлын үр дүнд үндэслэн гаргасан "Зөвлөмж"-ийг танилцуулж хэлэлцүүлэг өрнүүлсэн. Зөвлөлдөх уулзалтанд оролцогчдоос доорхи санал, хүсэлтүүдийг гаргасан. Үүнд:

- Хувийн хэвшлийн байгууллага бүх үйл ажиллагаандаа жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлтийг хийж хэрэгжүүлэх
- Аж ахуйн нэгж болон хувийн хэвшлийн байгууллагуудын ажилтнуудтай сургалт мэдээллийн ажиллагаа хамтарч зохион байгуулах
- Жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлтийг байгууллагууд хэрэгжүүлэх
- Боловсролын газрынхан гэхэд үндсэн ажлаа хийхээс гадна багш нар давхар олон ажил хийдэг учир жендэрийн чиглэлээр сургалт мэдээллийн ажиллагаа зохион байгуулсан урамшуулал, хөшүүргийг сайн өгч байх, жендэрийн үндсэн ойлголтыг мэдэж байгаа боловч хэрэгжүүлэх арга зүй дутаад байна. 3-4 хүнтэй баг үүсгээд зөвөлгөө, мэдээлэл өгч ажиллах
- Зөвлөмжинд хөтөлбөрийн явцад хийсэн ажлын талаар товч мэдээлэл оруулах
- Ямар байгууллага, хувь хүнд юуг чиглүүлэх гэж байгаа талаар тодорхой болгох
- Иргэд рүү мэдээлэл түгээх
- Эрэгтэйчүүдийн кабинет, мэргэшсэн эмчийн асуудлыг шийдвэрлэх
- Жендэрийн 8 модульт сургалтыг түгээн дэлгэрүүлж үргэлжлүүлэх ажлыг урамшуулалгүйгээр хийх боломжгүй юм, цаашид энэ тал дээр анхаарч төсвийг тооцох
- Хувийн хэвшлийн байгууллагад удирдах ажилтан нарт нөлөөллийн үйл ажиллагаа явуулах
- Зарим байгууллагын хувьд ажлын онцлогоос болж эр, эм гэж хүйс заах тохиолдол их гарч байна, үүнд уян хатан хандах
- Албан газар ажилладаг эцэг, эхчүүдийн мэдлэг арай өөр байна. Албан газаргүй, ажилгүй эцэг, эхчүүд, иргэдэд жендэрийн талаар мэдээлэл, ойлголтыг сайн өгөх хэрэгтэй байна. Үүнийг админаар дамжуулж мэдээлэл түгээх
- Жендэрийн статистик мэдээлэл их дутмаг байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хүйсийн ялгааны талаар мэдээлэл байдаггүй. Ямар үзүүлэлтийг жендэрийн мэдрэмжтэй гэж статистик үзүүлэлтэнд оруулах вэ? гэдгийг тодорхойлох
- Байгууллагууд дээр жендэрийн асуудал хариуцсан дагнасан мэргэжилтнүүд байдаггүй, ажлынхаа хажуугаар хийсэн болж байгаа. Энэ байдал нь жендэрийн хөтөлбөр үр дүнтэй хэрэгжихэд их нөлөөлж байна. Иймээс зохицуулалт хийх талаар зөвлөмжид тусгах
- 2016 оноос жендэрийн асуудал яригдаж ирсэн. Энэ чиглэлээр төслийн хүрээнд 10 сургагч багш бэлтгэгдсэн. 2019 онд үнэлгээ хийсэн. Түгээн дэлгэрүүлэлт хангалтгүй байгаа тул энэ ажлыг эрчимжүүлэх

- ЖЭТБХ хөтөлбөрийн хэрэгжилт хангалттай гэж үзэж байна. Орон нутгийн ИНБ-уудын төслийн багаас ОХШҮ-ний ажлыг сайн хийсэн байна.

**Зөвлөлдөх уулзалтанд оролцогчдоос:**

Цаашид хувийн хэвшлийн болон аж ахуйн нэгж байгууллагын удирдах ажилтан болон ажиллагсдын жендэрийн талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, байгууллагын хөгжлийн төлөвлөгөө, дотоод журам, хүний нөөцийн бодлого хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэхэд жендэрийн мэдрэмжтэй үзэл баримтлалыг нэвтрүүлэх ажлыг “ЖЭТБ-ыг хангах дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажиллах,

“Эрэгтэйчүүдийг хамгаалах дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж ажлын хэсгээр хэлэлцүүлэх, холбогдох зардлыг Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар батлуулах ажлыг хийх хэрэгтэй болохыг хэлэлцэж санал гаргасан.

## ГУРАВ. ОРОЛЦООНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

ЖЭТБХ дэд хөтөлбөрөөр шийдэх асуудлууд болон ЖЭТБХ дэд хөтөлбөрт тусгагдсан асуудлыг хэрхэн шийдвэрлэхээр төлөвлөсөн тухай, ЖЭТБХ-ийн оролцогчид, үр шим хүртэгчид хэн болохыг тодорхойлох, ЖЭТБХ -ийг хэдий хугацаанд, ямар эх үүсвэрийн хэдий хэмжээний төсөв, хөрөнгө зарцуулж хэрэгжүүлэх, ЖЭТБХ -ийн хэрэгжилтийг хэн хангаж ажиллах, ЖЭТБХ-ийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээг хэрхэн хийх, ЖЭТБХ -ийг хэрэгжүүлэхээр хэдий хугацаанд ямар, ямар үйл ажиллагааг төлөвлөсөн талаар, зорилт, үйл ажиллагааны чиглэл, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүний шалгуур үзүүлэлтийн хоёр үе шатны зураглал гаргах, “ЖЭТБХ-ийг батлагдсанаас хойш хэрэгжүүлсэн үйл ажиллагаа”, “ЖЭТБХ-т ОХШҮ хийхэд чиглэх асуудал, анхаарал татаж буй асуудлууд”-ыг тус тус тодорхойлсон.

### 3.1. ОРОЛЦООНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Төр, ИНБ-ууд хамтран боловсруулсан “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах” дэд хөтөлбөрийг Дорнод аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан.

Орон нутагт жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн зорилтуудыг хангахад Канадын Засгийн Газрын Мэрит төсөл, НҮБ-ын Хүн амын сан, Хүний эрхийн үндэсний комисс зэрэг олон улсын байгууллагууд болон ИНБ-ууд хувь нэмрээ оруулж, идэвхтэй хамтран ажилласан байна. (ЗДТГ, 2019)

ОХШҮ-ний ажлын үр дүнг ЖЭТБХ дэд хөтөлбөрийн зорилт түүний хэрэгжилттэй харьцуулан бичих тул дэд хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны чиглэлийн матрицыг харуулж байна.

Хүснэгт 4. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн зорилт ба үйл ажиллагааны чиглэл

| ЗОРИЛТУУД | ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА |
|---|---|
| **Зорилт 1:** Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх | 1. Сургуулийн өмнөх насны хүүхдийн хүчирхийлэлгүй орчинг дэмжих, хүүхэд, өсвөр нас, оюутан залуус, гэр бүлд жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах;<br>2. “Аз жаргал төв”, гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийн сургалт, зөвлөн туслах үйлчилгээнд жендэр судлал, нөхөн үржихүй, эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, гэр бүл судлал, охид эмэгтэйчүүдийг хүний наймаа, бэлгийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх сургалт судалгаа, нөлөөллийн үйл ажиллагааг тусгах; |

| | |
|---|---|
| | 3. Орон нутгийн төрийн удирдах албан тушаалтан, төрийн албан хаагчид болон аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд зориулсан жендэрийн сургалтуудыг зохион байгуулах, орон нутгийн сургагч багш нарыг чадавхжуулах<br>4. Орон нутгийн иргэдийн амьжиргаа, хүний хөгжлийг тодорхойлдог шалгуур үзүүлэлтүүдийн талаарх төрийн байгууллагууд болон олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлж, хэрэглээ болгох ажлуудыг зохион байгуулах,<br>5. Бүх нийтийн жендэрийн мэдлэгийг нэмэгдүүлэхэд орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах |
| **Зорилт 2:**<br><br>Төр, Иргэний нийгмийн байгууллагын түншлэлийн хүрээнд орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжсэн жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсөвлөлтийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх | 1. Аймгийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд нь салбар бүртээ, зүүн бүс аймаг, орон нутгийн урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, салбарын жендэрийн нэгдсэн бодлого, үндэсний болон орон нутгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй болох<br>2. Аймаг, сумын хөгжлийн бодлого, байгууллагуудын хөгжлийн төлөвлөгөө, байгууллагын дотоод журам, хүний нөөцийн бодлого, хөтөлбөр, төслийг жендэрийн мэдрэмжтэй үзэл баримтлалыг нэвтрүүлэх,<br>3. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах байрны үйл ажиллагааг чанаржуулж, жендэрт суурилсан хүчирхийллийн бүх хэлбэрт өртсөн хохирогчдын тоог эрс бууруулах<br>4. Аймаг сумын хэмжээнд ажиллах эрүүл мэнд-сэтгэл зүй-эрх зүйн зөвлөгөөг өгөх бүтэц, гэр бүл судлаач, сэтгэл зүйч болон хүний нөөцийг бэлтгэх, гэр бүлийн үнэ цэнэ, хамтын амьдралын утга учир, эцэг эхийн хамтын үүрэг хариуцлагыг таниулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ зохион байгуулах<br>5. Орон нутгийн ТББ, Иргэний нийгмийн байгууллагатай хамтран, "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт, ЖЭТБ-ыг хангах үндэсний хөтөлбөр, аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад зөвлөн туслах, сайн туршлагыг түгээх ажлуудыг зохион байгуулах |
| **Зорилт 3:**<br>Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлого, хөтөлбөрт жендэрийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлэх | 1. Үндэсний хөтөлбөрийн хүрээнд улсын хэмжээнд хийгдэх эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсрол, залуу малчдын нөхцөл байдалд хийгдэх жендэрийн судалгаанд тулгуурлаж, эрэгтэйчүүд болон хөвгүүдэд зориулсан кабинетийг байгуулан эрүүл мэндийн үзлэг оношилгоо сэтгэл зүйн зөвлөгөө болон бусад үйлчилгээг нэмэгдүүлэх<br>2. Залуу гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон эцэг (эх), амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэн, оюутан залууст чиглэсэн жендэрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлж үр дүнг тодорхойлох, нийгмийн салбарын хөтөлбөрүүдийн уялдаа холбоог хангаж ажиллах;<br>3. Уул уурхайн салбар болон улирлын шинжтэй ажил, хөдөлмөр эрхэлж буй иргэдийн эрүүл мэнд, ахуй нөхцөл, гэр бүлийн амьжиргаа, тогтвортой байдалд жендэрийн дүн шинжилгээ хийж, нөхцөл байдлыг сайжруулах зөвлөмжийг оролцогч талуудад өгөх;<br>4. Төр, хувийн хэвшлийн ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгох, эрэгтэй, эмэгтэй ажилтанд адил хэмжээний хөлс олгох, иргэнийг ажилд авахад хүйсээр ялгаварлахгүй байх, ажлын байран дахь хүчирхийллээс сэргийлэх ажлыг Төр, Иргэний нийгмийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;<br>5. Хүн амын нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын талаар орон нутгийн статистик мэдээллийн нэгдсэн санд хүйсээр ангилсан судалгааны нэр төрөл, тоог нэмэгдүүлж, хөгжлийн бодлого төлөвлөлтөнд хэрэглээ болгох |
| Эх сурвалж: Жендэрийн эрх тэгш байдлыг хангах Дорнод аймгийн дэд хөтөлбөр | |

Дээрх зорилт, үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд 2018-2020 онуудад нийт 88.3 сая төгрөг зарцуулсан байна. Энэхүү төсвийг үйл ажиллагааны чиглэл, эх үүсвэрийн хамт хүснэгтээр харуулъя.

**Хүснэгт 5. ЖЭТБХ дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, төсөв. 2018-2020 он**

| № | Санхүүжилтийн нэр төрөл | Төсөв /сая/ | Гүйцэтгэл/хувь/ | Санхүүжилтийн эх үүсвэр |
|---|---|---|---|---|
| 1 | Аз жаргал төвийн үйл ажиллагааны зардал | 37,5 | 100 | Орон нутгийн төсөв |
| 2 | Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааны зардал | 30,5 | 100 | Орон нутгийн төсөв |
| 3 | Хамгаалах байрны үйлчилгээ болон тохижилтын зардал | 4 323 9 | 100 | ОУБ |
| 4 | ЖЭТБ дэд хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ | 16.0 | 100 | Орон нутгийн төсөв |

Эх сурвалж . ГБХЗХ-ын тайлан. 2020.11 сар.

2018-2020 оны хооронд ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн үйл ажиллагааны хэрэгжилтийг төлөвлөлттэй харьцуулсан үр дүнг дараах хүснэгтээр харуулъя.

Хүснэгт 6. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөлт ба хэрэгжилт /оноор/

| Шалгуур | 2018 | 2019 | 2020 | Нийт |
|---|---|---|---|---|
| Төлөвлөж хэрэгжүүлсэн ажил | 7 | 5 | 5 | 17 |
| Төлөвлөсөн болович хэрэгжүүлээгүй ажил | - | - | - | - |
| Төлөвлөөгүй хэрэгжүүлсэн ажил | 5 | 8 | 10 | 23 |
| Бүгд | 12 | 13 | 15 | 40 |

**ЖЭТБХ дэд хөтөлбөрийн Зорилт 1 "Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх" үйл ажиллагааны хүрээнд**:

- 5 үйл ажиллагаа тусгагдсан байгаагаас бага насны хүүхдүүд, ЕБС-ийн сурагчид, оюутан залуус, төрийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтныг чадавхижуулах сургалт, мэдээлэл, хууль сурталчилах, нөлөөллийн үйл ажиллагаануудыг олон улсын төсөл хөтөлбөр болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр хийсэн байна.
- Хувийн хэвшлийн болон ААН байгууллага, иргэдэд зориулсан жендэрийн мэдлэг олгох сургалт, мэдээллийн ажиллагаа огт төлөвлөгдөөгүй тул энэ чиглэлийн ажил хийгдээгүй, төсөв зарцуулагдаагүй байна.
- Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тогтоохдоо хөдөлмөрийн мөлжлөг ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх заалтыг дотоод журамдаа тусгасан аж ахуйн нэгж байгууллагын тоог 35-аас доошгүй байхаар тогтоосон байна.
  Энэ ажлын хүрээнд сумын ЗДТГ, агентлагуудад чиглэл өгч ажилласнаар төрийн 22 байгууллагын дотоод журамд өөрчлөлт орсон тухай ГБХЗХГ-ын тайланд дурьджээ. (ГБХЗХГ, 2020).
- ЖЭТБХ дэд хөтөлбөрийн зорилт түүний үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийн түвшинг хангаж, хувийн хэвшлийн болон ААН байгууллагын удирдах ажилтан, албан хаагчдын жендэрийн талаарх ойлголт мэдлэг, хандлагыг өөрчлөх, хөдөлмөрийн харилцааг жендэрийн мэдрэмжтэй болгоход зөвлөн туслах, мэдээллээр хангах ажлуудыг хийх шаардлагатай байна.

Зорилт 1-ийн хүрээнд тодорхойлсон үйл ажиллагааны чиглэл тус бүрийн хэрэгжилтэд шинжилгээ хийж үзэхэд дараах дүр зураг харагдаж байна. Үүнд:

**Зорилт 1 "Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх"-ийн 3.1.1-д туссан "Сургуулийн өмнөх насны хүүхдийн хүчирхийлэлгүй орчинг дэмжих, хүүхэд өсвөр үе, оюутан залуус, гэр бүлд жендэрт**

**суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулах”- үйл ажиллагааны хүрээнд:**

- “Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг чадвар олгох” сургалтаар 2018-2020 онд ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер, нийгмийн ажилтан, анги удирдсан багш, баг, сумын нийгмийн ажилтан нараас бүрдсэн нийт 98 сургагч багшийг бэлтгэсэн байна. Мөн 2250 хүүхдүүд энэ талын мэдлэг ойлголттой болж сургуулийн орчны хүүхдийн эрхийн зөрчил буурахад нөлөөлж ажилласан байна. “Хүүхэд хамгаалалд-эцэг, эхийн оролцоо” сэдэвт уулзалтаар орон нутгийн 90 гаруй байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх эцэг, эхийн зөвлөлийн 140 гаруй төлөөлөгчдөд арга зүйн зөвлөгөө өгч мөн жендерийн эрх тэгш байдлын талаар мэдээлэл хүргэх зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн тухай ГБХЗХГ-ийн тайланд тус тус өгүүлсэн байна.

- Жендэрийн бэлтгэгдсэн сургагч багш нар жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлага, чадвар олгох сургалтыг түгээн дэлгэрүүлэх ажил хангалтүй хийсэн байна. Тухайлбал: 2019 онд ЕБ-ын 8 сургуулийн 16 сургагч багшийг хамруулсан сургалтын түгээн дэлгэрүүлэлтийн нөхцөл байдалд хийсэн үнэлгээний үр дүнд сургууль тус бүрт ажиллах сургагч багш нар баг болон хамтран ажиллаж чадаагүй, сургалтыг түгээн дэлгэрүүлэх төлөвлөгөөг үндсэн сургалтын хөтөлбөр төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлээгүй, сургуулийн орчинд тухайн сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгаа хийгээгүй байсныг илрүүлсэн байна.

- ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийн 4.2.2-т “Жендэрийн орон нутгийн сургагч багшийн хүрэх түвшинг 257 болно” гэж тооцсон боловч ГБХЗХГ-ын 2020 оны дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд сургагч багшийн тоо 98 гэж дурдсан байна. Энэ нь сургагч багшийн тоог нэмэгдүүлж буй байдал хангалтгүй, зорьсон түвшинд хүрээгүй байна. Мөн сургагч багш нар нийт 2250 хүүхдэд сургалтыг зохион байгуулсан байгаа нь аймгийн төвийн ЕБС-д суралцаж буй өсвөр насны хүүхдүүдийн 75 хувийг хамруулжээ.
- Өсвөр насны хүүхдэд жендэрийн тухай ойлголт, мэдлэг өгөх, хандлагыг өөрчлөх үйл ажиллагаанд аймгийн төвд суралцаж буй хүүхдүүдийг боломжийн түвшинд хамруулсан байгаа хэдий ч аймгийн хэмжээнний нийт өсвөр насны хүүхдүүдийн 41.2 хувьд хүрч ажилласан байна. Иймд хөдөө сумдад амьдарч, суралцаж буй өсвөр насны хүүхдэд сургалт мэдээллийг хүргэж ажиллах шаардлагатай байна.
- 2017-2019 онд Монголын эмэгтэйчүүдийн сан, орон нутгийн эмэгтэйчүүдийн ТББ-ууд бага насны хүүхдийг хүчирхийллээс ангид байх орчинг дэмжих, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд төрийн оролцоо, дэмжлэгийг нэмэгдүүлэх төслүүдийг төрийн өмчийн 2 цэцэрлэг, ерөнхий боловсролын 2 сургуулийн хүүхэд, багш, эцэг эхчүүдийн хамт хэрэгжүүлсэн байна.
- Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь хүүхэд хамгааллын салшгүй хэсэг гэдгийг бүх багш, сурагч, эцэг эхчүүдэд ойлгуулах, танхимын сургалтаас гадна мэдлэг, мэдээллийг тасралтгүй тогтмол олгох өөр үр дүнтэй арга хэлбэрийг сонгож хэрэгжүүлэх, өмчийн бүх хэлбэрийн ЕБС-ийн өсвөр насны хүүхдэд жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлага, чадвар олгох сургалтыг түгээн дэлгэрүүлэх саналуудыг орон нутгийн жендэрийн салбар хороонд ИНБЗ-өөс дэвшүүлсэн хэдий ч үүнийг ажил болгож хэрэгжүүлсэн байдал хангалтгүй байна.

Дээрх тоо баримтад үндэслэн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн Зорилт 1 ”Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх”-ийн 3.1.1-т туссан “Сургуулийн өмнөх насны хүүхдийн хүчирхийлэлгүй орчинг дэмжих, хүүхэд өсвөр үе, оюутан залуус, гэр бүлд жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулах” ажлын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хэрэгжилтэд өгсөн төрийн байгууллагын үнэлгээг ОХШҮ-ний багаас дүгнэвэл:

**Хүснэгт 7. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд өгсөн төрийн байгууллагын үнэлгээ ба ОХШҮ-ний багийн үнэлгээ. /3.1.1/**

| Шигтгээ: 3.1.1 | |
|---|---|
| *Төрийн байгууллагын үнэлгээ:* | ОХШҮ-ний багийн дүгнэлт: |
| *Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалтыг жил бүр зохион байгуулж нийтдээ 98 сургагч багш бэлтгэгдэж 3250 сурагч, 3226 хүн жендэрийн эрх тэгш байдлын талаарх мэдлэг ойлголттой болсон.* Биелэлт 100 | *Дэд хөтөлбөрийн зорилт 1-ийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийг үнэлсэн байдал нь гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлттэй уялдуулсан байдал хангалтгүй байна. Тухайлбал сургагч багш бэлтгэсэн байдлын хэрэгжилт 60 хувьтай байна. Мөн ЕБС-ийн өсвөр насны хүүхдүүдийг сургалтад хамруулсан хувь хэмжээ хангалтгүй, бага насны хүүхдийг хүчирхийллээс ангид байх орчинг дэмжих төслийн хүрээнд бий болсон сайн туршлага, сургалтын арга зүйг бусад цэцэрлэгүүдэд түгээн дэлгэрүүлэх санал санаачилга гаргаж ажиллаагүй байна. Иймээс төрийн байгууллага өөрт өгсөн үнэлгээгээ дахин нягтлах, бодит болгоход анхаарах хэрэгтэй байна.* |

**Зорилт 1 “Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх”-ийн 3.1.2-т туссан заалтын “**Аз жаргал төв”, “Гэр бүлд зөвлөгөө өгөх төв”-ийн сургалт, зөвлөн туслах үйлчилгээнд жендэр судлал, нөхөн үржихүй, эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, гэр бүл судлал, охид эмэгтэйчүүдийг хүний наймаа, бэлгийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх сургалт судалгаа, нөлөөллийн үйл ажиллагааны хүрээнд:

- Хүүхэд залуучуудын нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дэмжих зорилготой “Аз жаргал” төвийг аймаг, орон нутгийн төсвөөр Аймгийн Засаг даргын 2017 оны А/221 тоот захирамжаар шинээр байгуулсан байна. 2017-2018 онд өсвөр насны 4500 гаруй хүүхэд, 2019 - 2020 онд 6320 хүүхдэд хүрч үйлчилгээ үзүүлжээ.

Өмнөх онуудтай нь харьцуулж үзэхэд үйлчилгээ олон хүүхдэд хүргэсэн байгаа нь тус төвийн өдөр тутмын үйл ажиллагааг “Ашид батжин” ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлж, аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төвтэй хамтран өсвөр насны хүүхдүүдэд нөхөн үржихүйн мэдлэг боловсрол олгох, зөвлөн туслах үйлчилгээг цогцоор нь хүргэж эхэлсэн байна.

Мөн орон нутгийн төсвөөс тус төвд 2017- 2019 онд нийт 37.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж төвийн мэргэжлийн эмч, багш, зөвлөгч болон үе тэнгийн сургагч багш нар аймгийн өсвөр насны нийт хүүхдийн 55.4 хувийг хамарсан сургалт, зөвлөгөө мэдээлэл болон урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулжээ.

- “Залуучууд хөгжлийн төв”, “Аз жаргал төв”-үүд хамтран өсвөр үеийнхний эрүүл мэндийг дэмжих төслийн хүрээнд Хэрлэн сумын ЕБС-ийн 11 сургуулийн 958 хүүхэд /89.7 хувь/ урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан тухай ГБХЗХГ-ын 2018-2020 оны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд туссан байгаа нь зорилтот бүлгийн хүн амыг өндөр хувьтай хамруулж дэд хөтөлбөрийн зорилтыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа болж чаджээ.
- Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний шалгуурт нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээнээс гадна гэр бүл төлөвлөлт, гэр бүл судлал, охид эмэгтэйчүүдийг хүний наймаа, бэлгийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх сургалт, судалгаа, нөлөөллийн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхээр тусгажээ. Гэвч энэ талаар гүйцэтгэлийн тайлан, мэдээлэлд тусгагдаагүй байсан.

Дээрх тоо баримтад үндэслэн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн Зорилт 1 ”Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх”-ийн 3.1.2–д туссан Аз жаргал төв”, “Гэр бүлд зөвлөгөө өгөх төв”-ийн сургалт, зөвлөн туслах үйлчилгээнд жендэр судлал, нөхөн үржихүй, эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, гэр бүл судлал, охид эмэгтэйчүүдийг хүний наймаа, бэлгийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх сургалт судалгаа, нөлөөллийн үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд өгсөн төрийн байгууллагын үнэлгээг ОХШҮ-ний багаас дүгнэвэл:

**Хүснэгт 8. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд өгсөн төрийн байгууллага ба ОХШҮ-ний багийн үнэлгээний харьцуулалт. /3.1.2/**

| *Шигтгээ: 3.1.2* | |
|---|---|
| *Төрийн байгууллагын үнэлгээ:* | *ОХШҮ-ний багийн дүгнэлт:* |
| *Аз жаргал төв, Залуучууд хөгжлийн төвийн амьдрах ухааны сургалтаар 14-18 насны 8220 өсвөр үе, залуучуудад нөхөн үржихүйн мэдлэг, мэдээлэл, тусламж үйлчилгээг үзүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 20 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Биелэлт 100* | *Тайланд байгаа мэдээлэлд шинжилгээ хийж үзэхэд “Аз жаргал төв”-ийн үйл ажиллагааны дийлэнх нь нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлийн сургалт, зөвлөгөө, үзлэг оношлогоо давамгайлсан байна. Цаашид төрийн үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэж буй ТББ-тай хийх хамтын ажиллагааны гэрээнд дээрх орхигдсон чиглэлийн үйл ажиллагаа, үйлчилгээг зайлшгүй үзүүлэх тухай тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах шаардлагатай байна. Тус төв нь 7 чиглэлээр сургалт, мэдээлэл, судалгаа, нөлөөллийн үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байгаа хэдий ч зөвхөн нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг, мэдээлэл, тусламж үйлчилгээ үзүүлсэн байгаад бодит үнэлгээ өгөх шаардлагатай.* |

**Зорилт 1 “Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх”-ийн 3.1.3-т туссан “Орон нутгийн төрийн удирдах албан тушаалтан, төрийн албан хаагчид болон аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд зориулсан жендэрийн сургалтуудыг зохион байгуулах, орон нутгийн сургагч багш нарыг чадавхжуулах” үйл ажиллагааны хүрээнд:**

- Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулсан ЖЭТБХ үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2018-2020 онд Дархан, Хэнтий, Дорноговь, Сүхбаатар аймагт зохион байгуулсан сайн туршлагыг танилцуулах харилцан суралцах семинарт 35 төрийн албан хаагчид оролцсон байна.

- 2017 оноос хэрэгжсэн Канадын Мерит төслийн хүрээнд аймгийн хэмжээнд олон улсын сургалтад 2017 онд 1 албан хаагч үндэсний сургагч багшаар, 2018-2019 онд 26 төрийн албан хаагч тус бүр шинээр бэлтгэгдэж, 5 төрийн албан хаагч олон улсын төслийн цахим сургалтад хамрагдаж батламж авсан байна.

  Мөн жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт ба төсөвлөлт сэдэвт сургалтад төрийн захиргааны 70 гаруй албан хаагч хамрагдаж жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн талаар ахисан түвшний мэдлэгтэй болжээ.

- ЖЭТБ хангах дэд хөтөлбөрийн 4.1.5 –д “Шийдвэр гаргах болон гүйцэтгэх түвшин дэх хүйсийн тэнцвэртэй байдал хангагдсан байна” гэж тусгагдсан бөгөөд дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт 4.2.9-д “Шийдвэр гаргах түвшинд ажиллаж буй эмэгтэйчүүд 2021 онд 30 хувьд хүрсэн байна” гэж тогтоосон. Дэд хөтөлбөрийн дээрх үр дүн, шалгуур үзүүлэлтийг хангах зорилгоор 2018-2020 онд дэд хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд “Эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшинд ажиллахад бэлтгэх, чадваржуулах, манлайллыг бий болгох чиглэлээр эмэгтэйчүүдийн ТББ-тай хамтран ажиллах сургалт, мэдээллийн ажил зохион байгуулах” чиглэлд нийт 2.431.000 төгрөг төсөвлөж үйл ажиллагаа зохион байгуулсан байна. Орон нутгийн аймаг, сумын ИТХ-ын сонгуулийн үр дүнд сумдын ИТХ-д сонгогдсон эмэгтэй төлөөлөгчдийн тоо өмнөх

сонгуулийн жилийнхээс 2.7хувиар, аймгийн ИТХ-д сонгогдсон эмэгтэйчүүдийн тоо 4.1 хувиар тус тус өссөн байна. Мөн сумдын ИТХ-ын тэргүүлэгчид сонгогдсон эмэгтэйчүүдийн тоо өмнөх онтой адилхан, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид сонгогдсон эмэгтэйчүүдийн тоо өмнөх оноос 11 хувиар нэмэгдсэн байна. Үзүүлэлтийг хүснэгт 2.3 –д үзүүлэв.

***Хүснэгт 9. Дорнод аймгийн сумдын ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчид /2012-20124/***

| № | Нийт сумдын төлөөлөгчдийн тоо | Бүх төлөөлөгч | Эмэгтэй | Тэргүүлэгч | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2012-2016 | 274 | 75 | 25 | 27.4 |
| 2 | 2016-2020 | 274 | 70 | 16 | 25.5 |
| 3 | 2020-2024 | 280 | 79 | 16 | 28.2 |

***Хүснэгт 10. Дорнод аймгийн ИТХ-ийн эмэгтэй төлөөлөгчид. /2012-2024/***

| № | Аймгийн төлөөлөгчдийн тоо | Бүх төлөөлөгч | Эмэгтэй | Тэргүүлэгч | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2012-2016 | 32 | 3 | 0 | 9.4 |
| 2 | 2016-2020 | 31 | 4 | 0 | 12.9 |
| 3 | 2020-2024 | 35 | 5 | 1 | 14.3 |

Дээрх тоо баримтад үндэслэн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн Зорилт 1 ”Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх”-ийн 3.1.3–д “Орон нутгийн төрийн удирдах албан тушаалтан, төрийн албан хаагчид болон аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд зориулсан жендэрийн сургалтуудыг зохион байгуулах, орон нутгийн сургагч багш нарыг чадавхжуулах” гэсэн заалтын хүрээнд хийсэн төрийн байгууллагын үнэлгээг ОХШҮ-ний багаас дүгнэвэл:

**Хүснэгт 11.ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэнд өгсөн төрийн байгууллага ба ОХШҮ-ний багийн үнэлгээний харьцуулалт /3.1.3/**

| *Шигтгээ: 3.1.3* | |
|---|---|
| *Төрийн байгууллагын үнэлгээ:* | *ОХШҮ-ний багийн дүгнэлт:* |
| *Тайлант онд үндэсний сургагч багшаар 27, орон нутгийн сургагч багшаар 30 албан хаагч бэлтгэгдсэн бол төрийн захиргааны 70 гаруй албан хаагч жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн ахисан түвшний сургалтад хамрагдсан байна.*<br>Биелэлт 100 | *ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийн 4.2.3-т “Жендэрийн сургалтад хамрагдсан төрийн удирдах ажилтны хүрэх түвшин 85, төрийн албан хаагчийн хүрэх түвшинг 200 байхаар төлөвлөсөн байна”. Хүрэх түвшин болон өнөөгийн хүрсэн тоон үзүүлэлт хоорондын зөрүүтэй байдал нь төрийн удирдах болон төрийн албан хаагчдыг ЖЭТБХ сургагч багшаар нэмж бэлтгэх шаардлагатай байгааг харуулж байна.* |

**Зорилт 1 “Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх”-ийн 3.1.4-т туссан** “Орон нутгийн иргэдийн амьжиргаа, хүний хөгжлийг тодорхойлдог шалгуур үзүүлэлтүүдийн талаарх төрийн байгууллагууд болон олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлж, хэрэглээ болгох ажлуудыг зохион байгуулах” үйл ажиллагааны хүрээнд:

- Канадын ЗГ-ын Мерит төсөл болон аймгийн ЗДТГ-ын НБХ-ээс 12 сумын ЗДТГ, 18 агентлагын албан хаагчдад хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмж, соёл урлаг, санхүүгийн үзүүлэлт, өрсөлдөх чадварын тухай ерөнхий ойлголт мэдлэг олгох, судалгаа шинжилгээ хийх, өдөр тутамдаа хэрэглээ болгож ажиллах аргачлалыг төрийн албан хаагчдад өгч ажилласан байна.
- Олон улсын байгууллагын санаачилгатай жендэрийн мэдрэмжтэй сайн засаглалыг хөгжүүлэх төсөл орон нутагт хэрэгжиж байгаа нь олон давуу талыг бий болгож буй сайн талтай ч энэхүү төслийн үр шимийг хүртсэн төрийн байгууллагын удирдах албан тушаалтан, мэргэжилтэн, баг хамт олон орон нутгийн иргэдийн амьжиргаа, хүний хөгжлийг тодорхойлдог шалгуур үзүүлэлтүүдийг тусгасан бодлого, төлөвлөлт, төслийг

хэрхэн боловсруулж хэрэгжүүлсэн тухай, бүх нийтэд жендэрийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулсан байдал, төлөвлөгөө тайланд тусгагдаагүй байна.

Дээрх тоо баримтад үндэслэн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн Зорилт 1 "Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх"-ийн 3.1.4–т туссан "Орон нутгийн иргэдийн амьжиргаа, хүний хөгжлийг тодорхойлдог шалгуур үзүүлэлтүүдийн талаарх төрийн байгууллагууд болон олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлж, хэрэглээ болгох ажлуудыг зохион байгуулах" гэсэн үйл ажиллагааны хэрэгжилтэд өгсөн төрийн байгууллагын үнэлгээг ОХШҮ-ний багаас дүгнэвэл:

**Хүснэгт 12. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд өгсөн төрийн байгууллага ба ОХШҮ-ний багийн үнэлгээний харьцуулалт /3.1.4/**

| *Шигтгээ: 3.1.4* | |
|---|---|
| *Төрийн байгууллагын үнэлгээ:* | *ОХШҮ-ний багийн дүгнэлт:* |
| *Төрийн байгууллагын үнэлгээ: Аймгийн хүний хөгжлийн индекс буюу эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн хоорондын тэгш бус байдлыг 2019 оныг өмнөх онтой харьцуулахад 0,023 хувьтай байна. Үнэлгээ: 70 хувь* | *Орон нутгийн иргэдийн амьжиргаа, хүний хөгжлийг тодорхойлдог шалгуур үзүүлэлтүүдийн талаарх мэдээллийг зөвхөн төрийн байгууллагын ажилтан албан хаагчдад хандсан байдлаар хэрэгжиж харин олон нийт, иргэд рүү чиглэсэн мэдээлэл сурталчилгаа, мэдлэг олгох үйл ажиллагаа хийгдээгүй байна.* |

**Зорилт 1 "Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх"-ийн 3.1.4-т туссан "Бүх нийтийн жендэрийн мэдлэгийг нэмэгдүүлэхэд орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах" тухай заалтын хүрээнд:**

- "Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь" 3 удаагийн сургалтын талаарх мэдээллийг орон нутгийн ТV-6, Дорнод, Мижи телевизүүдээр цацаж, олон нийтэд хүргэж ажилласан байна.
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын нэвтрүүлгийн цагаар жендэрийн тухай ойлголтын талаарх шторк, видео нэвтрүүлгүүдийг тогтмол явуулж иргэд олон нийтэд жендэрийн мэдрэмжтэй хөгжлийн бодлого болон жендэрийн эсрэг хүчирхийллийн талаар ойлголт, мэдээллийг хүргэж ажилласан байна.
- Хүүхдийн хөгжил хамгааллын зурагт хуудас машины наалт зэрэг 12 төрлийг 122 байгууллага, 1500 ширхгийг машинд, 11 сургуульд дарамт хүчирхийлэлгүй бүс наалтыг нааж нөлөөлж ажилласан.

  Конвенц 30 арга хэмжээгээр 28 төрлийн гарын авлагыг 27 байгууллагад түгээж, 16960 хүүхдэд хялбаршуулсан хичээлийг зааж, 260 эцэг эхийн энэ талын мэдлэгийг нэмэгдүүлсэн байна.
- Dornod.mn, Хүүхэд бүрт.мн, "Dornod zaluus.mn сайт, "Дорнод залуус" гар утасны аппликейшны хэрэглээг сургалтаар дамжуулан 300 гаруй эцэг эхчүүдэд гар утсандаа суулгах зааварчилгаа өгч ажилласан. Мөн орон нутгийн телевизээр дамжуулан дээрх сайт, аппликейшны шторкыг тогтмол олон нийтэд хүргэж ажиллажээ.
- Жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн манлайлал, залуучуудын улс төрийн оролцоо сэдвүүдээр шторк бэлтгэж бүс нутгийн хэмжээнд зарласан Хакатонд оролцон 2-р байр эзэлсэн. Шторкийг Jagar.mn, Нутаг 21 тв болон нийгмийн сүлжээнд гаргаж иргэд олон нийтийн жендэр, жендэрийн эрх тэгш байдал болон залуучууд, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоот талаар ойлголт мэдлэгийг нэмэгдүүлсэн. Давхардсан тоогоор 7800 хүн үзэж танилцсан байна.
- Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт, мэдээ, шторк, видео нэвтрүүлэг, зааварчилгаа, постероор дамжуулж олон нийтэд мэдээлэл хүргэж ажилласан ч хөтөлбөрийн зорилттой уялдуулан үр дүнг хэмжсэн байдал хангалтгүй байна.

Дээрх тоо баримтад үндэслэн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн "Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх"-ийн 3.1.5-т туссан "Бүх нийтийн жендэрийн мэдлэгийг нэмэгдүүлэхэд орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажилласан үйл ажиллагааны хэрэгжилтэд өгсөн төрийн байгууллагын үнэлгээг ОХШҮ-ний багаас дүгнэвэл:

**Хүснэгт 13. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд өгсөн төрийн байгууллага ба ОХШҮ-ний багийн үнэлгээний харьцуулалт. /3.1.5/**

| *Шигтгээ: 3.1.5* | |
|---|---|
| *Төрийн байгууллагын үнэлгээ:* | *ОХШҮ-ний багийн дүгнэлт:* |
| *Тус зорилтыг хангах хүрээнд 56 удаагийн сургалт үйл ажиллагаагаар 7116 хүүхэд, насанд хүрэгчдийг хамруулан жендэрийн боловсрол олгох сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулан ажилласан ба 225 хүнд сэтгэл зүйн болоод хууль эрх зүйн зөвлөгөөг өгч ажилласан байна. Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагаар жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх 5 төрлийн мэдээллийг 8 удаагийн давтамжтайгаар 7800 хүнд хүргэж ажиллалаа. Биелэлт 100* | *Төрийн байгууллагын зүгээс жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэн 16 хоногийн аяны хүрээнд /акц/ мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулсан нь бүх нийтийн жендэрийн мэдлэгийг дээшлүүлэхэд урт хугацааны үр дүнд нөлөөлөхүйц бодлого чиглэл тодорхойгүй байгааг харуулж байна. Мөн ИНБ-аас УИХ болон орон нутгийн сонгуультай холбогдуулж улс төр дэх эмэгтэйчүүдийн манлайлал зэрэг сэдэвт мэдээлэл сурталчилгааны ажил хийсэн байдлаас харахад цаг үеийн шинжтэй үйл ажиллагаанууд зонхилж байна. Энэхүү ажил тодорхой төлөвлөлт, төсөвтэйгээр хэрэгжих шаардлагатай байна.* |

**ЖЭТБХ дэд хөтөлбөрийн Зорилт 2 "Төр ИНБ-ын түншлэлийн хүрээнд орон нутгийн тогвортой хөгжлийг дэмжсэн жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх"-ийн хүрээнд:**

- Төр иргэний нийгмийн байгууллагын түншлэлийн хүрээнд орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжсэн жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, төсөвлөлтийг нэвтрүүлэх тухай 5 үйл ажиллагаа тусгагдсан байна.

**Зорилт 2 "Төр ИНБ-ын түншлэлийн хүрээнд орон нутгийн тогвортой хөгжлийг дэмжсэн жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх"-ийн 3.2.1-д туссан "Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд нь салбар бүрд, зүүн бүс, аймаг орон нутгийн урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, салбарын жендэрийн нэгдсэн бодлого, үндэсний болон орон нутгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй болох" үйл ажиллагааны хүрээнд:**

- Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тулгуурлан Дорнод аймгийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар хорооны 2019 оны төлөвлөгөөнд нийт 15 ажил үйлчилгээ тусгаж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

- Аймгийн эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2.4.5 дахь заалт "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах" /2018-2021он/ аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гэж тусгаж өгсөн. Уг заалтыг хэрэгжүүлэх хүрээнд төр иргэний нийгмийн байгууллага Канадын Мерит төсөлтэй хамтран сургалт сурталчилгааны ажлуудыг хамтран зохион байгуулж жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, төсөвлөлтийг хийж байна.

- ЖЭТБХ дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Жендэрийн үндэсний хороо, Хүний эрхийн үндэсний комисс, Канадын Мерит төсөлтэй хамтран ажилладаг. МОНЭС-ийн дэмжлэгээр Дорнод аймаг дахь "Жендэрийн эрх тэгш байдлын төлөөх нийгмийн түншлэл, хамтын ажиллагаа" хөдөлгөөнийг бэхжүүлэх нь төслийн хүрээнд орон нутгийн манлайлагч 25 залуучууд "Хүний эрх, жендэр, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх

аргачлал, хүний эрхийн хамгаалагчдын аюулгүй байдал" зэрэг сэдвээр ойлголт мэдлэгтэй болж бодит амьдрал дээр ашиглаж сурсан үр дүнг тайланд онцолсон байна.

- Төрийн байгууллагууд жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, төсөвлөлтийг хийж байгаа тухай тайланд туссан байгаа хэдий ч түүнийг батлах, нотлох баримт, үзүүлэлтүүд хангалтгүй байна.

Дээрх тоо баримтад үндэслэн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн Зорилт 2 "Төр ИНБ-ын түншлэлийн хүрээнд орон нутгийн тогвортой хөгжлийг дэмжсэн жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх"-ийн 3.2.1–ийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хэрэгжилтэд өгсөн төрийн байгууллагын үнэлгээг ОХШҮ-ний багаас дүгнэвэл:

**Хүснэгт 14. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд өгсөн төрийн байгууллага ба ОХШҮ-ний багийн үнэлгээний харьцуулалт /3.2.1/**

| *Шигтгээ: 3.2.1* | |
|---|---|
| *Төрийн байгууллагын үнэлгээ:* | *ОХШҮ-ний багийн дүгнэлт:* |
| *Бодлого төлөвлөлтөд тусгаж төлөвлөгөө гарган ажилласнаар төр иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирч нийгмийн суурь үзүүлэлтүүд өссөн.*<br><br>*Биелэлт 100* | *Энэ чиглэлд олон улсын байгууллагын төсөл хөтөлбөр амжилттай хэрэгжиж орон нутгийн бодлого шийдвэрийг жендэрийн мэдрэмжтэй боловсруулахад нөлөөлнө гэж үзэж байна. Тухайлбал "Канадын ЗГ-ын Мерит төслийн үр дүнд тодорхой хугацааны дараа аймаг орон нутгийн урт болон богино хугацааны хөгжлийн бодлого жендэрийн мэдрэмжтэй боловсруулагдаж, эрэгтэй эмэгтэй хүмүүс хөгжлийн үр шимээс тэгш хүртэх боломж нэмэгдэх болно." гэсэн үр дүн харагдаж байна* |

**Зорилт 2 "Төр ИНБ-ын түншлэлийн хүрээнд орон нутгийн тогвортой хөгжлийг дэмжсэн жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх"-ийн 3.2.2-т туссан "Аймаг, сумын хөгжлийн бодлого, байгууллагуудын хөгжлийн төлөвлөгөө, байгууллагын дотоод журам, хүний нөөцийн бодлого, хөтөлбөр, төслийг жендэрийн мэдрэмжтэй үзэл баримтлалыг нэвтрүүлэх" заалтын хүрээнд:**

- Хүний эрхийн үндэсний комисс, Жендэрийн үндэсний хорооны дотоод аудит хийх ажлын үзүүлэлтэд тусгаж бүтэн 2 сарын хугацаанд хийж гүйцэтгэсэн.
- Зөвлөмжийн дагуу Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4 дэх заалт, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын дагуу бүх сум, агентлаг албан байгууллагууд дотоод журмаа шинэчилсэн. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, бусдыг бэлгийн болон хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн аливаа хэлбэрээр дарамтлах, хавчин гадуурхах эрхшээлдээ байлгавал ноцтой зөрчил гэж үзнэ" гэж нэмэлт өөрчлөлт оруулж жендерийн мэдрэмжтэй бодлогыг тусган ажиллаж байна.
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь албан хаагчдын нийгмийн баталгааг дэмжих хүрээнд тэдний хүүхэд, гэр бүлтэйгээ өнгөрүүлэх цагийг нэмэгдүүлэх, хүүхдийн эрхийг дээдлэх зорилгоор 2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн "Албан хаагчдын хүүхдийн /0-16 нас/ төрсөн өдөр тохиох бүрд цалинтай чөлөө олгох"- шийдвэрийг гарган цахим орчинд бусад байгууллагуудаа уриалсан бөгөөд уг шийдвэр нь үндэсний хэмжээнд сайн туршлага болсон байна.
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах нөхцлийг бүрдүүлэн бүх сум, агентлаг албан байгууллагууд дотоод журмаа шинэчилэн ажиллаж байгаа хэдий ч түүний хэрэгжилтийн явцад хяналт тавьсан, үр дүнг тодорхойлсон, дэд хөтөлбөрийн зорилттой уялдуулан тайлагнасан байдал хангалтгүй байна.

Дээрх тоо баримтад үндэслэн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн Зорилт 2 ”Төр ИНБ-ын түншлэлийн хүрээнд орон нутгийн тогвортой хөгжлийг дэмжсэн жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх”-ийн 3.2.2-т туссан “Аймаг, сумын хөгжлийн бодлого, байгууллагуудын хөгжлийн төлөвлөгөө, байгууллагын дотоод журам, хүний нөөцийн бодлого, хөтөлбөр, төслийг жендэрийн мэдрэмжтэй үзэл баримтлалыг нэвтрүүлэх” үйл ажиллагааны хэрэгжилтэд өгсөн төрийн байгууллагын үнэлгээг ОХШҮ-ний багаас дүгнэвэл

**Хүснэгт 15.ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд өгсөн төрийн байгууллага ба ОХШҮ-ний багийн үнэлгээний харьцуулалт /3.2.2/**

| *Шигтгээ: 3.2.2* | |
|---|---|
| *Төрийн байгууллагын үнэлгээ:* | *ОХШҮ-ний багийн дүгнэлт:* |
| *Сум агентлагууд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар чиглэл өгч ажилласнаар 22 байгууллага дотоод журамдаа өөрчлөлт оруулж, хийсэн ажлаа тайлагнадаг болсон. Биелэлт 100 хувь* | *Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх 4.2.7 дахь шалгуур үзүүлэлтэд жендэрийн мэдрэмжтэй салбарын хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг 2021 онд төрийн 4 байгууллага гэж тогтоосон байна.*<br>*Эдгээр байгууллагуудад төрийн үйлчилгээний байгууллагууд болон аймаг, сумын ЗДТГ-ыг нэр заан оруулжээ. Энэ ажлын хүрээнд нийт төрийн 22 байгууллага дотоод журмандаа өөрчлөлт оруулж, хийсэн ажлаа тайлагнадаг болсон байна. Цаашид энэхүү заалтын хэрэгжилт, үр дүнг үнэлэх ЖЭТБХ дэд хөтөлбөрийн зорилтыг хэрхэн хангаж буй байдлыг тайлагнадаг байхад анхаарах хэрэгтэй.* |

**Зорилт 2 “Төр ИНБ-ын түншлэлийн хүрээнд орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжсэн жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх”-ийн 3.2.3-д туссан “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах байрны үйл ажиллагааг чанаржуулж, жендэрт суурилсан хүчирхийллийн бүх хэлбэрт өртсөн хохирогчдын тоог эрс бууруулах” тухай заалтын хүрээнд:**

- Аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дэргэд 2014 онд орон нутгийн санхүүгийн дэмжлэгтэйгээр 4 хүн хүлээн авах чадалтай түр хамгаалах байрыг санаачлан байгуулсан бол 2019 онд Нэгдсэн Үндэсний Байгууллага, Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр олон улсын стандартад нийцсэн нэгэн зэрэг 8 үйлчлүүлэгч хүлээн авах хүчин чадалтай, гал тогооны өрөөтэй, ариун цэврийн өрөөний нөхцөлийг сайжруулж, хүүхдийн тоглоомын талбайг шинээр байгуулж, төвийн аюулгүй байдлыг хангасан блокон өндөр хашаатай болж, сэтгэл зүйчийн орон тоог нэмэгдүүлж “Нэг цэгийн үйлчилгээний төв” болгон өргөжүүлсэн. Уг төв нь хохирол учирсны дараах түр тусламж үйлчилгээ үзүүлдэг байсан бол одоо гэр бүл дотор хүчирхийлэл үйлдэгдэхээс нь өмнө урьдчилан сэргийлэх чиглэлд үзүүлэх үйлчилгээний нэр төрөл нэмэгдэж, 2019-2020 онд байнгын үйл ажиллагаатай болсноос хойш 129 хүнд эрүүл мэнд, сэтгэл зүй, хууль эрх зүйн болон холбон зуучлах, хамгааллын үйлчилгээг үзүүлж, нэг цэгийн үйлчилгээг шинээр нэвтрүүлсэн. Аймаг, орон нутгийн төсвөөс тус төвд 2016-2020 онд нийт 30,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлснээр 420 хүнд сэтгэл зүйн болон хууль эрх зүйн үйлчилгээ үзүүлж 186 хүүхэд эмэгтэйчүүдэд амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах үйлчилгээ үзүүлсэн байна.
- Бусад дөрвөн үйл ажиллагааг хэрэгжүүлэх төсвийг 2018-2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээнд тусгаагүй байна. Учир нь хоёрдугаар зорилтыг хангахад дэмжлэг үзүүлэх олон улсын техник, арга зүйн дэмжлэгтэй Канадын Меррит төслөөр нийгмийн төсөл, хөтөлбөрийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлжээ. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн 3.2.2-д туссан “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах байрны үйл ажиллагааг чанаржуулах” гэсэн үйл ажиллагааны хүрээнд НҮБ-ийн хүн амын сангийн

дэмжлэгтэйгээр "Хохирогчийг хамгаалах байр"-ны орчин нөхцөл, үйлчилгээг сайжруулан хохирогчид, нийгмийн ажил, хууль, эрх зүй, сэтгэл зүйн үйлчилгээг цогцоор үзүүлэх боломж бүрдүүлснээр хохирогч эрсдлээс өөрийгөө урьдчилан сэргийлэх чадвар ойлголтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажилласан байна. Тухайлбал: Хохирогчийг хамгаалах байранд гал тогооны өрөө, хүүхдийн тоглоомын талбай болон блокон хашаагшинээр барьж тохижуулсан байна. Мөн ариун цэврийн өрөөний нөхцлийг сайжруулан, сэтгэл зүйчийн орон тоог нэмж ажиллуулсан байна. Орон нутгийн төсвөөс 2018-2020 онд нийт 30.5 сая төгрөгийн санхүүжилт өгч хамгаалах байрны үйлчилгээний тогтвортой байдлыг ханган ажиллажээ.

- ЖЭТБХ дэд хөтөлбөрийн 3.2.2-т туссан "...жендэрт суурилсан хүчирхийллийн бүх хэлбэрт өртсөн хохирогчдын тоог эрс бууруулах" үйл ажиллагааны тухай мэдээлэл хангалтгүй, түүнийг хэмжиж үнэлэх боломжгүй байна.

Дээрх тоо баримтад үндэслэн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн Зорилт 2 "Төр ИНБ-ын түншлэлийн хүрээнд орон нутгийн тогвортой хөгжлийг дэмжсэн жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх"-ийн 3.2.3–д туссан "Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах байрны үйл ажиллагааг чанаржуулж, жендэрт суурилсан хүчирхийллийн бүх хэлбэрт өртсөн хохирогчдын тоог эрс бууруулах" тухай заалтын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хэрэгжилтэд өгсөн төрийн байгууллагын үнэлгээг ОХШҮ-ний багаас дүгнэвэл:

**Хүснэгт 16. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд өгсөн төрийн байгууллага ба ОХШҮ-ний багийн үнэлгээний харьцуулалт /3.2.3/**

| *Шигтгээ: 3.2.3* | |
|---|---|
| *Төрийн байгууллагын үнэлгээ:* | *ОХШҮ-ний багийн дүгнэлт:* |
| *Бүх төрлийн хүчирхийлэлд өртсөн дуудлага мэдээлэл 2019 онд 123 байсан бол 2020 онд 96 болж өмнөх оноос 22 хувиар буурсан үзүүлэлттэй байна.* *Биелэлт 100* | *Аймаг, орон нутгийн төсвөөс 30.5 сая, олон улсын байгууллагаас 4.3 сая төгрөг нийт 34.8 сая төгрөгний санхүүжилтийг тус төвийн үйл ажиллагааны зардал болон тохижилтод зарцуулсан байна. Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлжээ. Харин дэд хөтөлбөрийн хэрэгжлтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийн 4.2.10-д "Хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээг төрийн бус байгууллагад гэрээлэн гүйцэтгүүлнэ" гэж заасан байна. Энэ талаар тодорхой ажил хийгдээгүй байна.* |

**Зорилт 2 "Төр ИНБ-н түншлэлийн хүрээнд орон нутгийн тогвортой хөгжлийг дэмжсэн жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх"-ын 3.2.4-д туссан "Аймаг, сумын хэмжээнд ажиллах эрүүл мэнд-сэтгэл зүй-эрх зүйн зөвлөгөөг өгөх бүтэц, гэр бүл судлаач, сэтгэл зүйчийг бэлтгэх, хүний нөөцийг бэлтгэх, гэр бүлийн үнэ цэнэ, хамтын амьдралын утга учир, эцэг эхийн хамтын үүрэг хариуцлагыг таниулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ зохион байгуулах" үйл ажиллагааны хүрээнд:**

- "Сэтгэл зүйч зөвлөж байна" подкастын анхны дугаараар сэтгэл зүйн ерөнхий ойлголт, мэдээллийг 4954 дагагчдад хүргэсэн. Хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэн, Монгол өрх сэтгэл зүйн хүрээлэнтэй "Сэтгэл зүйн дархлаажуулалтын аяныг орон нутагт хамтран зохион байгуулж ижил асуудалтай зорилтот өрхийн 186 иргэнд бүлгээр сэтгэл зүйн хямрал, даван туулах арга, нийгмийн ажилтан, хамтарсан багийн 123 гишүүдэд сэтгэл зүйн зөвлөгөө, засал хийх аргачлалын сургалтыг 2 удаа зохион байгуулсан байна.

- Канад сангийн орон нутгийн санаачилга хөтөлбөр"-т хандсаны үр дүнд зөвлөгөө өгөх өрөөг стандартад нийцүүлэн тохижуулах, мэргэжлийн боловсон хүчнийг сургах чадваржуулах асуудлуудыг харилцан тохирч Хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэнтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулж хамтран ажилласан байна.

- Гэрээт ажлын хүрээнд сэтгэл зүйн зөвлөгөөний өрөөг 4.323.900 төгрөгийн дотоод засвар, тавилга, техник хэрэгслээр тохижуулсан. "Хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэн"-ийн мэргэшүүлэх 7 удаагийн сургалтанд 5 албан хаагч суралцаж мэргэжлийн сертификаттай болсон.

- "Гэр бүлд зөвлөгөө өгөх төвд тавигдах нийтлэг шаардлага MNS 6417:2013 стандарт"-ын дагуу бүртгэлийн нэгдсэн маягт, үйлчлүүлэгчийн анхны бүртгэлийн маягт, ярилцлагын тэмдэглэл, зөвлөгчийн дүгнэлт, төлөвлөгөө гарган ажилласан байна.

- Зөвхөн нэг ажлын тайлан мэдээ, үр дүнд тулгуурлан ЖЭТБХ дэд хөтөлбөрийн зорилтод туссан энэ чиглэлийн үйл ажиллагааг үнэлэх боломжгүй байлаа. Сэтгэл зүй- эрх зүйн зөвлөгөөг өгөх бүтэц, гэр бүл судлаач, сэтгэл зүйчийг бэлтгэх, хүний нөөцийг бэлтгэх, гэр бүлийн үнэ цэнэ, хамтын амьдралын утга учир, эцэг эхийн хамтын үүрэг хариуцлагыг таниулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ зохион байгуулахдаа орон нутгийн Их сургуулийн хүний нөөцөд тулгуурлах боломж байгааг анхаарч хамтран ажиллах шаардлагатай байна.

Дээрх тоо баримтад үндэслэн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн Зорилт 2: "Төр ИНБ-н түншлэлийн хүрээнд орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжсэн жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх" арга хэмжээний 3.2.4–д туссан "Аймаг, сумын хэмжээнд ажиллах эрүүл мэнд-сэтгэл зүй-эрх зүйн зөвлөгөөг өгөх бүтэц, гэр бүл судлаач, сэтгэл зүйчийг бэлтгэх, хүний нөөцийг бэлтгэх, гэр бүлийн үнэ цэнэ, хамтын амьдралын утга учир, эцэг эхийн хамтын үүрэг хариуцлагыг таниулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ зохион байгуулах" гэсэн үйл ажиллагааны хэрэгжилтэд өгсөн төрийн байгууллагын үнэлгээг ОХШҮ-ний багаас дүгнэвэл:

**Хүснэгт 17. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд төрийн байгууллага ба ОХШҮ-ний багийн өгсөн үнэлгээний харьцуулалт /3.2.4/**

**Хүснэгт 17. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд төрийн байгууллага ба ОХШҮ-ний багийн өгсөн үнэлгээний харьцуулалт /3.2.4/**

| *Шигтгээ: 3.2.4* | |
|---|---|
| *Төрийн байгууллагын үнэлгээ:* | *ОХШҮ-ний багийн дүгнэлт:* |
| *Зөвлөгөө өгөх чиглэлээр стандартад нийцсэн сэтгэл зүйн өрөөтэй болж, мэргэжлийн сэтгэл зүйч тогтмол ажиллуулж байгаад иргэд сэтгэл ханамжтай байна.*<br><br>*Биелэлт 100* | *Сэтгэл зүйн зөвлөгөөг олон талт хэлбэрээр зохион байгуулж зөвлөгөө өгөх төвтэй болсон давуу талтай байна. Гэхдээ эдгээр үйл ажиллагаа нь ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд жил бүр батлагддаг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд ороогүй төрийн байгууллагын үндсэн чиг үүргийн дагуу хэрэгжүүлсэн үйл ажиллагаа юм. Дэд хөтөлбөрийн зорилтуудыг төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлэх шаардлагатай байна. Цаашид дэд хөтөлбөрийн зорилтыг хангах арга хэмжээний төлөвлөлтөд тусгаж орон нутгийн Их сургуулийн нөөцөд тулгуурлан хэрэгжүүлэх боломж байна.* |

**Зорилт 2 "Төр ИНБ-н түншлэлийн хүрээнд орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжсэн жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх"-ийн 3.2.5-д туссан** "Орон нутгийн ТББ, Иргэний нийгмийн байгууллагатай хамтран, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт, "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр", аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад зөвлөн туслах, сайн туршлагыг түгээх ажлуудыг зохион байгуулах" тухай заалтын хүрээнд:

- Орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудын зөвлөлийн ажлын хэсгийн гишүүд 2018-2019 онд "Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх" мэдлэг, хандлага, чадвар олгох сургалтын түгээн дэлгэрүүлэх ажлын явцтай танилцаж аймгийн төвийн 9 сургуулийн үйл ажиллагаатай танилцаж зөвлөн туслах үйлчилгээ

үзүүлж ажилласнаар сургуулийн орчны хүүхдийн дундах жендэрт суурилсан хүчирхийллийг бууруулахад ахиц гарсан гэж үзсэн байна. Хэдийгээр ахиц гарсан гэж үзэж байгаа боловч сургалтыг түгээн дэлгэрүүлэх төлөвлөгөө, төсөв гаргаж батлан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- Дорнод аймаг дахь "Жендэрийн эрх тэгш байдлын төлөөх нийгмийн түншлэл, хамтын ажиллагаа" хөдөлгөөний чадавхыг үнэлэх цахим үнэлгээнд 80 хүн оролцож иргэний хөдөлгөөнүүдийн үйл ажиллагааг үнэлсэн байна. Үнэлгээний ажлын үр дүнг танилцуулах зөвлөлдөх уулзалтыг Либерал эмэгтэйчүүдийн оюуны сангийн Дорнод салбар зөвлөл, Гэр бүл олон нийтийн хөгжил төв ТББ хамтран зохион байгуулжээ. Уг үйл ажиллагаанд иргэдийн төлөөлөл 65 хүн оролцож, үнэлгээний үр дүнд суурилсан хөдөлгөөний чадавхыг бэхжүүлэх, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж сайн туршлагаа солилцсон байна.
- Дэд хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд эдгээр ажлууд тусгагдаагүй хэрэгжсэн байна. Энэ нь төрийн байгууллага үндсэн чиг үүргийнхээ хүрээнд гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайлан мэдээг ЖЭТБХ дэд хөтөлбөрийн тайланд хамаатуулан бичих явдал байгааг харуулж байна. Цаашид ЖЭТБХ дэд хөтөлбөрийн зорилтыг хангахуйц үр дүнг бий болгох төлөвлөгөөт ажлыг гүйцэтгэх нь нийгмийн нөөцийг үр дүнтэй зарцуулалт болохыг анхаарах нь чухал байна.

Дээрх тоо баримтад үндэслэн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн Зорилт 2 "Төр ИНБ-н түншлэлийн хүрээнд орон нутгийн тогвортой хөгжлийг дэмжсэн жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх"-ийн 3.2.5–т туссан "Орон нутгийн ТББ, Иргэний нийгмийн байгууллагатай хамтран, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт, "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр", аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад зөвлөн туслах, сайн туршлагыг түгээх ажлуудыг зохион байгуулах" гэсэн үйл ажиллагааны хэрэгжилтэд өгсөн төрийн байгууллагын үнэлгээг ОХШҮ-ний багаас дүгнэвэл:

**Хүснэгт 18. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд төрийн байгууллага ба ОХШҮ-ний багийн өгсөн үнэлгээний харьцуулалт /3.2.5/**

| *Шигтгээ: 3.2.5* | |
|---|---|
| *Төрийн байгууллагын үнэлгээ:* | *ОХШҮ-ний багийн дүгнэлт:* |
| *Зөвлөн туслах ажлыг ерөнхий боловсролын сургууль, сумд агентлагуудад 4 удаа зохион байгуулж, үндэсний болон бүсийн уулзалтуудад сайн туршлагаа түгээж* ажилласан.<br><br>Биелэлт 100 | *ЖЭТБХ чиглэлд төр, ИНБ-ын хамтын ажиллагааны хүрээнд бий болсон сайн туршлага нь үндэсний хэмжээнд үлгэр жишээ болж туршлагаа хуваалцсан байна. Тухайлбал Дэлхийн эмэгтэйчүүдийн сан, МОНЭС олон улсын аргачлалд тулгуурлан төр, ИНБ-ын жендэрийн төлөөх хамтын ажиллагааг хөдөлгөөн гэж үзэж тус үйл ажиллагааг үнэлсэн байна. Цаашид ЖЭТБХ дэд хөтөлбөрийн зорилтыг хангах төр, ИНБ, ОУБ хамтарсан төлөвлөгөөт ажлуудыг хэрэгжүүлдэг хандлагыг бий болгох.* |

**ЖЭТБХ дэд хөтөлбөрийн Зорилт 3 "Аймаг орон нутгийн эдийн засгийн хөгжилд ЖЭТ оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эрэгтэй, эмэгтэй хүн тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлэх"-ийн хүрээнд** : 5 үйл ажиллагаа тусгагдсан байна. Үүнд:

**Зорилт 3-ийн 3.3.1-д туссан "Үндэсний хөтөлбөрийн хүрээнд эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсрол, залуу малчдын нөхцөл байдалд хийгдэх жендэрийн судалгаанд тулгуурлаж эрэгтэйчүүд болон хөвгүүдэд зориулсан кабинетыг байгуулан эрүүл мэндийн үзлэг, оношилогоо, сэтгэл зүйн болон бусад үйлчилгээг нэмэгдүүлэх" гэсэн үйл ажиллагааны хүрээнд:**

- Үндэсний хөтөлбөрийн хүрээнд улсын хэмжээнд хийгдэх эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсрол, залуу малчдын нөхцөл байдал хийгдэх жендэрийн судалгаанд тулгуурлаж, эрэгтэйчүүд болон хөвгүүдэд зориулсан кабинетыг байгуулан эрүүл мэндийн үзлэг

оношилгоо сэтгэл зүйн зөвлөгөө болон бусад үйлчилгээг нэмэгдүүлэх; Аймгийн Эрүүл мэндийн газар нь "Өсвөр үе, залуучуудыг эрүүл мэндийг дэмжих" төслийг хэрэгжүүлэн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Политехник коллеж, Ерөнхий боловсролын сургуулийн 14-17 насны 1598 хөвгүүдийг төрөлжсөн мэргэжлийн эмч нарын эрт илрүүлэг үзлэг, шинжилгээнд 100 хувь хамруулан ажилласан бөгөөд энэ үзлэг, шинжилгээнд шаардагдах эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 30 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

- Эрэгтэйчүүдийн тусгай кабинетын үйл ажиллагаа тогтвортой биш, урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо хангалтгүй байгаагаас эрэгтэйчүүд эрүүл мэндийн байдал хүндэрсэн үедээ эмнэлэгт хандаж байна.
- Төр, ИНБ-ууд өөрсдийн нөөц боломжинд тулгуурлан "Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах –нийгмийн дэмжлэг" аяны хүрээнд "Эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд", "Бэлгийн замаар дамжих халдварт өвчин" сэдвээр сургалт зохион байгуулах, эрэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулах,
  төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа ба үүрэг оролцоо" сэдэвт хэлэлцүүлэг, Жендэр болон эрэгтэйчүүдийн асуудлаар эерэг хандлага, зөв зан үйлийг бусдад түгээх, яриа лекц "Эрчүүдээ ярилцъя", "Эерэг хөвгүүд" сэдэвт уулзалт зэрэг төлөвлөгдөөгүй ажлуудыг хийсэн байна.

Дээрх тоо баримтад үндэслэн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн Зорилт 3 "Аймаг орон нутгийн эдийн засгийн хөгжилд ЖЭТ оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эрэгтэй, эмэгтэй хүн тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлэх"-ийн 3.3.1–д туссан "Үндэсний хөтөлбөрийн хүрээнд эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсрол, залуу малчдын нөхцөл байдалд хийгдэх жендэрийн судалгаанд тулгуурлаж эрэгтэйчүүд болон хөвгүүдэд зориулсан кабинетыг байгуулан эрүүл мэндийн үзлэг, оношилогоо, сэтгэл зүйн болон бусад үйлчилгээг нэмэгдүүлэх" үйл ажиллагааны хэрэгжилтэд өгсөн төрийн байгууллагын үнэлгээг ОХШҮ-ний багаас дүгнэвэл:

**Хүснэгт 19. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд төрийн байгууллага ба ОХШҮ-ний багийн өгсөн үнэлгээний харьцуулалт /3.3.1/**

| *Шигтгээ: 3.3.1* | |
|---|---|
| *Төрийн байгууллагын үнэлгээ:* | *ОХШҮ-ний багийн дүгнэлт:* |
| *Тодорхойгүй* | *Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх дараах шалгуур үзүүлэлтүүд хангалтгүй биелэгдсэн байна. Үүнд: 4.1.4-д "Эрэгтэйчүүд судлал, эрэгтэйчүүдэд үзүүлэх цогц үйлчилгээний эхлэл тавигдсан байна"; 4.2.8-д "Эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг кабинет 2019 онд байгуулсан байх" гэсэн заалтууд тус тус хэрэгжээгүй байна.* |

**Зорилт 3 "Аймаг орон нутгийн эдийн засгийн хөгжилд ЖЭТ оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эрэгтэй, эмэгтэй хүн тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлэх"-ийн 3.3.2-т** "Залуу гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон эцэг (эх), амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэн, оюутан залууст чиглэсэн жендэрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлж үр дүнг тодорхойлоход, нийгмийн салбарын хөтөлбөрүүдийн уялдаа холбоог хангаж ажиллах" гэсэн заалтын хүрээнд:

- Орон нутагт 2018-2020 онд Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар нийгэм, эдийн засаг, улс төр, соёл, гэр бүлийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах 16 дэд хөтөлбөр батлагдаж дэд хөтөлбөрийн дээрх заалтыг хангахад дэмжлэг үзүүлэн уялдаа холбоотойгоор хэрэгжиж байна. Тухайлбал аймгийн ЭМГазар нь "Өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийг дэмжих" төслийн хүрээнд аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 14-17 насны 1598 хөвгүүдийг мэргэжлийн эмч нарын эрт илрүүлэг үзлэг, шинжилгээнд хамруулсан байна. Энэхүү үзлэг, шинжилгээнд шаардагдах эмнэлгийн

тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 30 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

- Энэ чиглэлийн хүрээнд хийсэн үйл ажиллагаануудын тогтвортой, үр дүнтэй байдлыг үнэлэх боломжгүй байна. Учир нь нэг удаагийн үйл ажиллагааны тайлан мэдээ хэлбэрээр тайланд туссан байгаа бөгөөд ЖЭТБХ дэд хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлтөд жил бүр тогтвортой тусгагдаагүй байна.

Дээрх тоо баримтад үндэслэн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн Зорилт 3 ”Аймаг орон нутгийн эдийн засгийн хөгжилд ЖЭТ оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эрэгтэй, эмэгтэй хүн тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлэх” зорилтын 3.3.2–т “Залуу гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон эцэг(эх), амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэн, оюутан залууст чиглэсэн жендэрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлж үр дүнг тодорхойлоход, нийгмийн салбарын хөтөлбөрүүдийн уялдаа холбоог хангаж ажиллах” үйл ажиллагааны хэрэгжилтэд өгсөн төрийн байгууллагын үнэлгээг ОХШҮ-ний багаас дүгнэвэл:

**Хүснэгт 20. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд төрийн байгууллага ба ОХШҮ-ний багийн өгсөн үнэлгээний харьцуулалт /3.3.2/**

| *Шигтгээ: 3.3.2* | |
|---|---|
| *Төрийн байгууллагын үнэлгээ:* | *ОХШҮ-ний багийн дүгнэлт:* |
| *Тодорхойгүй* | *Орон нутагт нийгмийн чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдэд ЖЭТБХ тодорхой ажлууд хийгдэж байна. Тухайлбал эмэгтэйчүүдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил хамгааллын хөтөлбөр, залуучуудын, ахмад настны дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд 55.5 сая төгрөгийг зарцуулжээ. Энэ нь ЖЭТБХ дэд хөтөлбөрийн зорилтуудын хэрэгжилтийг хангахад түлхэц болж байна* |

**Зорилт 3 “Аймаг орон нутгийн эдийн засгийн хөгжилд ЖЭТ оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эрэгтэй, эмэгтэй хүн тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлэх”-ийн 3.3.3-т туссан** “Уул уурхайн салбар болон улирлын шинжтэй ажил, хөдөлмөр эрхэлж буй иргэдийн эрүүл мэнд, ахуй нөхцөл, гэр бүлийн амьжиргаа, тогтвортой байдалд жендэрийн дүн шинжилгээ хийж, нөхцөл байдлыг сайжруулах зөвлөмжийг оролцогч талуудад өгөх” тухай заалтын хүрээнд:

- Уул уурхайн салбар болон улирлын шинжтэй ажил, хөдөлмөр эрхэлж буй иргэдийн эрүүл мэнд, ахуй нөхцөл, гэр бүлийн амьжиргаа, тогтвортой байдалд жендэрийн дүн шинжилгээ хийж, нөхцөл байдлыг сайжруулах зөвлөмжийг оролцогч талуудад өгсөн байна. Хэрэгжилтийн хүрээнд дэлхий даяар тархаад байгаа шинэ төрлийн корона вирус Covid-19 цар тахлын улмаас уул уурхайд ажиллагсдын эрүүл мэнд ахуйн нөхцөл, гэр бүлийн амьжиргаа тогтвортой байдалд жендэрийн дүн шинжилгээ хийх ажлыг 2021 онд хийхээр төлөвлөсөн байна.

- Хэдийгээр энэ чиглэлийн үйл ажиллагааг 2021 онд хийхээр төлөвлөсөн байгаа боловч 2021 онд ЖЭТБХ дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлтөд энэ үйл ажиллагаа тусгагдаагүй байна.

Дээрх тоо баримтад үндэслэн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн Зорилт 3 ”Аймаг орон нутгийн эдийн засгийн хөгжилд ЖЭТ оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эрэгтэй, эмэгтэй хүн тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлэх”-ийн 3.3.3–т туссан “Уул уурхайн салбар болон улирлын шинжтэй ажил, хөдөлмөр эрхэлж буй иргэдийн эрүүл мэнд, ахуй нөхцөл, гэр бүлийн амьжиргаа, тогтвортой байдалд жендэрийн дүн шинжилгээ хийж, нөхцөл байдлыг

сайжруулах зөвлөмжийг оролцогч талуудад өгөх" үйл ажиллагааны хэрэгжилтэд өгсөн төрийн байгууллагын үнэлгээг ОХШҮ-ний багаас дүгнэвэл:

**Хүснэгт 21. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд төрийн байгууллага ба ОХШҮ-ний багийн өгсөн үнэлгээний харьцуулалт./3.3.3/**

| *Шигтгээ: 3.3.3* | |
|---|---|
| *Төрийн байгууллагын үнэлгээ:* | *ОХШҮ-ний багийн дүгнэлт:* |
| *Биелэлт 30* | *Энэ чиглэлийн хүрээнд хийгдсэн ажил орон нутагт байхгүй, төрийн байгууллагаас өгсөн 30 онооны тайлбар хангалтгүй байна. Уул уурхайн салбар болон улирлын шинжтэй ажил, хөдөлмөр эрхэлж буй иргэдийн эрүүл мэнд, ахуй нөхцөл, гэр бүлийн амьжиргаа, тогтвортой байдалд жендэрийн дүн шинжилгээ хийж, нөхцөл байдлыг сайжруулах зөвлөмжийг оролцогч талуудад өгөх нь нэн тулгамдсан асуудал болж байна.* |

**Зорилт 3 "Аймаг орон нутгийн эдийн засгийн хөгжилд ЖЭТ оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эрэгтэй, эмэгтэй хүн тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлэх"-ийн 3.3.4-т туссан** "Төр, хувийн хэвшлийн ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгох, эрэгтэй, эмэгтэй ажилтанд адил хэмжээний хөлс олгох, иргэнийг ажилд авахад хүйсээр ялгаварлахгүй байх, ажлын байран дахь хүчирхийллээс сэргийлэх ажлыг Төр, Иргэний нийгмийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх" тухай заалтын хүрээнд:

- Төр, хувийн хэвшлийн ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгох, эрэгтэй, эмэгтэй ажилтанд адил хэмжээний хөлс олгох, иргэнийг ажилд авахад хүйсээр ялгаварлахгүй байх, ажлын байран дахь хүчирхийллээс сэргийлэх ажлыг Төр, Иргэний нийгмийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх, иргэнийг ажилд авах, адил хэмжээний цалин хөлс олгох хүйсээр ялгаварлахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хариуцлагыг чангатгах асуудлыг аймгийн төрийн захиргааны байгууллагуудын дотоод журамд тусгуулах ажлуудыг үе шаттайгаар тусгуулахаар жендэрийн салбар хорооноос оны эхэнд чиглэл хүргүүлсэн байна.
- Жилийн эцсийн байдлаар ирүүлсэн тайлангуудад дүн шинжилгээ хийхэд тодорхой ахиц гарсан байна. Тухайлбал: Аймгийн Засаг даргын Тамгын газраас төрийн захиргааны байгууллагуудыг манлайлан ажиллах талаар удирдах ажилтнуудад танилцуулга хийсний үр дүнд ерөнхий боловсролын 18 сургууль хүйсээр ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллагын ажилтнуудад яриа таниулга, мэдээллийн хэрэгслээр шторк явуулах зэргээр үр дүнтэй ажлуудыг хийсэн. Канадын Элчин Сайдын Яам, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Монголын Эмэгтэйчүүдийн сан, орон нутгийн Иргэний нийгмийн байгууллагуудын зөвлөл зэрэг 12 төрийн бус байгууллага, 16 төрийн байгууллага жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр идэвхтэй хамтран ажиллаж байна хэмээн тайланд дурьдсан байна.
- Хэдийгээр ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгох, эрэгтэй, эмэгтэй ажилтанд адил хэмжээний хөлс олгох, иргэнийг ажилд авахад хүйсээр ялгаварлахгүй байх, ажлын байран дахь хүчирхийллээс сэргийлэх чиглэл өгч ажилласан хэдий ч бас л үр дүнг хэмжээгүй, нөхцөл байдалд үнэлгээ хийгээгүй, ЖЭТБХ дэд хөтөлбөрийн зорилттой уялдуулан сайжруулах арга зүйн дэмжлэг, зөвлөмжийг хүргэж ажиллаагүй байна.

Дээрх тоо баримтад үндэслэн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн Зорилт 3 "Аймаг орон нутгийн эдийн засгийн хөгжилд ЖЭТ оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эрэгтэй, эмэгтэй хүн тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлэх"-ийн 3.3.4–т туссан "Төр, хувийн хэвшлийн ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгох, эрэгтэй, эмэгтэй ажилтанд адил хэмжээний хөлс олгох, иргэнийг ажилд авахад хүйсээр ялгаварлахгүй байх, ажлын байран дахь хүчирхийллээс

сэргийлэх ажлыг Төр, Иргэний нийгмийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх" үйл ажиллагааны хэрэгжилтэд өгсөн төрийн байгууллагын үнэлгээг ОХШҮ-ний багаас дүгнэвэл

**Хүснэгт 22. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд төрийн байгууллага ба ОХШҮ-ний багийн өгсөн үнэлгээний харьцуулалт /3.3.4/**

| *Шигтгээ: 3.3.4* | |
|---|---|
| *Төрийн байгууллагын үнэлгээ:* | *ОХШҮ-ний багийн дүгнэлт:* |
| *Биелэлт 100* | *Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд 4.2.5-д хөдөлмөрийн мөлжлөг, ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх заалтыг дотоод журамдаа тусгасан ААНБ-ын хүрэх түвшин 35 байхаар тогтоосон боловч хувийн хэвшлийн байгууллагад хэрэгжсэн тухай мэдээлэл огт байхгүй байна. Иймд энэхүү асуудлыг тодруулах судлах шаардлагатай байна* |

**Зорилт 3 "Аймаг орон нутгийн эдийн засгийн хөгжилд ЖЭТ оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эрэгтэй, эмэгтэй хүн тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлэх"-ийн 3.3.5-д туссан** "Хүн амын нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын талаар орон нутгийн статистик мэдээллийн нэгдсэн санд хүйсээр ангилсан судалгааны нэр төрөл, тоог нэмэгдүүлж, хөгжлийн бодлого төлөвлөлтөд хэрэглээ болгох" арга хэмжээний хүрээнд:

- Хүн амын нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын талаар орон нутгийн статистик мэдээллийн нэгдсэн сан хүйсээр ангилсан судалгааны нэр төрөл, тоог нэмэгдүүлж, хөгжлийн бодлого төлөвлөлтөд хэрэглээ болгох; Үндэсний статистикийн хорооны батлагдсан журам, маягтын дагуу хүн амын нас хүйсээр ангилсан мэдээллийг тогтмол ашиглагддаг бөгөөд аймгийн Олон улсын байгууллагууд болон орон нутгийн Иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөлтэй хамтран "Талоны бараа авдаг иргэдийн эрүүл мэнд", "Байгууллагын түншлэл хамтын ажиллагаа" – г тандах зорилгоор судалгааны ажил хийгдэж дүгнэлтийг олон нийт, төрийн байгууллагын төлөөлөлд танилцуулан судалгааны нэр төрөл, тоог нэмэгдүүлэн байгууллагын бодлого төлөвлөлт үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна. Хүн амын нийгэм эдийн засаг улс төр, соёлын талаар орон нутгийн статистик мэдээллийн санд хүйсээр ангилсан судалгааны нэр төрөл тоо нь 2017 онд 15 байсан бол 2019 онд 20 болж өссөн үзүүлэлттэй байгааг тайланд дурджээ.
- Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийн 4.2.4-т орон нутгийн түвшинд хүйсээр ангилсан статистик үзүүлэлтүүдийн суурь түвшин 15-ийг 2019 онд 20 болон өссөн тухай тайланд туссан байна.

Дээрх тоо баримтад үндэслэн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн Зорилт 3 "Аймаг орон нутгийн эдийн засгийн хөгжилд ЖЭТ оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эрэгтэй, эмэгтэй хүн тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлэх"-ийн 3.3.5–д туссан "Хүн амын нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын талаар орон нутгийн статистик мэдээллийн нэгдсэн сан хүйсээр ангилсан судалгааны нэр төрөл, тоог нэмэгдүүлж, хөгжлийн бодлого төлөвлөлтөд хэрэглээ болгох" үйл ажиллагааны хэрэгжилтэд өгсөн төрийн байгууллагын үнэлгээг ОХШҮ-ний багаас дүгнэвэл:

**Хүснэгт 23. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд төрийн байгууллага ба ОХШҮ-ний багийн өгсөн үнэлгээний харьцуулалт /3.3.5/**

| *Шигтгээ: 3.3.5* | |
|---|---|
| *Төрийн байгууллагын үнэлгээ:* | *ОХШҮ-ний багийн дүгнэлт:* |
| *Хүн амын нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын талаар орон нутгийн статистик мэдээллийн нэгдсэн сан хүйсээр ангилсан судалгааны нэр төрөл, тоо нь 2017 онд 15 байсан бол 2019 онд 20 болж өссөн байна.*<br>*Биелэлт 100* | *Орон нутгийн түвшинд хүйсээр ангилсан статистик үзүүлэлтүүдийн 2020 онд хүрэх түвшинг 30-аас доошгүй байхаар төлөвлөсөн хэдий ч энэ тоо хэмжээнд хүрэхгүй байна. Мөн орон нутгийн статистик мэдээллийн нэгдсэн сан хүйсээр ангилсан мэдээллийн нэр төрөл, түүнийг хөгжлийн бодлого төлөвлөлтөд хэрхэн ашиглаж буй мэдээ, тайлан байхгүй байна.* |

**ОХШҮ-ний үр дүн:**

- Аймгийн ЗД-ын 2018 оны А/349, 2019 оны А/72, 2020 оны А/96 дугаар захирамжуудад ЖЭТБ-ыг хангах дэд хөтөлбөрийн 3 зорилтын хүрээнд 15 чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар тусгагдсан;
- ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хүрээнд 2018-2019 онд Зорилт 1 “Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх”-ийн хүрээнд тусгагдсан 5 төрлийн ажлаас 3 төрлийн ажилд 8 сая төгрөг;
- ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хүрээнд 2018-2019 онд Зорилт 2 “Төр ИНБ-н түншлэлийн хүрээнд орон нутгийн тогвортой хөгжлийг дэмжсэн жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх”-ийн хүрээнд тусгагдсан 5 төрлийн ажлаас 1 төрлийн ажилд 7,6 сая төгрөг;
- ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хүрээнд 2018-2019 онд Зорилт 3 “Аймаг орон нутгийн эдийн засгийн хөгжилд ЖЭТ оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эрэгтэй, эмэгтэй хүн тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлэх”-ийн хүрээнд тусгагдсан 5 төрлийн ажлаас 1 төрлийн ажилд 400 000 төгрөг;
- ЖЭТБХ дэд хөтөлбөрийн зорилтуудын хүрээнд төлөвлөж хийсэн ажлуудаас харахад зардлын хувиарлалт харилцан адилгүй байна. Тухайлбал: Жендэрийн талаарх сургалт мэдээлэл болон ЖЭТБ хангах дэд хөтөлбөрийг сурталчлах, хэрэгжилтийг тайлагнах зэрэг ажлуудад түлхүү зардал хуваарилагдаж, харин хүн амын бүлгүүд (залуу гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эрэгтэйчүүд болон хөвгүүд, уул уурхайн болон улирлын чанартай ажил эрхэлж буй иргэд, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид ажиллаж буй иргэд, залуу малчид) чиглэсэн хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлыг сайжруулах, дүн шинжилгээ хийх зэрэг ажилд зардал төсөвлөөгүй байна.

**ЖЭТБХ дэд хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийг тоон үзүүлэлтээр харуулбал:**

**График 2. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн зорилтуудыг хангах үйл ажиллагааны чиглэлийн хэрэгжилт /тоо/**




“ДОРНОД АЙМГИЙН ЖЭТБ-ЫГ ХАНГАХ ДЭД ХӨТӨЛБӨР”-ИЙН ХЭРЭГЖИЛТЭНД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ
/Төрийн байгууллага болон ОХШҮ-ний баг/

| № | Зорилт | Үйл ажиллагаа | Төрийн байгуулагын үнэлгээ /0-100 хувь/ | ОХШҮ-ний багийн үнэлгээ /0-100 хувь/ |
|---|---|---|---|---|
| 1 | **Зорилт 1:** Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа, | 1.1 Сургуулийн өмнөх насны хүүхдийн хүчирхийлэлгүй орчинг дэмжих, хүүхэд, өсвөр нас, оюутан залуус, гэр бүлд жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах | 100 хувь | 80 хувь |
| | | 1.2 “Аз жаргал төв”, гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийн сургалт, зөвлөн туслах | 100 хувь | 80 хувь |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх | үйлчилгээнд жендэр судлал, нөхөн үржихүй, эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, гэр бүл судлал, охид эмэгтэйчүүдийг хүний наймаа, бэлгийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх сургалт судалгаа, нөлөөллийн үйл ажиллагаар тусгах | | |
| | | 1.3 Орон нутгийн төрийн удирдах албан тушаалтан, төрийн албан хаагчид болон аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд зориулсан жендэрийн сургалтуудыг зохион байгуулах, орон нутгийн сургагч багш нарыг чадавхжуулах | 100 хувь | 80 хувь |
| | | 1.4 Орон нутгийн иргэдийн амьжиргаа, хүний хөгжлийг тодорхойлдог шалгуур үзүүлэлтүүдийн талаарх төрийн байгууллагууд болон олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлж, хэрэглээ болгох ажлуудыг зохион байгуулах | 70 хувь | 60 хувь |
| | | 1.5 Бүх нийтийн жендэрийн мэдлэгийг нэмэгдүүлэхэд орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах | 100 хувь | 100 хувь |
| **Зорилт 1-ын дундаж үнэлгээ** | | | **94 хувь** | **80 хувь** |
| | Зорилт 2:<br>Төр, Иргэний нийгмийн байгууллагын түншлэлийн хүрээнд орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжсэн жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсөвлөлтийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх | 2.1 Аймгийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд нь салбар бүртээ, зүүн бүс аймаг, орон нутгийн урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, салбарын жендэрийн нэгдсэн бодлого, үндэсний болон орон нутгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй болох | 100 хувь | 100 хувь |
| | | 2.2 Аймаг, сумын хөгжлийн бодлого, байгууллагуудын хөгжлийн төлөвлөгөө, байгууллагын дотоод журам, хүний нөөцийн бодлого, хөтөлбөр, төслийг жендэрийн мэдрэмжтэй үзэл баримтлалыг нэвтрүүлэх | 100 хувь | 100 хувь |
| | | 2.3 Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах байрны үйл ажиллагааг чанаржуулж, жендэрт суурилсан хүчирхийллийн бүх хэлбэрт өртсөн хохирогчдын тоог эрс бууруулах | 100 хувь | 100 хувь |
| | | 2.4 Аймаг сумын хэмжээнд ажиллах эрүүл мэнд-сэтгэл зүй-эрх зүйн зөвлөгөөг өгөх бүтэц, гэр бүл судлаач, сэтгэл зүйч болон хүний нөөцийг бэлтгэх, гэр бүлийн үнэ цэнэ, хамтын амьдралын утга учир, эцэг эхийн хамтын үүрэг хариуцлагыг таниулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ зохион байгуулах | 100 хувь | 100 хувь |
| | | 2.5 Орон нутгийн ТББ, Иргэний нийгмийн байгууллагатай хамтран, “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт, ЖЭТБ-ыг хангах үндэсний хөтөлбөр, аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад зөвлөн туслах, сайн туршлагыг түгээх ажлуудыг зохион байгуулах | 100 хувь | 100 хувь |
| **Зорилт 2-ын дундаж үнэлгээ** | | | **100 хувь** | **100 хувь** |
| | | 3.1 Үндэсний хөтөлбөрийн хүрээнд улсын хэмжээнд хийгдэх эрэгтэйчүүдийн эрүүл | 70 хувь | 50 хувь |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Зорилт 3:<br>Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлого, хөтөлбөрт жендэрийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлэх | мэнд, боловсрол, залуу малчдын нөхцөл байдалд хийгдэх жендэрийн судалгаанд тулгуурлаж, эрэгтэйчүүд болон хөвгүүдэд зориулсан кабинетийг байгуулан эрүүл мэндийн үзлэг оношилгоо сэтгэл зүйн зөвлөгөө болон бусад үйлчилгээг нэмэгдүүлэх | | |
| | | 3.2 Залуу гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон эцэг (эх), амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэн, оюутан залууст чиглэсэн жендэрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлж үр дүнг тодорхойлох, нийгмийн салбарын хөтөлбөрүүдийн уялдаа холбоог хангаж ажиллах | 100 хувь | 100 хувь |
| | | 3.3 Уул уурхайн салбар болон улирлын шинжтэй ажил, хөдөлмөр эрхэлж буй иргэдийн эрүүл мэнд, ахуй нөхцөл, гэр бүлийн амьжиргаа, тогтвортой байдалд жендэрийн дүн шинжилгээ хийж, нөхцөл байдлыг сайжруулах зөвлөмжийг оролцогч талуудад өгөх | 30 хувь | 20 хувь |
| | | 3.4 Төр, хувийн хэвшлийн ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгох, эрэгтэй, эмэгтэй ажилтанд адил хэмжээний хөлс олгох, иргэнийг ажилд авахад хүйсээр ялгаварлахгүй байх, ажлын байран дахь хүчирхийллээс сэргийлэх ажлыг Төр, Иргэний нийгмийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх | 100 хувь | 60 хувь |
| | | 3.5 Хүн амын нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын талаар орон нутгийн статистик мэдээллийн нэгдсэн санд хүйсээр ангилсан судалгааны нэр төрөл, тоог нэмэгдүүлж, хөгжлийн бодлого төлөвлөлтөнд хэрэглээ болгох | 70 хувь | 70 хувь |
| **Зорилт 3-ын дундаж үнэлгээ** | | | **74 хувь** | **60 хувь** |
| **Нийт үнэлгээ** | | | **89,3 хувь** | **80 хувь** |

## 3.2 ОРОЛЦОО НЫ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Дорнод аймгийн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хүрээнд “Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн ажил олгогч, ажиллагсдын ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг болон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, ажлын байрны нөхцөл байдал, “Эрэгтэйчүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж”-ийг орон нутгийн жендэрийн тулгамдсан асуудал хэмээн үзэж ОХШҮ-ний ажлыг хийж гүйцэтгэлээ.

Оролцооны үнэлгээний ажлын үр дүнг сонгож авсан хоёр асуудлын хүрээнд асуулга, бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагуудыг зохион байгуулсан тул үр дүнгийн танилцуулгыг хоёр хэсэгт ангилсан. Үүнд:

3.2.1. **Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн ажил олгогч болон ажиллагсдын ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг, жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, ажлын байрны нөхцөл:**

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 59.5 хувь нь дээд, 25 хувь нь бүрэн дунд, 10.7хувь нь тусгай дунд, 3.6 хувь нь бүрэн бус дунд, 1 хувь нь бага боловсролтой иргэд эзэлсэн байна. Харин судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн хувьд 66.7 хувь нь дээд, 9.5

хувь нь тусгай дунд 9.5 хувь нь, 9.5 хувь нь бүрэн бус дунд, 4.8 хувь нь бага боловсролтой байна. Үүнийг эрхэлж буй ажилтай нь харьцуулан харвал:

Хүснэгт 24. Боловсролын түвшин ба эрхэлж буй ажил /хүйсээр, хувиар/

| Боловсрол | Нарийн мэргэжлийн | Удирдах ажилтан | Бусад | Үйлчилгээний | Туслах | Гэрээт |
|---|---|---|---|---|---|---|
| Эмэгтэй | | | | | | |
| Дээд | 20 | 12 | 28 | 30 | 6 | 4 |
| Бүрэн бус дунд | | 66.7 | | | 33.3 | |
| Бүрэн дунд | 14.3 | | 19.1 | 61.9 | 4.8 | |
| Тусгай дунд | 11.1 | | 11.1 | 55.6 | 11.1 | 11.1 |
| Бага | | | | 100 | | |
| Эрэгтэй | | | | | | |
| Дээд | 35.7 | 35.7 | 28.6 | | | |
| Бүрэн бус дунд | | | | 50 | 50 | |
| Бүрэн дунд | | | | | 50 | 50 |
| Тусгай дунд | 50 | | | 50 | | |
| Бага | | | | 100 | | |

Мөн насаар нь ангилж гэр бүлийн байдал, ам бүлийн тоотой харьцуулан үзвэл:

**Хүснэгт 25. Насны ангилал ба ам бүлийн тоо/ хүйсээр, хувиар/**

| | Бэлэвсэн | Гэрлэсэн | Гэрлээгүй | Салсан | Ам бүл |
|---|---|---|---|---|---|
| Эмэгтэй | | | | | |
| 18-25 нас | | 6 | 6 | 1.2 | 4 |
| 26-35 нас | | 20.3 | 6 | 2.4 | 4 |
| 36-45 нас | | 29.8 | 3.6 | 1.2 | 5 |
| 46-60 нас | 2.4 | 16.7 | 1.2 | 2.4 | 4 |
| 61-аас дээш нас | | 1.2 | | | 2 |
| Эрэгтэй | | | | | |
| 18-25 нас | | 4.8 | | | 3 |
| 26-35 нас | | 28.6 | | | 5 |
| 36-45 нас | | 33.3 | | | 5 |
| 46-60 нас | | 23.8 | 4.8 | 4.8 | 3 |

Судалгаанд дурдагдсан ажлын байрны бусад гэсэн сонголтын 29.8 хувь буюу хамгийн их хувийг эмэгтэйчүүд эзлэж байгаа ба хувийн өмчит уул уурхайн аж ахуйн нэгжид гэсэн сонголтыг эрэгтэйчүүдийн дийлэнх нь буюу 47.6 хувь нь сонгожээ.

**Хүснэгт 26. Ажил эрхэлж буй салбар ба албан тушаал /хүйсээр/**

| *Ажлын байр* | *Бусад* | *Нийтийн хоол* | *Нийтийн худалдаа* | *Орон нутгийн өмчит аж ахуйн төрийн үйлчилгээний газар* | *Төрийн өмчит уул уурхайн аж ахуйн нэгж* | *Төрийн өмчит ХХК* | *Хувийн өмчит уул уурхайн аж ахуйн нэгж* |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Эмэгтэй** | | | | | | | |
| Бусад | 9.5 | 1.2 | | 1.2 | 1.2 | 2.4 | 7.1 |
| Гэрээт | | | | | | 2.4 | 1.2 |
| Нарийн мэргэжлийн | 3.6 | | | | | 9.5 | 3.6 |
| Туслах | 1.2 | 2.4 | | | | 3.6 | 0.0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Удирдах ажилтан | 1.2 | | | | | 3.6 | 2.4 |
| Үйлчилгээний | 14.3 | 1.12 | 1.2 | 11.9 | 2.4 | 7.2 | 4.8 |
| ***Нийт дундаж*** | ***29.8*** | ***4.8*** | ***1.2*** | ***13.1*** | ***3.6*** | ***28.6*** | ***19.1*** |
| **Эрэгтэй** | | | | | | | |
| Бусад | 4.8 | | | | | 9.5 | 4.8 |
| Гэрээт | | | | | | | 4.8 |
| Нарийн мэргэжлийн | 4.8 | | | | 4.8 | 9.5 | 9.5 |
| Туслах | | | | | | | 9.5 |
| Удирдах ажилтан | 9.5 | | | | | 9.5 | 4.8 |
| Үйлчилгээний | | | | | | | 14.3 |
| ***Нийт дундаж*** | ***19.1*** | | | | ***4.8*** | ***28.6*** | ***47.6*** |

Жендэр хэмээх ойлголтыг аль нь илэрхийлж байна вэ?

График 3. Иргэдийн жендэрийн тухай ойлголт




Судалгаанд хамрагдсан иргэд жендэрийн тухай “Нийгэм дэх эрэгтэй эмэгтэй хүмүүсийн тэгш эрх, тэгш боломж, тэш оролцоо, тэгш байдал, эрх тэгш шийдвэрийн тухай ойлголт”-51.9 хувь, “Хаана ч эрэгтэй, эмэгтэй хүмүүс тооны хувьд тэнцвэртэй байлгах тухай ойлголт”-17.6хувь, “Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах тухай ойлголт”-15.1хувь, “Эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшин дэх оролцоог нэмэгдүүлэх тухай ойлголт”-9.8 хувь, “Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгэм, соёлын ялгаатай болохыг тайлбарласан ойлголт”-3.7 хувь гэж тус тус хариулсан байна. Судалгаанд оролцогчдын жендэрийн тухай мэдлэг, боловсролын түвшингийн хамаарал шууд хамааралтай байна.

“Нийгэм дэх эрэгтэй эмэгтэй хүмүүсийн тэгш эрх, тэгш боломж, тэгш оролцоо, тэгш байдал, эрх тэгш шийдвэрийн тухай“ ойлголт юм гэж асуулгад оролцсон дээд боловсролтой иргэдийн 40 хувь нь үзсэн байна. Харин энэ асуултанд боловсролгүй иргэдийн 1 хувь, бүрэн бус дунд боловсролтой иргэдийн 1 хувь, бүрэн дунд боловсролтой иргэдийн 9.52 хувь, тусгай дунд боловсролтой иргэдийн 2,9 хувь нь тус тус зөв хариултыг өгсөн байна. Эндээс харахад боловсролын түвшин дээгүүр хүмүүсийн мэдлэг ойлголт бусдаасаа илүү байгаа нь харагдаж байна. Боловсрол багатай иргэдийн Жендэрийн талаарх ойлголт мэдлэг хангалтгүй байгаа нь дээрхи судалгаанаас харагдаж байгаа юм.

*Хүснэгт 27 Жендэрийн тухай ойлголт/хүйсээр,хувиар/.*

| Бодомж | Эмэгтэй | | Эрэгтэй | |
|---|---|---|---|---|
| | Буруу | Зөв | Буруу | Зөв |
| Залуу эмэгтэйчүүд жирэмсэн болж, хүүхэдтэй болох тул ажилд авах хэрэггүй | 39.0 | 4.4 | 36.2 | 10.8 |
| Өрхийн тэргүүн эрэгтэй хүнийг илүү хүндэтгэх ёстой. | 12.5 | 43.4 | 21.3 | 29.7 |
| Сайн эхнэр бол нөхрийнхөө үгэнд орох ёстой | 29.5 | 18.4 | 29.8 | 18.9 |
| Эр хүн бол өрх гэр бүлээ авч явагч, тэжээгч | 19.0 | 33.8 | 12.8 | 40.5 |

Судалгаанд хамрагдсан иргэд “Залуу эмэгтэйчүүд жирэмсэн болж, хүүхэдтэй болох тул ажилд авах хэрэггүй” хэмээх бодомжийг эрэгтэйчүүдийн 36.2 хувь, эмэгтэйчүүдийн 39 хувь нь буруу ойлголт, “Өрхийн тэргүүн эрэгтэй хүнийг илүү хүндэтгэх ёстой” гэсэн бодомжийг

эрэгтэйчүүдийн 29.7, эмэгтэйчүүдийн 43 хувь нь зөв ойлголт, "Сайн эхнэр бол нөхрийнхөө үгэнд орох ёстой" гэсэн бодомжийг эрэгтэйчүүдийн 29.5 хувь, эмэгтэйчүүдийн 29.8 хувь нь буруу бодомж, "өрхийн тэргүүн эрэгтэй хүнийг илүү хүндэтгэх ёстой" бодомжийг эрэгтэйчүүдийн 33.9 хувь, эмэгтэйчүүдийн 40.5 хувь нь зөв ойлголт гэж үзэж байна. Эндээс судалгаанд хамрагдсан иргэд эмэгтэй, эрэгтэй ялгаагүй эцгийн эрх ёсыг баримталж эрэгтэй хүмүүс илүү хариуцлага үүрэх ёстой гэж үзсэн байна.
Жендэрийн эрх тэгш байдлыг хангах нь таны амьдралд хэр нөлөөтэй гэж үзэж байна вэ?

График 4 .Нийгэмд ЖЭТБХ нь хувь хүний амьдралд үзүүлэх нөлөөллийн талаарх төсөөлөл




Жендэрийн эрх тэгш байдлыг хангах нь иргэдэд эерэг нөлөөтэй гэж 69.6 хувь нь үзсэн бол ямар ч нөлөөгүй гэж 8.7 хувь нь үзсэн байна. Мөн энэ асуудлыг мэдэхгүй гэж хариулсан хүн 21.8 хувь нь байна. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн дийлэнх нь жендерийн эрх тэгш байдал нийгэмд хангагдах нь хувь хүний амьдралд эерэг нөлөөтэй гэж үзсэн байна.

Хувийн хэвшлийн байгууллага болон аж ахуйн нэгжийн ажилчдын ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг болон ажлын байрны нөхцөл байдал, хөдөлмөрийн харилцаанд тулгарч буй жендэрийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх тухай бүлгийн ярилцлагын явцад "Жендэр болон жендэрийн ялгаварлан гадуурхалт-ын талаарх ойлголт мэдлэг тааруу гэж өөрсдийгөө үнэлсэн бол орон нутагт ЖЭТБ хангах дэд хөтөлбөр хэрэгжиж байгаа талаар ихэнх нь мэдэхгүй байв. Мөн эрэгтэй хүн ажлаа хийж гэр бүлээ авч явах, эмэгтэй хүн хүүхдээ асрах, гэр орны ажлаа хийх ёстой" гэсэн жендэрийн хэвшмэл ойлголт байсаар байгааг онцолжээ.

Байгууллагын хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлын шалгуур үнэлгээг 1-5 оноогоор сэтгэл ханамжийг 1 маш муу, 2 муу, 3 дунд, 4 сайн, 5 маш сайн гэсэн хэмжилтээр үнэлсэн.

***Хүснэгт 28 Хөдөлмөрийн харилцаан дахь ЖЭТБ хангаж буйг үнэлсэн байдал***

| Үзүүлэлтүүд | Эмэгтэй | Эрэгтэй | Дундаж |
|---|---|---|---|
| Ажил, ар гэрийн тэнцвэрийг хангах зохицуулалт | 3.5 | 3.4 | 3.4 |
| Ажлын ачааллын тэнцвэржүүлэлт | 3.7 | 3.6 | 3.6 |
| Ажлын байрандаа хөгжих боломж | 3.5 | 3.7 | 3.6 |
| Албан тушаал ахих боломж | 3.4 | 3.5 | 3.4 |
| Мэдээллийн ил тод байдал | 3.7 | 3.6 | 3.6 |
| Нийгмийн хамгааллын тусламж дэмжлэг хүртэх | 3.6 | 3.5 | 3.6 |
| Үзэл бодлоо илэрхийлэх | 3.5 | 3.6 | 3.6 |
| Хөдөлмөрийн эрүүл, аюулгүй байдал | 4.0 | 3.9 | 3,9 |
| Шударгаар хөдөлмөрөө үнэлүүлэх, шагнал, урамшуулал авах | 3.5 | 3.7 | 3.6 |

| | | | |
|---|---|---|---|
| Эрүүл мэндийг хамгаалах дэмжлэг | 3.9 | 3.9 | 3.9 |

Судалгаанд хамрагдсан иргэд өөрийн ажиллаж буй байгууллагынхаа жендэрийн эрх тэгш байдлын шалгуурыг дунд буюу 3.6 гэж дүгнэсэн байна. Мөн хүйсээр нь харвал эмэгтэйчүүд “хөдөлмөрийн эрүүл, аюулгүй байдал”-ыг 4.0 буюу сайн, эрэгтэйчүүд 3.9 буюу дунд гэж тус тус үнэлжээ. Ганцаарчилсан ярилцлагад оролцогчид орон нутгийн хувийн хэвшлийн байгууллагууд ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгоход санаачилга гаргаж ажиллахгүй байгаа, байгууллагын дотоод журамд энэ тухай заалт хангалттай тусгагдаагүй, аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн байгууллагын  шийдвэр гаргах субъект нь жендэрийн тухай ойлголттой байж төсвийг зөв хуваарилах, ажлын байран дахь жендэрийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд анхаарах шаардлагатай байгааг анхааруулжээ. Харин орон нутагт хувийн хэвшлийн байгууллага болон төрийн байгууллагын ажилтан албан хаагчдад зориулсан сургалтуудыг зохион байгуулж бүх талын оролцоог хангахад анхаарч байгаа ч төрийн байгууллагын бодлого, үйлчилгээ жендэрийн мэдрэмж муутай, хувийн хэвшлийн байгууллагын удирдлага, ажилчид жендэрийн эрх тэгш байдлын тухай ойлголт мэдлэг хангалтгүй байна гэж иргэд үнэлсэн.

*Шигтгээ:1*
***….** Хувийн хэвшлийн байгууллагуудын 70-80 хувь нь дотоод журамдаа жендэрийн эрх тэгш байдлыг хангах заалт, зарчмуудыг тусгаагүй байсан.*

Мөн бүлгийн ярилцлагын явцад хувийн хэвшил, аж ахуйн нэгж байгууллагын дотоод журам, хамтын гэрээ болон хөдөлмөрийн гэрээнд ЖЭТБХ тухай туссан байдлыг тодруулж асуухад оролцогчдын ихэнх нь хариулж чадахгүй байсан. Орон нутгийн хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлыг төрийн албан хаагчид боломжийн гэж үнэлсэн бөгөөд дараах тайлбаруудыг өгч байв.

2019 оноос эхлэн ХЭҮК-ын орон нутгийн салбарын ажилтан Дорнод аймгийн хэмжээнд ажлын байрны дарамт, хөдөлмөрийн харилцааны маргаантай байдлыг тодорхойлох судалгаа хийсэн, одоогоор  ноцтой зөрчил илрээгүй, төрийн байгууллагууд хөдөлмөрийн дотоод журамдаа тодорхой заалтууд тусгаж хэрэгжүүлж байгаа, зарим байгууллагад жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн ажиллаж, энэ чиглэлээр уулзалт, хэлэлцүүлэг, сургалтууд зохион байгуулагдан төрийн албан хаагчид хамрагддаг, албан бичиг хөтлөх болон бусад бүх үйл ажиллагаанд жендэрийн мэдрэмжтэй байхад анхаарч, хүний эрхийг хамгаалсан 500 гаруй хуулийн хэрэгжилтэд төр хяналтаа тавьж ажиллаж байна гэсэн тайлбаруудыг өгсөн байна.

Төрийн албан хаагчидтай хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдал орон нутагт ямар түвшинд байгааг хэлж мэдэхгүй, энэ чиглэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн илүү мэдээлэлтэй байдаг гэж хэлсэн бол  орон нутагт хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдал алдагдсан, тэнцвэрт бус байдал үүссэн, ажилд ороход ялгавартай хандах байдал байсаар байна гэж онцлон хэлсэн байна. Харин иргэдийн төлөөлөл энэхүү асуултад хариулт өгөхдөө ИТХ болон гүйцэтгэх засаглалд шударга бус байдал их гардаг, орон нутгийн шийдвэр гаргах түвшинд болон хөдөлмөр эрхлэлтийн салбарт хүйсийн тэгш харьцаа алдагдсан, иргэд жендэрийн тухай ойлголтыг зөвхөн нэг хүйсийн эрхийн асуудал гэж хардаг, орон нутгийн төрийн ба төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд ЖЭТБ хангах үйл ажиллагаа явагдаж байна гэжээ.

Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлыг ярилцлагад оролцсон төрийн албан хаагчид судалгаа, бодлогын баримт бичигт туссан байдал түүний хэрэгжилттэй холбож боломжийн түвшинд байгаа гэж дүгнэсэн  бол иргэдийн төлөөлөл хүйсийн харьцаа,  шударга байдалтай уялдуулж  төрийн энэ чиглэлийн бодлого алдагдсан гэж үнэлж байв.

*Шигтгээ: 2*
*....Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого алдагдсан, төлөвлөгдсөн зүйл хэрэгждэггүй. Жишээлбэл хөдөлмөрийн харилцаатай нэг ийм жишээ байна. ЭЕШ-ын дараа мэргэжил сонгох үед хүйс заах тохиолдол гарч байсан....*
*/Ганцаарчилсан ярилцлагаас-52 настай, эмэгтэй/*

Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам дахь хэм хэмжээ

**Хүснэгт 29. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам дахь ЖЭТБ-ыг хангах хэм хэмжээ**

| Үзүүлэлт | Эзлэх хувь |
|---|---|
| Ар гэр, хүүхдийн асуудлаар чөлөө авах тухай | 29.7 |
| Мэдэхгүй | 16.6 |
| Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаархи ажил олгогч болон ажилтны эрх үүрэг хариуцлагын тухай | 13.1 |
| Иргэнийг ажилд авахад хүйсээр ялгаварлахгүй байх тухай | 11.7 |
| Ажлын байранд жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах тухай | 7.6 |
| Уурхайн ААН-н хувьд амьдрах байр, кемпээр хангах тухай | 6.2 |
| Уурхайн ААН-ийн хувьд хүйсээр ангилсан ариун цэврийн өрөөгөөр хангах тухай | 5.5 |
| Уурхайн ААН-ийн хувьд эрэгтэй, эмэгтэй ажилтны росторыг ялгаатай тогтоох тухай | 5.5 |
| Дээрх бүгд тусгагдаагүй | 4.1 |

Асуулгад хариулсан байдлаас ажилчдын ар гэр, хүүхдийн асуудлаар чөлөө авах асуудлыг дотоод журмандаа тусгасан байдаг гэж 29.7 хувь, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаархи ажил олгогч болон ажилтны эрх үүрэг хариуцлагын тухай асуудлыг тусгасан гэж 13.1 хувь, Иргэнийг ажилд авахад хүйсээр ялгаварлахгүй байх тухай 11.7 хувь нь байгууллагын хөдөлмөрийн харилцаанд тусгасан гэж хариулсан байна. Гэтэл судалгаанд хамрагдсан иргэдийн 4.2 хувь нь дээрх бүх асуудлууд тусгагдаагүй гэж үзжээ. Үүнийг байгууллагаар нь ангилан үзвэл Төрийн өмчийн ХХК болон Хувийн өмчит уул уурхайн байгууллага, нэгжүүд байна.

**График 5. Байгууллагын хамтын гэрээ, хэлэлцээрт туссан хэм хэмжээ.**




Байгууллагын хамтын гэрээ, хэлэлцээрт хөдөлмөрийн аюулгүй нөхцөлд ажиллах, хүүхэд төрүүлэх, асрах нөхцөл бололцоо олгох, эрүүл мэнддээ анхаарах, хамгаалах, ижил ажилд цалин, нэмэгдэл хөлс ижил хэмжээгээр тогтоох зэрэг асуудлууд голчлон туссан байдгыг нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 77.2 хувь нь үзсэн байна. Тэгвэл асуудал шийдэхэд талуудын оролцоог хангах, санал авах, эмэгтэй, эрэгтэй ажилтанд ажил, гэр бүлийн үүргээ хослуулах тухай асуудлуудыг судалгаанд хамрагдсан иргэдийн 16.4 хувь нь тусгасан байдаг гэж үзжээ. Үүнийг албан байгууллагаар нь харьцуулан харвал:

**Хүснэгт 30. Байгууллагын хамтын гэрээ, хэлэлцээрт туссан ЖЭТБ-ыг хангах хэм хэмжээ/албан байгууллагаар/**

| Үзүүлэлтүүд | Бусад | Нийтийн хоол | Нийтийн худалдаа | Орон нутгийн өмчит аж ахуйн төрийн үйлчилгээний газар | Төрийн өмчит уул уурхайн аж ахуйн нэгж | Төрийн өмчит ХХК | Хувийн өмчит уул уурхайн аж ахуйн нэгж | Эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Асуудал шийдэхэд талуудын оролцоог хангах, санал авах тухай | 1.7 | 0.4 | | | | 3 | 3.9 | 9.0 |
| Бусад | | | | | 0.4 | | | 0.4 |
| Ижил ажилд цалин, нэмэгдэл хөлс ижил хэмжээгээр тогтоох тухай | 3.4 | 0.4 | | 0.4 | 0.4 | 4.3 | 2.6 | 11.6 |
| Мэдэхгүй | 1.3 | 0.4 | 0.4 | | 0.4 | 0.9 | 2.6 | 6.0 |
| Хөдөлмөрийн аюулгүй нөхцөлд ажиллах тухай | 6.0 | 0.7 | | 3.4 | 0.9 | 8.6 | 7.3 | 26.9 |
| Хүүхэд төрүүлэх, асрах нөхцөл боломцоо олгох тухай | 7.3 | 0.4 | | 2.6 | 1.3 | 6.0 | 6.0 | 23.7 |
| Эмэгтэй, эрэгтэй ажилтанд ажил, гэр бүлийн үүргээ хослуулах тухай | 0.9 | | | 0.4 | | 0.4 | 1.3 | 3.0 |
| Эрүүл мэнддээ анхаарах, хамгаалах тухай | 5.6 | 0.4 | | 2.2 | 0.4 | 5.2 | 5.2 | 19.1 |
| Эзлэх хувь | 26.3 | 3.1 | 0.4 | 9.1 | 3.8 | 28.4 | 28.9 | 100.00 |

Эндээс харахад Төрийн өмчит ХХК, Хувийн өмчит уул уурхайн аж ахуйн нэгж болон бусад байгууллагууд хөдөлмөрийн аюулгүй нөхцөлд ажиллах, хүүхэд төрүүлэх, асрах зэргийг зохицуулах, цалинтай чөлөө олгох тухай асуудлыг хамтын гэрээндээ тусгасан гэж 25.4хувь нь хариулсан байна. Хөдөлмөрийн харилцаанд маш хялбар зохицуулж болох эдгээр хэм хэмжээ хангалттай сайн тусгагдаагүй байна. Мөн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээн дэх ЖЭТБХ хангаж буй байдлыг ганцаарчилсан ярилцлагын хүрээнд тодруулахад:

Төрийн байгууллагын хувьд хуулийн дагуу бүх ажлууд явагдаж байна. Ажлын байрны ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтаас ангид байх талаар аймгийн ЗДТГ-ын дотоод

журамд 2020 оны 07 дугаар сард тусган хэрэгжүүлж байна. ЖЭБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага арга зүйгээр хангаж ажиллаж буй тул бусад аймгуудаас туршлага солилцох, төсөл хэрэгжүүлж буй 5 аймгийн хүрээнд зөвлөлдөх уулзалт хийвэл их зүгээр байна гэсэн санааг төрийн албан хаагчид хэлсэн байна.

Аймгийн ҮЭХ-оос хөдөлмөрийн харилцаан дахь маргаантай асуудлыг хэрхэн шийдэж байгаа тухай мэдээллээ ХЭҮК-ын салбартай хуваалцдаг. Иргэд олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа нь ХЭҮК-ын үйл ажиллагааны 25-30 хувийг эзэлдэг байна. Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй бодлогын баримт бичигт ЖЭТБ хангах тухай заалтууд туссан байгаа. Аймгийн ИТХ болон ИНБ-уудын зөвлөлөөс энэ асуудалд хамтран ажиллаж байна. Төрийн өмчит ХХК-ны хувьд байгууллагын хамтын гэрээнд жендерийн эрх тэгш байдлыг хангаж ажиллана гэж заасан тухай иргэд хэлжээ.

Төрийн албан хаагчид болон иргэд өөрсдийн ажиллаж буй байгууллагын хөдөлмөрийн дотоод журам болон хамтын гэрээнд туссан заалтуудыг санах, утгачлан тайлбарлах боломжгүй байв. Байгууллагууд хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээнд туссан ЖЭТБХ заалтуудаа танилцуулах, хэрэгжилтийн талаарх тайлан мэдээгээ ил тод нээлттэй байлгах зөвлөмж чиглэлийг жендэрийн салбар хорооноос өгч ажиллах боломжтой юм.
Байгууллагын хөдөлмөрийн харилцаанд гардаг асуудлууд

**Хүснэгт 31.Байгууллагын хөдөлмөрийн харилцаанд гардаг зөрчил /хүйс, насаар/**

| Үзүүлэлтүүд | Эмэгтэй | Эрэгтэй | Дундаж хувь |
|---|---|---|---|
| Хүний нөөцийн бүртгэл судалгаа, хувь хүний ур чадвар, амжилтыг үл харгалзан ажилтныг албан тушаал дэвшүүлэх, шагнаж урамшуулах | 31.7 | 22.2 | 26.9 |
| Шаардлагатай ажлын байр, нөхцөлд ажилтан авахдаа хүйсийн харьцааны тэнцвэртэй байдлыг харгалзахгүй байх | 14.3 | 22.2 | 18.3 |
| Ажлын байрны орон тооны зар мэдээнд нас, хүйс заах | 18.3 | 11.1 | 14.7 |
| Мэдээлэл хүртээмжтэй авах боломжоор хангахгүй байх | 7.1 | 16.7 | 11.9 |
| Хөдөлмөрийн харилцаанд гарсан хүний эрхийн зөрчлийн талаарх өргөдөл, гомдлыг барагдуулахгүй байх, үл ойшоох | 11.9 | 11.1 | 11.5 |
| Аль нэг хүйсийг давуу гэж үзэх | 9.5 | 8.3 | 8.9 |
| Ажил хөдөлмөр гүйцэтгэсэн өдрийн хөдөлмөрийн хөлсийг бүрэн олгохгүй байх | 7.1 | 8.3 | 7.7 |

Судалгаанд хамрагдсан иргэд хөдөлмөрийн харилцаанд дээрх асуудлууд гардаг гэж 83.3% нь хариулсан байна. Иргэд хөдөлмөрийн харилцаанд хүний эрхэд халдахгүй байх тухайлбал насны хязгаарлалт тавих, хүйс заах, мэдлэг чадварын ялгаатай байдлыг хэт дөвийлгөхгүй байхыг анхааруулж байлаа.

Байгууллагад ЖЭТБ-ыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа төлөвлөгөө ба ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ганцаарчилсан ярилцлагын явцад тодруулахад:

Аймгийн ЗДТГ-ын 2021-2024 оны төлөвлөгөөнд андрологич эмчийг бэлдэж кабинет байгуулахаар туссан. 14-17 насны хөвгүүдийг үзлэгт хамруулж, сургалт мэдээлэл хийсэн, сүүлийн 3 жилд цэргийн комиссын үзлэгт ороод тэнцээгүй 2600 гаруй залуу эрэгтэйчүүдийг 100 хувь эрүүлжүүлсэн байна. Эдгээр залуучуудын дийлэнх нь амны хөндийн өвчлөлтэй байсан. ЖҮХ-оос ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг үндэсний хэмжээнд үнэлэхэд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны чанар, хүртээмжийн хувьд хангалттай гэж үнэлэгдэн 2019 оны тэргүүний аймаг болсон байна. Мөн ХЭҮК-оос орон нутгийн төрийн байгууллагууд жендэрийн

асуудал хариуцсан дагнасан мэргэжилтэн байгаа эсэхэд үнэлгээ хийсэн гэсэн хариултуудыг төрийн албан хаагчид өгсөн байна. Мөн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн зорилтуудыг хангахад чиглэсэн үйл ажиллагааны явц, үр дүнгийн талаар ажилчдад мэдээлэл өгдөг эсэхийг тодруулахад ЗДТГ-ын нийт ажилчдын 70 хувьд тогтмол өгдөг байна.

Хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжийн хувьд голдуу гэр бүлийн гишүүд хамтран үйл ажиллагаа явуулдаг. Хүний тоо харилцан адилгүй байх тул жендэрийн мэдрэмжтэй байдлын тухай ярихад төвөгтэй, хувийн хэвшлийн ажлын байранд жендэрийн эрх тэгш байдлын талаар орхигдуулсан байдаг тухай иргэд ярьж байна. Жендэрийн эрх тэгш байдлын тухай ярихад зөвхөн хүйсийн харьцааны тэнцвэрт байдлыг чухалчилж байгууллагынхаа нийт ажилчдын эрэгтэй, эмэгтэй хүний тоог харьцуулан асуултад хариулт өгөх нь иргэдийн дунд түгээмэл байгаа нь ажиглагдсан. Энэ нь хувийн хэвшил, аж ахуйн нэгжийн удирдлага, ажилчдын дунд ЖЭТБХ тухай ойлголт өгөх сургалт, мэдээллийн үйл ажиллагааг нэмэгдүүлэх, ажлын байранд хүний эрхийн зөрчил гаргахгүй байхад анхаарлаа хандуулахад төрийн болон ИНБ-дын хамтын ажиллагаа чухал байгааг харуулж байна.

Төрийн албан хаагчид байгууллагынхаа ЖЭТБХ хангахад чиглэсэн үйл ажиллагаа, төлөвлөгөө хэрэгжиж байгаа хэмээн дүгнэж хэлсэн бол хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид хангалтгүй хэрэгжиж байгаа гэж дүгнэсэн байна.

Ажлын байрны нөхцөл, хөдөлмөрийн харилцаанд гарч буй жендэрийн тулгамдсан асуудал, байгууллагын дотоод журам, хамтын болон хөдөлмөрийн гэрээнд ЖЭТБХ заалтыг тусгах шаардлагатай эсэхийг бүлгийн ярилцлаганд оролцогчдоос тодруулан асуухад байгууллагынхаа хувьд жендэрийн тулгамдсан асуудал ярихаас илүү эрэгтэйчүүдийн нийтлэг асуудлаар санал бодлоо хуваалцаж байв. Тухайлбал: эрэгтэйчүүдийн онцлог хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх, эрэгтэйчүүдийн эмчтэй болох нь нэн чухал болохыг сануулсан байна.

Байгууллагын бодлого, төлөвлөгөө, үйл ажиллагааны төсөвлөлт жендэрийн мэдрэмжтэй байдлыг ганцаарчилсан ярилцлагын явцад тодруулахад Мерит төслийн хүрээнд орон нутагт хэрэгжиж буй нийгмийн төсөл хөтөлбөрүүдийг жендэрийн мэдрэмжтэй болгох зорилгоор 30 гаруй жижиг бүлэг төрийн бодлого, төлөвлөлтийг сайжруулахаар ажиллаж байна. Төрийн байгууллага иргэдэд нэг сувгаар, нэгдсэн цагт мэдээлэл өгдөг байх, төрийн байгууллагын бодлого, төлөвлөлтийг жендэрийн мэдрэмжтэй байдлыг нэмэгдүүлэх тухай хэлсэн байна.

ИТХ-ын төлөөлөгчдийн хүйсийн харьцааны тэнцвэрт байдал хангалтгүй, эрэгтэй нэр дэвшигчид иргэдэд янз бүрээр нөлөөлөх, тэдэнд шахалт үзүүлэх, эдийн засгийн байдлаар олзлох хэлбэрээр саналд нөлөөлөх оролдлого байсаар байна. Харин төрийн байгууллага, хувийн хэвшлийн томоохон байгууллагууд дотоод журмаа маш сайн боловсруулсан байдаг хэдий ч жендэрийн мэдрэмжтэй байдал, түүнд холбогдох заалт туссан журмыг одоогоор харж судлаагүй байна. Жижиг хувийн хэвшлийн байгууллагууд ихэвчлэн хөдөлмөрийн дотоод журамгүй байдаг. Орон нутаг дахь төрийн байгууллагуудын хэлтэс, тасаг хамтын гэрээ байдаггүй. Ажлын байрны тодорхойлолтод жендэрийн мэдрэмжтэй байдлын тухай оруулах ёстойг иргэд сануулж байна.

Ажил амралтын хоногийн харьцаа

**Хүснэгт 32. Уул уурхайн салбарт ажиллаж буй ажилчдын ажил амралтын хугацаа /хувиар/**

| Үзүүлэлт | Бусад | Нийтийн хоол | Орон нутгийн өмчит аж ахуйн төрийн үйлчилгээний газар | Төрийн өмчит уул уурхайн аж ахуйн нэгж | Төрийн өмчит ХХК | Хувийн өмчит уул уурхайн аж ахуйн нэгж |
|---|---|---|---|---|---|---|
| Ажил амралтын тэнцүү хуваарьтай | 12.3 | | 3.5 | 3.5 | 12.3 | 3.5 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Амрах хугацаанаасаа 7-20 хоногоор илүү ажилладаг | 7.0 | 1.8 | | 1.8 | 5.3 | 12.3 |
| Бусад | 7.0 | 1.8 | | 1.8 | 1.8 | 24.6 |

Ажил амралтын харьцааг тодруулахад "бусад" гэсэн сонголтыг хувийн өмчит уул уурхайн аж ахуйн нэгжүүдэд хамгийн өндөр буюу 24.6 хувийг эзлэж байгаа нь уул уурхайн салбарт ажил амралтын хоног ажил амралтын тэнцүү болон 7-20 гэсэн хугацаанаас өөр хугацаагаар тогтоожээ гэсэн үр дүн харагдаж байна. Хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн харилцаанд жендэрээр ялгаварлан гадуурхах, Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжид зөвшөөрснөөс бусад тохиолдолд эрэгтэй, эмэгтэй хүйсийн аль нэгэнд давуу эрх олгох, хязгаарлалт тогтоох, мөн жирэмсэн, хүүхэд асарсан болон гэр бүлийн байдлын шалтгаанаар ажилтныг ажлаас халахыг хориглосон бөгөөд энэ заалт үр дүнтэй хэрэгжиж буй байдлыг ганцаарчилсан ярилцлагаар тодруулахад:

Иргэд хууль эрх зүйн мэдлэгийн түвшин харилцан адилгүй байдаг тул хөдөлмөрийн харилцаанд гарч байгаа хүний эрхийн зөрчлөө илэрхийлж шийдвэрлүүлэх тал дээр ялгаатай хандаж байна. ХЭҮК-ын салбарт хандах тохиолдол байгаа ч нийтлэг биш байна. Эрэгтэй, эмэгтэй хүйсийн аль нэгэнд давуу эрх олгох, ажлын байрны сонгон шалгаруулалтад нас заадаг, цалингийн шатлалыг ялгаатай тогтоодог хэмээн төрийн албан хаагчид яриандаа дурьдсан байна.

Хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн харилцаанд жендэрээр ялгаварлан гадуурхах явдал байсаар байгаа тухай иргэд дараах тайлбартайгаар хэлж байна. Төрийн байгууллага жендэрийн мэдрэмжгүй, хувийн хэвшлийн байгууллага энэ талаар ойлголт, хандлага муутай байдаг. Жишээлбэл уул уурхайн компаниуд эрэгтэйчүүдийг голлон ажиллуулах сонирхолтой, үүнээс болоод жендэрт суурилсан нийгмийн бусад асуудлууд нийгэмд олноор гарч байна. Мөн гадаад дотоодын ажилчдын цалин хөлс ялгаатай тогтоогдсоноос цалингийн зөрүү их байна. Илэрхий биш ч хөдөлмөрийн харилцаанд зөрчил байсаар байна. Ажлын байрны дарамт үзүүлсэн тухай жилд 2-3 удаагийн, ажлаас шалтгаангүй халсан тухай өргөдөл өмгөөлөгчдийн холбоонд ирж байна. Эрэгтэйчүүдийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа бага явагддаг. Ажлын шаардлагаас эмэгтэйчүүдэд ажил албан тушаал ахихад нөлөөлдөг зүйлүүд байдаг.

*Шигтгээ: 3*
*.... Зарим аж ахуйн нэгж байгууллагууд дээр эмэгтэй хүмүүсийг жирэмсэн бол ажилд авахгүй, "Жирэмсэн үү ?" гэж хүртэл асуусан, 2 жил төрж болохгүй хэмээн тулгаж хөдөлмөрийн гэрээ хийх тохиолдол гарч байсан...*
*/Ганцаарчилсан ярилцлагаас-64 настай, эмэгтэй/*

Хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн харилцаанд жендэрээр ялгаварлан гадуурхах явдал байсаар байгааг төрийн албан хаагч болон иргэдийн төлөөлөл хэлж байгаа тул аймгийн жендэрийн салбар хороо ЖЭТБХ дэд хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны чиглэлд туссан хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн харилцаанд жендэрээр ялгаварлан гадуурхах явдлыг таслан зогсооход хувийн хэвшил, ИНБ, иргэдтэй хамтран ажиллах шаардлагатай байна.

Иргэдэд тулгамдаж буй асуудлыг тодруулахад:

**Хүснэгт 33. Ажлын байрны нөхцөл, эрхэлж буй ажлаас хамаарах асуудал /хүйс, насаар/**

| Үзүүлэлтүүд | Эмэгтэй | Эрэгтэй | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| Ажил мэргэжлээс шалтгаалах өвчин тусах | 18.6 | 4.1 | 22.7 |
| Ажлын байр солих | 19.6 | 3.1 | 22.7 |
| Бусад | 2.1 | 1.0 | 3.1 |
| Гэр бүлийн тогвортой харилцаа авч үлдэх | 15.5 | 3.0 | 18.5 |

| | | | |
|---|---|---|---|
| Тулгамдсан асуудал байхгүй | 13.4 | 6.2 | 19.6 |
| Хөдөлмөрийн бүтээмж буурах | 10.3 | 3.1 | 13.4 |
| **Grand Total** | **79.5** | **20.5** | **100.00** |

Дээрх асуудлууд нь иргэдийн өмнө тулгамдаж буй нийтлэг асуудал төдийгүй хувийн жингийн хувьд жигдхэн хэмжээтэй байна. Үүнийг ажиллаж буй байгууллага, хүйсээр нь харьцуулж харвал:

Хүснэгт 34. Ажлын байрны нөхцөл, эрхэлж буй ажлаас хамаарах асуудал/байгууллага, хүйс,хувиар/

| Эрэгтэй | Ажил мэргэжлээс шалтгаалах өвчин тусах | Ажлын байр солих | Бусад | Гэр бүлийн тогвортой харилцааг авч үлдэх | Тулгамдсан асуудал байхгүй | Хөдөлмөрийн бүтээмж буурах |
|---|---|---|---|---|---|---|
| Бусад | 5.0 | 5.0 | | 5.0 | 5.0 | 5.0 |
| Төрийн өмчит уул уурхайн аж ахуйн нэгж | | | | | | 5.0 |
| Төрийн өмчит ХХК | 5.0 | | 5.0 | | 10.0 | |
| Хувийн өмчит уул уурхайн аж ахуйн нэгж | 10.0 | 10.0 | | 10.0 | 15.0 | 5.0 |
| **Эмэгтэй** | **Ажил мэргэжлээс шалтгаалах өвчин тусах** | **Ажлын байр солих** | **Бусад** | **Гэр бүлийн тогвортой харилцааг авч үлдэх** | **Тулгамдсан асуудал байхгүй** | **Хөдөлмөрийн бүтээмж буурах** |
| Бусад | 6.5 | 6.5 | | 6.5 | 7.8 | 6.5 |
| Нийтийн хоол | | 3.9 | | 1.3 | | |
| Нийтийн худалдаа | | 1.3 | | | | |
| Орон нутгийн өмчит аж ахуйн төрийн үйлчилгээний газар | 6.5 | 3.9 | | 2.6 | | |
| Төрийн өмчит уул уурхайн аж ахуйн нэгж | | 1.3 | | 1.3 | 1.3 | |
| Төрийн өмчит ХХК | 9.1 | 5.2 | 1.3 | 1.3 | 1.3 | 3.9 |
| Хувийн өмчит уул уурхайн аж ахуйн нэгж | 1.3 | 2.6 | 1.3 | 6.5 | 6.5 | 2.6 |

Уул уурхайн байгууллагуудад ажиллаж буй эрэгтэйчүүдэд дээрх 5 асуудал байгаа гэж сонголт хийсэн бол эмэгтэйчүүд ажил мэргэжлээс шалтгаалсан өвчин тусах, ажлын байр солих, хөдөлмөрийн бүтээмж буурах зэрэг тулгамдсан асуудалтай байдаг хэмээн сонголт хийсэн байна.

Ганцаарчилсан ярилцлагын явцад байгууллагын хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд жендэрийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэж буй байдлыг тодруулахад иргэдийн хэвшмэл ойлголтыг өөрчлөх, хандлагад нөлөөлөх, мэдлэгийг дээшлүүлэх сургалт зохион байгуулах, жендэрийн ялгаатай байдлыг сайн тайлбарлах, ажилчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах тал дээр анхаарах хэрэгтэй байна.

Хөдөлмөрийн харилцааны жендэрийн тулгамдсан асуудлыг гурвалсан гэрээний хүрээнд шийдвэрлэж байна. (Ажил олгогч эздийн холбоо, аймгийн ҮЭХ, ЗДТГ-ын хууль зүйн хэлтэс) Байгууллагын бүтэц дэх нэгжүүдэд ажилтан сонгон шалгаруулж авахдаа нас, хүйсийн тэнцвэртэй байдлыг хангахад анхаардаг болсон байна. Хууль, журам, дэд хөтөлбөрийг сайн сурталчлах, дэлгэрүүлэх, төрийн байгууллагууд түншлэлийн хүрээнд сайн хамтарч ажиллах, өөрчлөлтийн судалгаа сайн гаргах шаардлагатай байгааг иргэд онцолжээ.

Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ЖЭТБХ талаар санаачлан хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, туршлагыг тодруулахад хангалттай мэдээлэл авч чадсангүй. Иргэд болон төрийн байгууллагын ажилтнуудын жендэрийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, сурталчилгаа маш үр дүнтэй. Шинэ хүүхэдтэй болсон аавуудад 5 өдрийн цалинтай чөлөө олгох, цаг үеийн нөхцөл байдлын шаардлагаар 0-12 хүртэл насны хүүхэдтэй эцэг, эхчүүдэд цалинг нь бүрэн олгож, гэрээсээ цахимаар ажиллах нөхцлийг төрийн албан хаагчид эдэлсэн байна. Эмэгтэйчүүдийн зөвлөл болон залуучуудын хэсгийг байгуулан жил бүр байгууллагын төсвөөс болон ҮЭ-ийн зүгээс санхүүгийн дэмжлэг үзүүлж ажилладаг ба үүнд сэтгэл хангалуун байдаг хэмээн төрийн өмчит ХХК-ны ажилтан хэлсэн байна.

Орон нутагт Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр хэрэгжиж байгаа талаарх мэдээлэл, ойлголтыг тандахад
судалгаанд хамрагдсан иргэдийн 70 хувь нь орон нутагт ЖЭТБХ дэд хөтөлбөр хэрэгжиж байгаа талаар мэдэхгүй гэж хариулсан нь тус хөтөлбөрийн талаарх танилцуулга мэдээлэл төдийлөн иргэдэд хүрч чадахгүй байгааг харуулж байна.

**Хүснэгт 35. Жендэрийн мэдлэг, чадвар, хандлага олгох үйл ажиллагаанд хамрагдсан байдал, хувиар /эрхэлж буй ажилтай нь харьцуулсан/**

| Байгууллага | Бусад | Өдөрлөг арга хэмжээ | Судал -гаа | Сургалт | Төсөл | Уулзалт, хэлэлцүүлэг | Хамрагдаж байгаагүй |
|---|---|---|---|---|---|---|---|
| Бусад | | 0.9 | 3.7 | 4.6 | 0.9 | 2.8 | 15.6 |
| Нийтийн хоол | | | | 0.9 | | | 2.8 |
| Нийтийн худалдаа | | | 0.9 | | | | |
| Орон нутгийн өмчит аж ахуйн төрийн үйлчилгээний газар | 0.9 | | 0.9 | 0.9 | | 0.9 | 6.4 |
| Төрийн өмчит уул уурхайн аж ахуйн нэгж | | | 0.9 | | | | 2.7 |
| Төрийн өмчит ХХК | | 0.9 | 0.9 | 4.6 | | 1.8 | 17.4 |
| Хувийн өмчит уул уурхайн аж ахуйн нэгж | | 0.9 | 1.8 | 3.7 | | 1.8 | 19.3 |

Жендэрийн асуудлаар орон нутгаас зохион байгуулсан үйл ажиллагаанд иргэдийн хамрагдсан байдлыг аваад үзвэл: Төрийн өмчит ХХК, Хувийн өмчит уул уурхайн аж ахуйн нэгж болон бусад салбарт жендэрийн асуудлаар орон нутагт зохион байгуулсан сургалтад 14.7 хувь, судалгаанд 9.2 хувь нь хамрагдаж, 64.2 хувь буюу ихэнх хувь нь ямар нэгэн үйл ажиллагаанд хамрагдаж байгаагүй байна.

Орон нутгийн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд ямар нэг үйл ажиллагаа зохион байгуулбал 63.1 хувь нь тус үйл ажиллагаанд оролцох хүсэлтэй байгаагаа дурдсан байна.

Судалгаанд хамрагдагсад жендэрийн мэдлэгээ дээшлүүлэх сургалтанд хамрагдах хүсэлтэй гэж 36.9 хувь нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Дээрх хоёр асуултанд хариулсан байдлыг дэлгэрүүлж харвал:

**Хүснэгт 36.**
**Орон нутгийн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд оролцох үйл ажиллагааны чиглэл, хэлбэр**

| Орон нутгийн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд ямар нэг үйл ажиллагаа зохион байгуулбал | | Хэрэв оролцох бол ямар хэлбэрээр оролцох вэ?. | |
|---|---|---|---|
| Оролцохгүй | 3.9 | Жендэрийн мэдлэгээ дээшлүүлэх сургалтад хамрагдах хүсэлтэй иргэд | 36.9 |
| Мэдэхгүй | 33.1 | Байгууллагын түвшинд ЖЭТБ-ыг хангах хүрээнд ажил олгогч, төр, ИНБ-тай хамтарч төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэх, | 35.9 |
| Оролцоно | 63.1 | Гэр бүл, ажлын хүрээнд хувь нэмрээ оруулахаар зорьж, энэ асуудалд өөрийн хувь нэмрээ оруулах хүсэлтэй иргэд 40.78% нь байна. Мөн мэдэхгүй гэж хариулсан | 21.4 |

Дэд хөтөлбөрийн хүрээнд ямар нэг үйл ажиллагаа зохион байгуулвал оролцох эсэх талаар асуулгад оролцогсдын 63 хувь нь оролцоно, 37 хувь нь оролцохгүй, мэдэхгүй гэсэн хариултыг өгчээ. Энэ нь иргэдийн ихэнх нь жендэрийн талаар мэдлэгээ нэмэгдүүлэх сонирхолтой байгааг харуулж байна.

Ямар чиглэлийн үйл ажиллагаанд оролцох талаар тодруулахад 40.8 хувь нь гэр бүл, ажлын хүрээнд хувь нэмрээ оруулахад, 36 хувь нь төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхэд , сургалтанд 37 хувь нь тус тус хамрагдах бодолтой байгаагаа илэрхийлсэн.

Харин 21 хувь нь мэдэхгүй гэсэн байна. Эндээс харахад оролцогчдын ихэнх хувь нь өөрийн жендэрийн талаар олж авсан мэдлэг, ойлголтоо гэр бүлийнхээ хүрээнд түлхүү ашиглах сонирхолтой байна. Мөн жендэрийн талаар төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалтанд хамрагдах хүсэлтэй иргэд нилээд байна.

### 3.2.2. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн чанар хүртээмжийг тодорхойлох

Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг тодорхойлох зорилгоор анкетын асуулгаар 114 иргэдээс мэдээлэл авч, ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага зохион байгуулсан.

Судалгаанд хамрагдсан иргэдийг боловсролын түвшнээр нь харуулбал:

График 6. Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн боловсролын түвшин /хувиар/




Судалгаанд хамрагдсан иргэдийн 46 хувь нь дээд, 45 хувь нь бүрэн болон тусгай дунд боловсролтой байна. Эрэгтэйчүүдийн боловсролын түвшинг ажиллаж буй байгууллагаар нь харьцуулан харвал:

Хүснэгт 37.
Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн боловсролын түвшин ба ажиллаж буй салбар /хувиар/

| Үзүүлэлтүүд | Бага | Бүрэн бус дунд | Бүрэн дунд | Дээд | Тусгай дунд | Grand Total |
|---|---|---|---|---|---|---|
| Барилгын салбар | | 0.9 | 1.7 | 3.5 | 1.7 | 7.8 |
| Боловсролын салбар | | | 0.9 | 7.9 | | 8.8 |
| Бусад | | 0.9 | 6.2 | 7.0 | 1.7 | 15.8 |
| Нийтийн хоол | 0.9 | | 1.7 | | | 2.6 |
| Орон нутгийн өмчит аж ахуйн төрийн үйлчилгээний газар | | | 1.7 | 0.9 | 5.3 | 7,9 |
| Төрийн өмчит уул уурхайн аж ахуйн нэгж | | | | 1.7 | | 1.7 |
| Төрийн өмчит эрчим хүчний систем ХХК | | | 7.9 | 19.3 | 2.6 | 29.8 |
| Хувийн өмчит уул уурхайн аж ахуйн нэгж | | 5.3 | 11.4 | 5.3 | 2.6 | 24.6 |

Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн 29.8 хувь нь төрийн өмчит ХХК-д ажиллаж байгаа бөгөөд тэдний 19.3 нь дээд боловсролтой, 24.6 хувь нь хувийн өмчит уул уурхайн аж ахуйн нэгжид ажиллаж эдгээрийн 11.4 хувь нь бүрэн дунд боловсролтой, боловсролын салбарт ажиллаж байгаа нь 7.9 хувь ба бүгд дээд боловсролтой байна. Эндээс харахад төрийн өмчит болон боловсролын салбарт дээд боловсролтой иргэд түлхүү ажиллаж, хувийн уул уурхайн аж ахуйн нэгжид бүрэн дунд боловсролтой иргэд голчлон ажиллаж байна. Тодруулбал: Эрэгтэйчүүдийн боловсролыг эрхэлж буй ажил, албан тушаалаар нь харьцуулж харвал:

Хүснэгт 38.
Эрэгтэйчүүдийн боловсролыг эрхэлж буй ажил, албан тушаалаар нь харьцуулж харвал /хувиар/

| Эрхэлж буй ажил | Бага | Бүрэн бус дунд | Бүрэн дунд | Дээд | Тусгай дунд | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| Бусад | | 0.9 | 5.4 | 12 | 3.6 | 21.9 |
| Гэрээт | | 1.8 | 1.8 | | | 3.6 |
| Нарийн мэргэжлийн | | 1.7 | 7.0 | 11.5 | 0.9 | 21.1 |
| Туслах | | 1.7 | 7.9 | 3.5 | 5.3 | 18.4 |
| Удирдах ажилтан | | | 1.7 | 14.9 | 0.9 | 17.5 |
| Үйлчилгээний | 0.9 | 1.7 | 7.9 | 3.5 | 3.5 | 17.5 |
| **Grand Total** | **0.9** | **7.8** | **31.7** | **45.4** | **14.2** | **100.00** |

Эндээс харахад дээд боловсролтой иргэд түлхүү удирдах болон нарийн мэргэжлийн ажил эрхэлж байна. Харин бүрэн дунд боловсролтой иргэд үйлчилгээний болон туслах ажил эрхэлж байна.

**Эрэгтэйчүүдийн жендэрийн талаарх болон хэвшмэл ойлголт:**

**Хүснэгт 39. Эрэгтэйчүүдийн жендэрийн тухай ойлголт, мэдлэгийн түвшин/хувиар/**

| Үзүүлэлтүүд | Эзлэх хувь |
|---|---|
| Нийгэм дэх эрэгтэй эмэгтэй хүмүүсийн тэгш эрх, тэгш боломж, тэгш оролцоо, тэгш байдал, эрх тэгш шийдвэрийн тухай ойлголт | 65.1 |
| Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгэм, соёлын ялгаатай болохыг тайлбарласан ойлголт | 12.8 |
| Хаана ч эрэгтэй, эмэгтэй хүмүүс тооны хувьд тэнцвэртэй байлгах тухай ойлголт | 10.1 |
| Эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшин дэх оролцоог нэмэгдүүлэх тухай ойлголт | 5.5 |
| Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах тухай ойлголт | 5.5 |
| Бусад | 0.9 |

Судалгаанд хамрагдсан иргэдийн 65.14хувь нь жендэр хэмээх ойлголтыг нийгэм дэх эрэгтэй эмэгтэй хүмүүсийн тэгш эрх, тэгш боломж, тэгш оролцоо, тэгш байдал, эрх тэгш шийдвэрийн тухай ойлголт, 34.85хувь нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгэм, соёлын ялгаатай болохыг тайлбарласан ойлголт, хаана ч эрэгтэй, эмэгтэй хүмүүс тооны хувьд тэнцвэртэй

байлгах тухай, эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшин дэх оролцоог нэмэгдүүлэх тухай, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах тухай ойлголт гэж тус тус үзсэн байна.

Эндээс харахад эрэгтэйчүүдийн жендэрийн талаарх ойлголт харилцан адилгүй байгаа боловч дийлэнх нь зөв ойлголттой байна. Жендэрийн тухай ойлголтыг хамгийн өндөр хувийг эзлэж буй үзүүлэлтийг салбараар нь харвал:

**График 7. Эрэгтэйчүүдийн жендэрийн тухай ойлголт, мэдлэгийн түвшин ба ажил эрхлэлтийн салбар /хувиар/**




Харьцуулалтаас харахад төрийн өмчит ХХК, хувийн өмчит уул уурхайн аж ахуйн нэгжид ажиллаж буй эрэгтэйчүүдийн жендэрийн тухай ойлголт бусдаасаа илүү байсан.

**График 8. Эрэгтэйчүүдийн жендэрийн хандлага /хувиар/**




Эрэгтэйчүүдийн хариулсан байдлаас харахад өрхийн тэргүүн эрэгтэй хүнийг илүү хүндэтгэх ёстой гэсэн бодомжийг зөв гэж 16.4 хувь нь, эр хүн өрх гэр бүлээ авч явагч, тэжээгч гэсэн бодомжийг зөв хэмээн 15.3 хувь нь үзсэн байна. Харин залуу эмэгтэйчүүд жирэмсэн болж, хүүхэдтэй болох тул ажилд авах хэрэггүй гэсэн бодомжийг буруу гэж 22.8 хувь нь, Сайн эхнэр бол нөхрийнхөө үгэнд орох ёстой гэсэн бодомжийг буруу гэж 16.7 хувь нь тус тус үзсэн байна.

Эндээс харахад эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн дунд жендэрийн уламжлалт хэвшмэл ойлголт байсаар байгаа нь харагдаж байна.

**График 9. Нийгэмд ЖЭТБХ нь хувь хүний амьдралд үзүүлэх нөлөөллийн талаарх төсөөлөл /хувиар/**




Судалгаанд харагдсан иргэд жендэрийн эрх тэгш байдлыг амьдралд эерэг нөлөөтэй гэж 58 хувь, мэдэхгүй гэж 32 хувь нь үзсэн байна.

Иргэдийн нилээд хэсэг нь жендэрийн эрх тэгш байдлыг хангаснаар нийгмийн болон гэр бүлийн амьдралд чухал үр нөлөөтэй болохыг ойлгож мэдэрсэн байна.

Үүнийг боловсролын түвшингээр нь авч үзвэл:

**Хүснэгт 40.**
**Нийгэмд ЖЭТБХ нь хувь хүний амьдралд үзүүлэх нөлөөллийн талаарх төсөөлөл /боловсролын түвшин, хувиар/**

| Үзүүлэлт | Бага | Бүрэн бус дунд | Бүрэн дунд | Дээд | Тусгай дунд | Эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|---|
| Мэдэхгүй | | 2.7 | 15.2 | 8.8 | 5.4 | 32.1 |
| Сөрөг нөлөөтэй | | | 0.9 | | | 0.9 |
| Эерэг нөлөөтэй | 0.9 | 4.5 | 13.4 | 33.9 | 5.3 | 58.0 |
| Ямар ч нөлөөгүй | | | 1.8 | 3.6 | 3.6 | 8.9 |
| Эзлэх хувь | 0.9 | 7.2 | 31.3 | 46.3 | 14.3 | 100.00 |

**Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч буй байдал:**

**График 10. Сүүлийн 2 жил эрүүл мэндийн үйлчилгээ авсан байдал /төрөл, хувиар/**




Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн 51.7 хувь нь оношилгоо, шинжилгээ, амбулаторын тусламж авсан, 28.9 хувь нь огт үйлчилгээ аваагүй байна. Үйлчилгээ авч байгаагүй иргэдээс эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч байгаагүй шалтгааныг асуухад дараах хариултыг өгсөн байна.

**График 11. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ аваагүй шалтгаан/хувиар/**




Эрэгтэйчүүдийн 61 хувь нь өвдөх зовиур байдаггүй, өвдвөл очно гэж хариулсан бол, очер дугаар авахад төвөгтэй, үйлчилгээ нь чирэгдэлтэй тул үйлчлүүлдэггүй гэж 20 хувь нь хариулсан байна. Эндээс харахад эрэгтэйчүүд өвчнөө хүндэрсэн хойно эмнэлэгт хандаж, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдах талаар хойрго ханддаг байна.

**График 12. Эрүүл мэндийн үйлчилгээ авч буй эрүүл мэндийн байгууллагын шатлал/хувиар/**




Иргэдийн 78.8 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэг болон өрхийн эмнэлэгийг сонгож үйлчлүүлдэг бол үлдсэн  13.0 хувь дээрх эмнэлэгүүдээр үйлчлүүлдэггүй байна.

**График 13. Эрүүл мэндийн үйлчилгээ ба үнэлгээ /хувиар/**




Дээрх графикаас харахад эрэгтэйчүүдийн 75 хувь нь эрүүл мэндийн тусламж авахад хүндрэлтэй төвөгтэй байдаг гэж хариулжээ.

**График 14. Эрүүл мэндийн үйлчилгээ авахад төвөгтэй байдаг шалтгаан/хувиар/**




Судалгаанаас харахад эрэгтэйчүүдэд ихэнхдээ дугаар авах, эмч нар удаан хүлээлгэдэг, хүнд суртал их байдаг зэрэг нь тэдэнд төвөгтэй санагддаг байна.

Эрэгтэйчүүдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг бууруулахад төрийн байгууллагын зүгээс хийсэн ажлын талаар ганцаарчилсан ярилцлагаар тодруулга авсан. **Тухайлбал:** 2019-2020 онд 14-17 насны хөвгүүдийн өсвөр үеийн эрүүл мэндийг хамгаалах урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд орон нутгийн хөгжлийн сангаас 20 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлжээ. Мөн урологийн тусламж үйлчилгээнд 2021 оны төсөвт орон нутгийн төсвөөс 25 сая төгрөгийг төсөвлөсөн байна.

Эрэгтэйчүүдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлийг бууруулахтай холбоотой шийдвэр, төсөл хөтөлбөр хоорондоо уялдаагүй, үр дүн хангалтгүй байдаг. Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг сайжруулахтай холбоотой олон хөтөлбөрүүд байгаа ч үр дүн муутай байна. Эрчүүдийн эрүүл мэндийн талаарх асуудлын шийдлийг гаргасан төсөл хөтөлбөр огт байхгүй.

ЖЭТБХ хангах дэд хөтөлбөрийн "...Эрэгтэйчүүд болон хөвгүүдэд зориулсан кабинетийг байгуулан эрүүл мэндийн үзлэг оношилгоо, сэтгэл зүйн зөвлөгөө бусад үйлчилгээг нэмэгдүүлэх заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Эрэгтэйчүүдийн эмчийг БОЭТ дотроосоо сонгож бэлдсэн хэдий ч тасгийн эрхлэгчийн албан тушаалд ажиллаж байгаа тул ажлын ачаалал их, эрэгтэйчүүдийн эрүүл мэндэд чиглэсэн үйлчилгээнд цаг гаргах боломж хязгаарлагдмал байна. Дэд хөтөлбөрийн хэрэгжилт зохих үр дүнд хүрч байгаа хэдий ч эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ эхлэл төдий байна андрологи, сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг мэргэжилтэн, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн чиглэлээр нэгж ажиллах хэрэгтэй байна.

Сэтгэц, наркологийн талаасаа эрэгтэйчүүд эрүүл мэндийн олон асуудалтай тулгараад байна. БОЭТ-ийн сэтгэцийн эрүүл мэндийн тасгийн наркологийн чиглэлээр нийт үйлчлүүлэгчдийн 95 хувь нь эрэгтэйчүүд үйлчлүүлсэн байна. Эрэгтэйчүүдийн түрүү булчирхайн өвчлөлөөс шалтгаалж бэлгийн амьдрал буурч байна. Шээсний сүвийн нарийсал, түрүү булчирхайн томролт зэрэг нь эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг болж байна. Иймд орон нутагт эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн дурангын хагалгаа, мэс засал хийх эмч бэлтгэх ажлыг эхлүүлсэн байна. Эрэгтэйчүүдийн дундаж

наслалт эмэгтэйчүүдээс бага, хөгжлийн бэрхшээлтэй болох, нас баралт, зарим өвчлөлд эрэгтэйчүүд өртөх нь өндөр байгаа тул жендэрийн тулгамдсан асуудал мөн гэж үзэж байна.

Эрэгтэйчүүдийг хамруулсан амбулаторийн үзлэгийг 2018 оноос жигдрүүлсэн. Оношилогоог хувийн лабораториудад хийгдэж байна. Урьдчилан сэргийлэх багцын үзлэгээр нийт 150 хүн хамрагдсан гэхдээ үүнийг хангалттай гэж үзэхгүй байна. Дэвшилтэт технологид суурилсан эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үйлчилгээ хөгжүүлэхэд анхаарч байна. Тухайлбал: Мэс заслын хагалгааг дурангаар хийх багажийг авч, эмч бэлтгэх ажлыг эхлүүлсэн. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлд анхаарч урологи, андрологийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх чиглэлд бодлого барьж байгаа тухай төрийн бодлого хэрэгжүүлж буй салбарын албан хаагчид хэлж байна.

Гэтэл эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үйлчилгээнд тулгамдаж буй асуудлын талаар судалгаа мэдээлэл дутмаг, эрэгтэйчүүдэд үзүүлэх өвөрмөц тусламж үйлчилгээ эхлэл төдий, эмнэлэгт очиж үйлчилгээ авахад төвөгтэй, эрэгтэй, эмэгтэй хүнд тохирсон эрүүл мэндийн үйлчилгээг үнэлэх боломжгүй байна гэж иргэд сэтгэл ханамжаа илэрхийлсэн байна.

**График 15. Эрэгтэйчүүд өөрийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг сонгосон байдал /хувиар/**




Эрэгтэйчүүдийн дийлэнх нь архи, тамхины хэрэглээ, ажлын нөхцөл, зохисгүй хооллолт, стресс, эрүүл мэндийн боловсрол зэрэг нь тэдний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна гэж үзсэн байна. Төр, хувийн хэвшлийн байгууллага болон ИНБ-уудын ажилтнуудтай хийсэн бүлгийн ярилцлаганд оролцогчдын зүгээс эрэгтэйчүүдийн эрүүл мэндэд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг буруу хооллолт, таргалалт, архи тамхины хэрэглээ өндөр, эрчүүдийн буруу дадал, зуршил, жендэрийн хэвшмэл ойлголт, уламжлалт ёс заншил, стресс, бухимдал гэж тодорхойлсон.

**Амь эрсдэх ямар нэгэн тохиолдолд өртөж байсан талаар:**

**График 16. Амь эрсдэж болзошгүй ямар нэгэн тохиолдолд өртөж байсан /төрөл, тоо/**




Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн 64 хувь нь хүнд төрлийн буюу уул уурхайн байгууллагад ажиллаж байгаа бөгөөд  авто болон мотоциклийн осолд орох эрсдэл их байдаг байна.

*Шигтгээ:4 ...Осол гэмтлийн нас баралтын 86.3  хувийг эрэгтэйчүдийн эндэгдэл эзлэж байгаа бөгөөд үүнээс мотоциклын ослын нас баралт 100 хувь, тээврийн хэрэгслийн ослын нас баралт 83.3 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна.*

*Кэйсийн судалгаагаар*

*Шигтгээ:5*
*...Дорнод аймгийн хувьд нийт нас баралтанд тархинд цус харвах, зүрхний шигдээс, осол гэмтэл, амиа хорлох шалтгаант үхэл өндөр хувийг эзэлж байна. Хүн амын дотор халдварт бус өвчлөлд зүрх судас, амьсгалын өвчлөлд эрэгтэйчүүдийн өвчлөл илүү байгаа ба уушиг тэлэгдэх, зүрхний шигдээс өвчин зонхилж байна.*

Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн 66.4 хувь нь бага байхдаа хүнд ажил эрхэлж байгаагүй ба 33.6 хувь нь хүнд ажил эрхэлж байсан байна. Мөн судалгаанд хамрагдсан иргэд одоогийн эрхэлж буй ажлынхаа эрүүл мэндэд нөлөөлөх эрсдлийн түвшинг үнэлжээ.

**График 17. Эрэгтэйчүүдийн эрхэлж буй ажлын эрүүл мэндэд нөлөөлөх эрсдлийн түвшин /хувиар/**




Эрэгтэйчүүдийн дийлэнх хувь нь эрсдэлтэй ажил эрхэлж байна гэж үзжээ. Эндээс харахад эрэгтэйчүүдийн ажиллах орчин, аюулгүй байдлын хамгаалалтыг сайжруулах шаардлага гарч байна.

**График 18.Эрэгтэйчүүд БОЭТ-өөр үйлчлүүлж буй байдал**




Эрэгтэйчүүдийн дийлэнхэд нь шүд, чих, хамар, хоолой, эрүү нүүрний мэс засал, халдварт, сүрьеэ, нүд, мэс засал, гэмтэл, мэдрэл, дотор зэрэг өвчлөл илэрдэг байна.

Дорнод аймгийн цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн нөхцөл байдалд 2018-2020 онд хийсэн судалгаанаас харахад: Цэрэг татлагад 2018 онд 1077 залуучууд татагдаж эрүүл мэндээр 716 хүн, 2019 онд 1306 залуучуудаас 922 хүн, 2020 онд 1868 залуучуудаас 1232 хүн тус тус тэнцээгүй байна.

**График 19. Цэрэг татлагт хамрагдсан иргэдийн эрүүл мэндийн үзүүлэлт**




**График 20. Цэрэг татлагт ирсэн эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үзүүлэлт /2018-2020/**




Дээрх тоон үзүүлэлтээс цэргийн үзлэгт оролцсон нийт иргэдийн тэнцсэн тоо 29-34 хувьтай байхад тэнцээгүй иргэдийн тоо 65-70 хувьтай байгаа нь анхаарал татсан үзүүлэлт болж байна.

БОЭТ-д урологийн тусламж үйлчилгээг үзүүлж эхлээд байгаа ба 7 хоногт 2 удаа, Мягмар, пүрэв гаригт урологийн үзлэг хийгдэж байгаа боловч эрэгтэйчүүдийн онцлог хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд болон сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ, эрэгтэйчүүдийн төрөлжсөн кабинет орон нутагт байхгүй байгаад бүлгийн ярилцлаганд оролцогчид шүүмжлэлтэй хандсан.

Мөн төрийн байгууллагын зүгээс албадан эмчилгээнд явуулсан хүмүүсийн ихэнх нь эргээд архинд орж байгаа тул үр дүн гарахгүй байна, тийм учраас сэтгэл зүйн зөвлөгөө өгөх ажил хэрэгтэй байгаа талаар зарим оролцогчид ярьсан.

*Шигтгээ: 6*
*....АА-ийн цуглаанд явдаг хүмүүсээс өнгөрсөн жил 20 хүн архинаас гарсан байна, зөвхөн эм тариагаар эмчлэх бус сэтгэл зүйн хувьд эмчлэх хэрэгтэй байна.*

*/Бүлгийн ярилцлага, Эрэгтэй, 47 настай/*

*Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах ажил төрийн дэмжлэг авч чадахгүй олон жил болж байгаа бөгөөд үүнд төрийн зохицуулалт дутагдаж байна.*

*/Бүлгийн ярилцлага, Эмэгтэй, 55 настай*

**Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж:**

**График 21.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн байдлын үнэлгээ /хувиар/**




Эрэгтэйчүүдэд чиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээ, хүртээмжтэй байдлыг сайн 16.3 хувь, муу 52.9 хувь, дунд зэрэг 30.7 хувь нь үзсэн байна. Эндээс харахад аймгийн хэмжээнд эрэгтэйчүүдэд чиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах шаардлагатай байна.

...Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 37 дугаар захирамжаар “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж насжилтын зөрүүг бууруулах” талаар авч хэрэгжүүлэх салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлын төсвийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Богино хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний гол зорилго нь “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүтэй байдалд хамгийн ихээр сөргөөр нөлөөлж буй өвчлөлийг эрт илрүүлэх, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх, зам тээврийн ослоос шалтгаалсан нас баралтыг бууруулах, эрүүл аж төрөх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлж дадал, хандлагыг өөрчлөх замаар эрэгтэйчүүдийн наслалтыг нэмэгдүүлэх”-д оршиж байгаа юм. Уг арга хэмжээний төлөвлөгөө нь 4 зорилт, 25 үйл ажиллагаатай бөгөөд 2020-2022 он хүртэл хэрэгжих талаар бүлгийн ярилцлаганд оролцогчдын зүгээс мэдээлэл хийсэн.

Эрэгтэйчүүдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг бууруулахад чиглэсэн шийдвэр, зонхилон тохиолдож байгаа өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах санхүүжилтийг төрийн зүгээс шийдвэрлэсэн байдлын талаар ганцаарчилсан ярилцлагаар тодруулан ярилцсан. Үүнд:

2019-2020 онд 14-17 насны хөвгүүдийн өсвөр үеийн эрүүл мэндийг хамгаалах урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд орон нутгийн хөгжлийн сангаас 20 сая төгрөгийн санхүүгийн

дэмжлэг үзүүлжээ. Мөн урологийн тусламж үйлчилгээнд 2021 оны төсөвт орон нутгийн төсвөөс 25 сая төгрөгийг төсөвлөсөн байна.

Эрэгтэйчүүдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлийг бууруулахтай холбоотой шийдвэр, төсөл хөтөлбөр хоорондоо уялдаагүй, үр дүн хангалтгүй байдаг. Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг сайжруулахтай холбоотой олон хөтөлбөрүүд байгаа ч үр дүн муутай байна. Эрчүүдийн эрүүл мэндийн талаарх асуудлын шийдлийг гаргасан төсөл хөтөлбөр огт байхгүй.

ЖЭТБХ хангах дэд хөтөлбөрийн "...Эрэгтэйчүүд болон хөвгүүдэд зориулсан кабинетийг байгуулан эрүүл мэндийн үзлэг оношилгоо, сэтгэл зүйн зөвлөгөө бусад үйлчилгээг нэмэгдүүлэх заалтын хэрэгжилт хангалтгүй байна. Эрэгтэйчүүдийн эмчийг БОЭТ дотроосоо сонгож бэлдсэн хэдий ч тасгийн эрхлэгчийн албан тушаалд ажиллаж байгаа тул ажлын ачаалал их, эрэгтэйчүүдийн эрүүл мэндэд чиглэсэн үйлчилгээнд цаг гаргах боломж хязгаарлагдмал байна. Дэд хөтөлбөрийн хэрэгжилт зохих үр дүнд хүрч байгаа хэдий ч эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ эхлэл төдий байна андрологи, сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг мэргэжилтэн, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн чиглэлээр нэгж ажиллах хэрэгтэй байна.

Сэтгэц, наркологийн талаасаа эрэгтэйчүүд эрүүл мэндийн олон асуудалтай тулгараад байна. БОЭТ-ийн сэтгэцийн эрүүл мэндийн тасгийн наркологийн чиглэлээр нийт үйлчлүүлэгчдийн 95 хувь нь эрэгтэйчүүд үйлчлүүлсэн байна. Эрэгтэйчүүдийн түрүү булчирхайн өвчлөлөөс шалтгаалж бэлгийн амьдрал буурч байна. Түрүү булчирхай, шээсний сүв, түрүү булчирхайн утленлат нээх зэрэг нь эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг болж байна. Иймд орон нутагт эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн дурангын хагалгаа, мэс засал хийх эмч бэлтгэх ажлыг эхлүүлсэн байна. Эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдээс бага, хөгжлийн бэрхшээлтэй болох, нас баралт, зарим өвчлөлд эрэгтэйчүүд өртөх нь өндөр байгаа тул жендэрийн тулгамдсан асуудал мөн гэж үзэж байна.

Эрэгтэйчүүдийг хамруулсан амбулаторийн үзлэгийг 2018 оноос жигдрүүлсэн. Оношлогоог хувийн лабораториудаар хийлгэж байна. Урьдчилан сэргийлэх багцын үзлэгээр нийт 150 хүн хамрагдсан гэхдээ үүнийг хангалттай гэж үзэхгүй. Дэвшилтэт технологид суурилсан эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үйлчилгээ хөгжүүлэхэд анхаарч байна. Тухайлбал мэс заслын хагалгааг дурангаар хийх багажийг авч, эмч бэлтгэх ажлыг эхлүүлсэн. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлд анхаарч урологи, андрологийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх чиглэлд бодлого барьж байгаа тухай төрийн бодлого хэрэгжүүлж буй салбарын албан хаагчид хэлж байна. Гэтэл эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үйлчилгээнд тулгамдаж буй асуудлын талаар судалгаа мэдээлэл дутмаг, эрэгтэйчүүдэд үзүүлэх өвөрмөц тусламж үйлчилгээ эхлэл төдий, эмнэлэгт очиж үйлчилгээ авахад төвөгтэй, эрэгтэй, эмэгтэй хүнд тохирсон эрүүл мэндийн үйлчилгээг үнэлэх боломжгүй байна гэж иргэд сэтгэл ханамжаа илэрхийлсэн байна.

**Эрэгтэйчүүд эрүүл мэндээ хамгаалах, урьдчилан сэргийлэх ямар арга хэмжээ авдаг болох:**

Судалгаанд оролцсогчдын 85.2 хувь нь үгүй гэжээ. Харин 14.8 хувь нь тийм гэж хариулсан бөгөөд зөв хооллолт, дасгал хөдөлгөөн, ажил амралтаа зохицуулах, хөдөлмөр хамгааллын аюулгүй байдлыг хангаж хувцас өмсөх, хорт зуршлаас татгалах, спортоор хичээллэх, нэмэлт витамин хэрэглэдэг гэж бичжээ.

**Орон нутагт Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр батлагдан, хэрэгжиж байгаа талаар:**

Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдээс Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр батлагдан хэрэгжиж байгааг мэдэх үү гэж асуухад 85.2хувь нь мэдэхгүй, 14.8хувь нь мэднэ гэж хариулжээ. Эрэгтэйчүүд жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн тухай

төдийлөн сайн мэдэхгүй, эрэгтэйчүүдэд чиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээ сул, эрүүл мэнддээ төдийлөн сайн анхаардаггүй  байна.

Төр, хувийн хэвшлийн байгууллага болон ИНБ-уудын төлөөлөл оролцсон бүлгийн ярилцлаганд оролцогчдын дийлэнх нь “Дэд хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд суурь судалгаа хийх, боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх, тайлагнах үйл явцад оролцож хамтран ажилласан тул дэд хөтөлбөрийн талаарх ойлголт мэдлэг хангалттай сайн байсан.

**Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн онцлог хэрэгцээнд зориулсан ямар үйлчилгээг бий болгох шаардлагатай талаар:**

Төрөөс эрэгтэйчүүдэд чиглэсэн эрүүл мэндийн онцлог хэрэгцээнд зориулсан ямар үйлчилгээг бий болгох шаардлагатай байгаа тухай асуухад нийт судалгаанд хамрагдсан иргэдийн дийлэнх хувь нь эрэгтэйчүүдийн эмнэлэг, үйлчилгээг нэн яаралтай эхлүүлэх шаардлагатай байна гэж үзжээ. Нээлттэй асуултын хариултыг багцлан харуулбал:

- Эрэгтэйчүүдийн эмнэлэгтэй болох;
- Тандалт судалгаа хийх
- Аймгийн нэгдсэн эмнэлэгт эрэгтэйчүүдийн тусгай тасгийг бий болгох;
- Үе шаттай, жилд нэг удаа үзлэгт бүх эрэгтэйчүүдийг хамруулдаг байх;
- Эрэгтэйчүүдэд чиглэсэн үзлэг, оношлогоо, зөвлөх үйлчилгээг өдөрлөг, ёслолын байдалтай хийдэг байх;
- Эмэгтэйчүүдтэй ижил түвшинд эрүүл мэнд, хүний эрхийн мэдлэг олгодог байх хэрэгтэй;
- Архины хэрэглээг багасгах ажил зохион байгуулах
- Эрэгтэйчүүдийн сэтгэл санааг дэмждэг төв буюу эмчтэй болох, сэтгэл зүйн эмчилгээ; зөвлөгөө өгөх
- Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн чанар хангалтгүй түвшинд байгаа, хувь хүний ухамсартай ч бас холбоотой тул эрэгтэйчүүд өөрсдөө эрүүл мэнддээ анхаарах;

Бүлгийн ярилцлаганд оролцогчид эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих, чанар хүртээмжийг сайжруулах талаар доорхи ажлуудыг хийж болох  санал бодлоо хуваалцсан. Үүнд:

- Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжсэн хөтөлбөртэй болох
- "Эрэгтэйчүүдээ хайрлая - хандлагаа өөрчилцгөөе"! гэсэн жилийн аяныг  аймгийн хэмжээнд өрнүүлэх
- Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн талаарх асуудлыг аймаг, сумын ИТХ болон ЗДТГ болон шийдвэр гаргах түвшинд танилцуулах
- Зүрх судасны өвчнөөр нас барж буй хүмүүсийн дийлэнх нь эрэгтэйчүүд байгаа тул Нью Эндорфен эмнэлэгийн хувьд зүрх судасны өвчний талаар зөвлөгөө өгөх ажлыг эхлүүлэх боломжтой.
- Эрэгтэйчүүдийн эмч бэлтгэх ажлыг бодлогоор хийх
- Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах
- Эрэгтэйчүүдэд үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж, сэтгэл заслын зөвлөгөө өгөх болон андрологийн тусламж үзүүлэх эмч мэргэжилтнийг БОЭТ-д, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн түвшинд бэлдэх
- Зам тээврийн ослоос сэргийлэх, хөдөлгөөний соёл, замын аюулгүй байдлыг сайжруулах
- Сэтгэц наркалогийн тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх
- Эрэгтэйчүүдийн  кабинет байгуулж ажиллах,
- Эцэг эхчүүдийн хандлагыг өөрчилж, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх

- Хувийн хэвшлийн болон ААН байгууллагуудын удирдах ажилтнуудын жендэрийн талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлж нөлөөллийн ажил зохион байгуулах гэх мэт

Асуулга судалгаа, ганцаарчилсан болон бүлгийн ярилцлаганд хамрагдсан иргэдийн дийлэнх нь эрэгтэйчүүдийн онцлог хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг орон нутагт бий болгох талаар санал гаргажээ.

**ДҮГНЭЛТ**

ОХШҮ-ний үр дүнд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ЖЭТБ хангах тухай хууль, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан ЖЭТБХ үндэсний хөтөлбөр /2017-2021/, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус үндэслэн Дорнод аймгийн ЖЭТБХ дэд хөтөлбөр боловсруулагдаж, 2018 оноос эхлэн хэрэгжиж эхэлсэн байна.
- ЖЭТБХ дэд хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд ЖЭТБ-ыг хангах орон нутгийн чадавхийг бэхжүүлэх, төрийн байгууллагын удирдах ажилтан албан хаагчдын дунд жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсвийн талаар сургалт мэдээллийн ажиллагаа зохион байгуулах, орон нутгийн нийгмийн чиглэлийн төсөл хөтөлбөрүүдийн уялдаа холбоог хангах, жендэрийн мэдрэмжтэй төсөл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, бүх нийтэд жендэрийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлж тогтвортой байдлыг хангах ажлын хүрээнд сургагч багш бэлтгэх, өсвөр насны хүүхдийн жендэрийн талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр голчлон ажилласан байна.
- ЖЭТБХ дэд хөтөлбөрийн ажлын хүрээнд Төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд, олон улсын байгууллагуудын түншлэл, хамтын ажиллагаа сайжирсан байна. Тухайлбал: НҮБ-ын Хүн амын сан, Мэрит төсөл, Хүний эрхийн үндэсний комисс, МОНЭС зэрэг олон улсын болон төрийн байгууллагууд ЖЭТБ-ыг хангах дэд хөтөлбөрийн зорилтуудыг хангах чиглэлд хувь нэмрээ оруулж, идэвхтэй хамтран ажиллажээ.
- ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж, мэдээ, тайланг хүйсээр ангилах эхлэл тавигдаж, Аймгийн ИТХ-аар шаардагдах төсвийг жил бүр тогтвортойгоор батлан хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа нь сайшаалтай байна. Гэвч одоогоор төрийн байгууллагуудад жендэрийн асуудлыг хариуцсан мэргэжилтэн байхгүй байгаа нь хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд сөргөөр нөлөөлж байна.
- Төрийн байгууллагын зүгээс ЖЭТБ-ыг хангах ажлын тайлан мэдээ, үнэлгээ дүгнэлт гаргахдаа тухайн ажлын чанар, үр дүнг зөв тооцож гаргах талаар хангалтгүй байна. Тухайлбал: “Аз жаргал төв”, “Гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүд”-ийн сургалт, зөвлөн туслах үйлчилгээнд жендэр судлал, нөхөн үржихүй, эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, гэр бүл судлал, охид эмэгтэйчүүдийг хүний наймаа, бэлгийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх сургалт судалгаа, нөлөөллийн үйл ажиллагааг тусгах” гэсэн үйл ажиллагааны хүрээнд “Аз жаргал төв”, “Залуучууд хөгжлийн төв”-ийн амьдрах ухааны сургалтаар 14-18 насны 8220 өсвөр үе, залуучуудад нөхөн үржихүйн мэдлэг, мэдээлэл, тусламж үйлчилгээг үзүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 20 хувиар өссөн үзүүлэлттэй байна” гэж дүгнээд, үнэлгээг 100 хувийн биелэлтэй гэж тооцжээ.

  Гэтэл дээрх үйл ажиллагааны хүрээнд зөвхөн нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлаар мэдээлэл, тусламж үйлчилгээ үзүүлээд бусад асуудлаар /Жендэр судлал, эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, гэр бүл судлал, охид эмэгтэйчүүдийг хүний наймаа, бэлгийн

хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх/ сургалт судалгаа, нөлөөллийн үйл ажиллагаа явуулаагүй, орхигдуулсан байна.

Уул уурхайн салбар болон улирлын шинжтэй ажил, хөдөлмөр эрхэлж буй иргэдийн эрүүл мэнд, ахуй нөхцөл, “Гэр бүлийн амьжиргаа, тогтвортой байдалд жендэрийн дүн шинжилгээ хийж, нөхцөл байдлыг сайжруулах зөвлөмжийг оролцогч талуудад өгөх” гэсэн үйл ажиллагааны хүрээнд 2018-2020 онд гүйцэтгэл байхгүй байхад 30 хувийн биелэлтэй гэж үнэлсэн байна.

Уг ажлыг Covid-19 цар тахлын улмаас уул уурхайд ажиллагсдын эрүүл мэнд ахуйн нөхцөл, гэр бүлийн амьжиргаа тогтвортой байдалд жендэрийн дүн шинжилгээ хийх ажлыг 2021 онд хийхээр төлөвлөжээ.

- ЖЭТБХ дэд хөтөлбөрийн үндсэн 3 зорилтын хүрээнд 15 чиглэлийн үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр тусгагдаж, 2018-2020 онд дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд давхардсан тоогоор нийт 12 чиглэлийн үйл ажиллагааг төлөвлөж, төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулсан байна.

  ЖЭТБ-ыг хангах дэд хөтөлбөрийн зорилтуудыг хангах ажлуудын хүрээнд төлөвлөгдөөгүй хэрэгжсэн ажил нийт 23 үйл ажиллагаа байна. Дэд хөтөлбөрийн зорилтуудын хүрээнд төлөвлөгдөж хийгдсэн болон төлөвлөгдөөгүй хийгдсэн ажлуудаас гадна огт хийгдээгүй ажлууд 20 хувь нь байна. Тухайлбал:

  a. “Үндэсний хөтөлбөрийн хүрээнд улсын хэмжээнд хийгдэх эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсрол, залуу малчдын нөхцөл байдалд хийгдэх жендэрийн судалгаанд тулгуурлаж эрэгтэйчүүд болон хөвгүүдэд зориулсан кабинетыг байгуулан эрүүл мэндийн үзлэг, оношилогоо, сэтгэл зүйн болон бусад үйлчилгээг нэмэгдүүлэх,
  b. “Уул уурхайн салбар болон улирлын шинжтэй ажил, хөдөлмөр эрхэлж буй иргэдийн эрүүл мэнд, ахуй нөхцөл, гэр бүлийн амьжиргаа, тогтвортой байдалд жендэрийн дүн шинжилгээ хийж, нөхцөл байдлыг сайжруулах зөвлөмжийг оролцогч талуудад өгөх, “Төр, хувийн хэвшлийн ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгох, эрэгтэй, эмэгтэй ажилтанд адил хэмжээний хөлс олгох, иргэдийг ажилд авахад хүйсээр ялгаварлахгүй байх, ажлын байран дахь хүчирхийллээс сэргийлэх ажлыг төр, ИНБ-тай хамтран хэрэгжүүлэх гэсэн ажлууд орж байна.
- ОХШҮ-ний ажлын дүн шинжилгээнд тулгуурлан ОНЖДХ дэд хөтөлбөрийн “ЖЭТБ-ыг хангах, жендэрийн ялгаварлан гадуурхалт, хүчирхийлийг тэвчих, жендэрийн хэвшмэл ойлголт, хандлагыг арилгах” болон “Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн нийгмийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэйгээр хүртэх боломжийг нэмэгдүүлэх” гэсэн 2 чиглэлд ”Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн ажил олгогч болон ажиллагсдын ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг болон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, ажлын байрны нөхцөл байдлыг тодорхойлох”, Эрэгтэйчүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг тодорхойлох” гэсэн 2 асуудлыг ОХШҮ-ний багаас тодруулан судалсан байна.

**“Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн нийгмийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэйгээр хүртэх боломжийг нэмэгдүүлэх”асуудлаар:**

- Дорнод аймагт 2019 оны байдлаар 82 мянган хүн амьдарч байгаагаас 50 хувийг эрэгтэйчүүд эзэлж, эрэгтэй хүний дундаж нас эмэгтэй хүнээс 8.2 жилээр бага байна. 2019 онд нас барсан хүний 62.5 хувь нь эрэгтэйчүүд, хорт хавдрын өвчлөлийн 61.2 хувь нь эрэгтэйчүүд тус тус байна. Мөн Халдварт өвчнөөр түүний дотор цусан суулга, заг хүйтэн, сүрьеэ өвчнөөр өвчлөгсөд болон цаг бусаар тахир дутуу болж байгаа хүмүүс, мэргэжлээр шалтгаалах өвчнөөр өвдөгсөд, амиа хорлогчдын ихэнх хувийн эрэгтэйчүүд эзэлж байна. Тухайлбал: Дорнод аймагт өөрийгөө боймолж нас барах тохиолдол 2019 онд 14 гарснаас

бүгд эрэгтэйчүүд, 2020 онд 20 тохиодол гарснаас 19 нь эрэгтэй хүн байна. 2019 онд зүрхний шигдээс өвчнөөр нас баралт 100 хувь эрэгтэйчүүд эзэлсэн байна. Эрэгтэйчүүдийн хувьд нийт нас баралтанд тархинд цус харвах, зүрхний шигдээс, осол гэмтэл, амиа хорлох шалтгаант үхэл өндөр хувийг эзлэж байна Энэхүү тоо баримтаас харахад эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудал тулгамдсан асуудлуудын нэг болсон байна.

- Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудал орон нутагт асуудал дагуулсаар байна. Тухайлбал: 2018-2020 онд цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгт 4251 залуучууд хамрагдаж, үүнээс 2870 буюу 65.5 хувь нь эрүүл мэндээр тэнцээгүй байна. Өвчлөлийн 70 гаруй хувийг эмчилж эрүүлжүүлэх боломжтой гэж мэргэжлийн байгууллагаас үзсэн байна
- Хэдийгээр орон нутагт төрийн байгууллагын зүгээс эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн онцлог хэрэгцээнд зориулсан эмнэлэгийн тусламж үйлчилгээний хүрээнд нарийн мэргэжлийн эмч бэлтгэх, шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авах, урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ хийх ажлуудыг эхлүүлсэн боловч энэ нь урологийн тусламж үйлчилгээ болон БЗХӨ-нөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд чиглэгдэж байгаа бөгөөд андрологийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх боломжгүй юм. Одоогийн байдлаар эрэгтэйчүүдэд үзүүлэх антропологийн болон сэтгэл зүйн тусламж үйлчилгээ тус аймагт хөгжөөгүй байна.
- Эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйл архи, тамхины хэрэглээ эрэгтэйчүүдийн дунд өндөр байгаа ба сэтгэл зүйн хямралын тусламж үйлчилгээнд хамрагдалт хангалтгүй байна.
- “Нөхөн үржихүйн асуудал” гэдэг сэдэвт эмэгтэйчүүдийг илүү анхаарч эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд гэдэг үгийг сонсож хэвшээгүй, энэ талаар зөвлөгөө мэдээлэл өгөх, үзлэг шинжилгээ хийх нөхцөл бүрдээгүй, эрэгтэйчүүдийн эмч, эмнэлэг, кабинет, нэгж орон нутагт дутагдалтай байна.
- Шийдвэр гаргагчдын жендэрийн талаарх мэдлэг ойлголт нэмэгдэж, Аймаг, сумын ИТХ-ийн төлөөлөгчид болон ЗДТГ-ын удирдах ажилтан нар жендэрийн талаар эерэг ойлголт хандлагатай болж жендэрийн мэдлэмжтэй төлөвлөлт, төсвийг жил бүр нэмэгдүүлж байна. Тухайлбал: “Аз жаргал” төв, “Нэг цэгийн үйлчилгээ”-ний төв болон “Хохирогчийг хамгаалах байр”-ны тогтвортой байдлыг хангах зорилгоор жил бүр орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлэх, Бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх болон хамтран өсвөр үеийнхний эрүүл мэндийг дэмжих чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг ажлуудыг хийж байна. Мөн ЖҮХ-ны дэмжлэгээр хэрэгжиж буй "Иргэний нийгмийн байгууллагын оролцоотойгоор жендэрийн тэгш байдлыг хангах нь" техникийн туслалцааны төслийн хүрээнд зохион байгуулсан уулзалт хэлэлцүүлгийн ажиллагаа болон ОХШҮ-ний ажлын явцад орон нутгийн ИНБ-уудын зөвлөл болон төслийн багийн гишүүдээс гаргасан санал санаачлага, боловсруулсан хөтөлбөрийг дэмжиж “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөр”-ийг 2021 оны 01-р сарын 13-ны өдөр аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар баталж шийдвэрлэсэн байна.
- Асуулга судалгаа, ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага, хэлэлцүүлэгт хамрагдсан иргэдийн дийлэнх хувь нь төрийн байгууллагын зүгээс эрэгтэйчүүдийн онцлог хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх талаар саналууд гаргасан байна.

**Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн ажил олгогч болон ажиллагсдын ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг болон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, ажлын байрны нөхцөл байдлыг тодорхойлох асуудлаар:**

- ЖЭТБХ дэд хөтөлбөрийн 4.1.1-т Аймаг, сумын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын бодлогын баримт бичиг, дотоод журам жендэрийн мэдрэмжтэй боловсруулагдсан байна” гэж хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүнг тодорхойлсон

байна. Энэ ажлын хүрээнд Орон нутгийн төрийн байгууллагууд жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт, төлөвлөлтийг хийх арга зүйд суралцаж, аймаг сумын хөгжлийн бодлого, байгууллагуудын хөгжлийн төлөвлөгөө, дотоод журам, хүний нөөцийн бодлого, хөтөлбөр, төслийг жендэрийн мэдрэмжтэй үзэл баримталыг тусгах талаар санаачлагатай ажиллаж байна.

**Тухайлбал:** Хүний эрхийн үндэсний комисс, Жендэрийн үндэсний хорооны ажлын албанаас өгсөн зөвлөмжийн дагуу Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4 дэх заалт, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын дагуу бүх сум, агентлаг албан байгууллагууд дотоод журмаа шинэчилжээ. Энэ ажил нь хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хийх ажлын үзүүлэлтэд тусгагдсан байна. 2020 онд орон нутгийн төрийн 22 байгууллага "Хөдөлмөрийн дотоод журам"-д ЖЭТБХ талаар чиглэлээр албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, бусдыг бэлгийн болон хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн аливаа хэлбэрээр дарамтлах, хавчин гадуурхах эрхшээлдээ байлгавал ноцтой зөрчил гэж үзнэ" гэж нэмэлт өөрчлөлт оруулж жендэрийн мэдрэмжтэй бодлогыг тусган ажиллажээ. Харин энэ талаар хувийн хэвшил болон аж ахуйн нэгж байгууллагууд ЖЭТБ-ыг хангах дэд хөтөлбөрийн дээрх заалтыг хэрэгжүүлэх талаар санаачлага гаргаагүй, хойрго хандаж, 80 шахам хувь нь байгууллагынхаа "Дотоод журам" болон бодлогын бичиг баримтад ЖЭТБ-ын талаар заалт тусгаагүй байна. Мөн аймгийн ЖЭТБХ дэд хөтөлбөрийг 2018-2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд сургалт мэдээлэл, судалгаа болон нөлөөллийн ажлуудыг төлөвлөөгүй байна.

- Хувийн хэвшлийн болон ААН байгууллагад ажиллаж буй ажилтнуудад жендэрийн талаар сургалт, мэдээллийн үйл ажиллагаа хийдэггүйгээс тэнд ажиллаж буй ажилтан албан хаагчдын жендэрийн талаарх ойлголт болон ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар сайн мэдэхгүй байна.
- Хувийн хэвшил болон ААН байгууллагын ажил олгогч, ажилтны хооронд хийсэн хөдөлмөрийн гэрээнд ажил олгогчийн эрх ашгийг хамгаалсан заалтууд илүү тусдаг бөгөөд хувийн хэвшлийн болон ААН байгууллагад ажиллаж буй ажилчид ЖЭТБ-ын талаар ойлголт мэдлэг байхгүй байгаагаас шалтгаалж байгууллагынхаа дотоод журам, хөдөлмөрийн гэрээ болон бусад бодлогын бичиг баримтанд жендэрийн мэдрэмжтэй ямар асуудал тусгахаа мэдэхгүй байгаагаас шалтгаалж хүүхэд асрах цалинтай чөлөө олгох, амралт авах зэрэг цөөн тооны асуудлаар хязгаарлагдаж байна.
- Байгууллагын хөдөлмөрийн харилцаанд "Хүний нөөцийн бүртгэл судалгаа, хувь хүний ур чадвар, амжилтыг үл харгалзан ажилтныг албан тушаал дэвшүүлэх, шагнаж урамшуулах, шаардлагатай ажлын байр, нөхцөлд ажилтан авахдаа хүйсийн харьцааны тэнцвэртэй байдлыг харгалзахгүй байх, ажлын байрны орон тооны зар мэдээнд нас, хүйс заах, мэдээлэл хүртээмжтэй авах боломжоор хангахгүй байх, хөдөлмөрийн харилцаанд гарсан хүний эрхийн зөрчлийн талаарх өргөдөл, гомдлыг барагдуулахгүй байх, үл ойшоох, цалингийн шатлалд ялгавартай хандах, хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн харилцаанд жендэрээр ялгаварлан гадуурхах, эрэгтэй, эмэгтэй хүйсийн аль нэгэнд давуу эрх олгох, хязгаарлалт тогтоох, жирэмсэн, хүүхэд асарсан болон гэр бүлийн байдлын шалтгаанаар ажилтныг ажлаас халах" гэсэн зөрчлүүд гардаг байна.
- Уул уурхай болон газрын тосны салбарт ажлын байрны дарамт, ажлаас шалтгаангүй халагдах, ажилчдын хүйсийн харьцаа алдагдсан, гадаад дотоодын ажилчдын дунд хөдөлмөрийн хөлсний зөрүү их байгаа зэрэг нь орон нутагт хөдөлмөрийн харилцаанд хүний эрх зөрчигдөж байгааг харуулж байна.

- Хувийн хэвшлийн байгууллага болон ААН байгууллагын хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн тулгамдсан асуудал болон хөдөлмөрийн нөхцөл байдлыг тодорхойлсон судалгаа байхгүй байна.

## ЗӨВЛӨМЖ

Оролцоот хяналт шинжилгээ үнэлгээ /ОХШҮ/- ний ажлын үр дүн, дүгнэлтэнд үндэслэн дараах зөвлөмжийг боловсруулլаа.

**1.ЖЭТБ-ыг хангах дэд хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт, хяналт шинжилгээ үнэлгээний ажлын хэрэгжилтийг сайжруулах талаар:**

**Жендэрийн Үндэсний Хороонд:**

- Төрийн байгууллагын салбар, нэгжүүдэд жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтнийг ажиллуулах, ажил үүргийн тэнцвэрт байдлыг хангуулах талаар зөвлөмж, зааварчилгаа өгөх
- Орон нутгийн Жендэрийн салбар зөвлөлөөс хүргүүлсэн тайлан мэдээний гүйцэтгэлд санал зөвлөмж өгөх, техник арга зүйн дэмжлэг үзүүлэх
- Жендэрийн эрх тэгш байдлын зарчмыг амжилттай хэрэгжүүлж буй улс орнуудын туршлагаас суралцах, үндэсний болон орон нутгийн хэмжээнд гарсан жендэрийн тэгш эрхийн талаарх сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх нөхцөл боломжоор хангах

**Аймаг, сумын ИТХ, ЗДТГ, Хэлтэс, Агентлагийн удирдах ажилтан нарт:**

- Жил бүр дэд хөтөлбөрийн зорилтуудын хэрэгжилтийг хангахуйц төсвийг төлөвлөж батлах
- Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын салбарын жендэрийн нэгдсэн бодлогыг үндэсний болон орон нутгийн дэд хөтөлбөрийн зорилтуудтай уялдуулж төлөвлөх, ажлын гүйцэтгэлд хяналт тавих
- ЖЭТБ-ыг хангах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулахдаа хөтөлбөрийн үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлттэй уялдуулж, биелэлтийг түүнд нийцүүлэн үнэлж байх
- Орон нутгийн төрийн байгууллагын бодлого боловсруулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, тайлан мэдээ гаргах, хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэнг жендэрийн асуудлаар чадавхжуулах
- Орон нутгийн салбар, нэгжүүд өөрсдийн гаргаж буй хүйсээр ангилсан статистик мэдээллийн нэр төрлийг нэмэгдүүлэхэд тусгайлсан төлөвлөгөө, төсвийг гаргаж ажиллах, түүнийг орон нутгийн бодлого төлөвлөлтөнд ашиглах ажлуудыг санаачлагатай хийх
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төлөвлөсөн арга хэмжээний эзлэх хувийг нэмэгдүүлж, төлөвлөгдөөгүй хийгдсэн ажлын тоог бууруулах
- ЖЭТБ-ыг хангах дэд хөтөлбөр болон бусад нийгмийн чиглэлийн төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг тогтмолжуулах, ОХШҮ-ний аргачлалыг нутагшуулах
- Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хөндлөнгийн үнэлгээний ажлын дүгнэлт зөвлөмжийн дагуу ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллах

**2.“Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн ажил олгогч, ажиллагсдын ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг болон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, ажлын байрны нөхцөл байдлыг сайжруулах талаар:**

- Байгууллагын ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгоход чиглэсэн бодлого төлөвлөлтийг орон нутгийн Үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтран боловсруулж, мөрдүүлэх талаар нөлөөллийн ажил зохион байгуулах
- Байгууллагын удирдах ажилтан болон ажиллагсдад жендэрийн асуудлаар сургалт мэдээллийн ажиллагаа зохион байгуулах, тэдэнд зориулсан жендэрийн цахим сургалтын модуль боловсруулан нэвтрүүлэх
- Байгууллагын дотоод журам, бодлогын бичиг баримтуудыг жендэрийн агуулгатай болгох
- Жендэрийн аудитыг хувийн хэвшлийн болон аж ахуйн нэгж байгууллагуудад хийж эхлэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах  чиглэлээр санаачлагатай ажиллах талаар нөлөөллийн ажил явуулах
- Төр, хувийн хэвшил болон олон нийтийн байгууллагын удирдах ажилтан нарт эрэгтэй, эмэгтэй ажилтан нарын ар гэрийн амьдралын тэнцвэрийг хангах талаар мэдлэг ойлголт өгч, зохицуулалт бий болгох
- Байгууллагын хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн тулгамдсан асуудал болон хөдөлмөрийн нөхцөл байдлыг тодорхойлсон үнэлгээ, судалгааны ажлыг ИНБ-уудтай хамтран хийх

**3.Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн нийгмийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэйгээр хүртэх боломжийг нэмэгдүүлэх чиглэлийн хүрээнд “Эрэгтэйчүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж”-ийг сайжруулах талаар:**

- Шийдвэр гаргагчдад эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, түүнд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар нөлөөллийн үйл ажиллагаа явуулах
- Эрэгтэйчүүд, гэр бүл, хамт олон, нийгэмд эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг таниулж оролцоог нэмэгдүүлэх
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчдэд эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн онцлог хэрэгцээг ойлгуулахад чиглэсэн сургалт, сурталчилгаа зохион байгуулах
- Эрэгтэйчүүд хөвгүүдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багцыг тусламж үйлчилгээний шатлал бүрээр тодорхойлох,
- Эрүүл мэндийн хоёрдахь  шатлалын байгууллагад эрэгтэйчүүд, хөвгүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүтцийг одоогийн тогтолцоонд түшиглэн байгуулах, түүнд шаардлагатай нөөцийг бүрдүүлэх
- Эрэгтэйчүүдэд үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж, сэтгэл засалын зөвлөгөө өгөх  болон андарологийн тусламж үзүүлэх эмч мэргэжилтнийг БОЭТ болон сум, өрхийн эрүүл мэндийн төвийн түвшинд бэлтгэх, чадавхжуулах
- Хувийн хэвшлийн аль нэг үүдэн эмнэлгийг түшиглэн эрэгтэйчүүдийн үүдэн эмнэлэг байгуулах, эмчийг сургалтанд хамруулах эдгээрт шаардагдах зардлын асуудлыг орон нутаг шийдвэрлэх
- Эрэгтэйчүүдийн амьдралын эгзэгтэй мөчүүдэд тулгарах сэтгэл зүй, эрүүл мэндийн асуудлуудад зөвлөгөө өгөх бүтцийг төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагаанд түшиглэн хөгжүүлэх

- Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн эрсдэлтэй зан үйлийг өөрчлөхөд чиглэсэн мэдээлэл харилцаа, ухуулга нөлөөллийн үйл ажиллагаа бусад төсөл хөтөлбөрүүдтэй уялдуулах
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эрүүл мэндийн дэмжих хөдөлгөөнийг бүх нийтэд өрнүүлэх
- Эрүүл зан үйлийг төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг оновчтой арга хэлбэрээр, тасралтгүй зохион байгуулах
- Зам тээврийн ослоос сэргийлэх, хөдөлгөөний соёл, замын аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээг авах
- Цэргийн насны эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагааг хүчний байгууллагатай хамтран зохион байгуулах
- Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдлын дүн шинжилгээт мэдээллээр хангах
- Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн онцлог асуудлаар судалгаа хийх
- Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудлаарх судалгааны чадавхийг дэмжих
- “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд Төр, ИНБ-уудын хамтарсан ажлын хэсэг байгуулан, 2021 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргаж шаардлагатай төсвийг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж батлах, хэрэгжилтийг хханган ажиллах

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ


1. Орон нутгийн Жендэрийн дэд хөтөлбөрт оролцоот хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал, 2020 он
2. Олон нийтийн мэдээлэл харилцааны сургалтын гарын авлага, 2020 он, Ийст Мэйвэн ХХК
3. ХНХЯ, Жендэрийн Үндэсний хороо, Азийн хөгжлийн банк, Ядуурлыг бууруулах сан, UNFPA., Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, үндэсний хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө (2017-2021он).,
4. “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж насжилтын зөрүүг бууруулах” талаар гаргасан Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 37 дугаар захирамж“
5. Жендэрийн Үндэсний хороо,UNFPA. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Засгийн газрын дунд хугацааны стратегийн баримт бичиг, үйл ажиллагааны төлөвлөгөө (2013-2016 он).,
6. Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын нэгдсэн дүн
7. Сууръ судалгааны тайлан, 2020
8. МУ-ын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон бусад бодлогын баримт бичиг., УБ хот, 2017 он.
9. МОНЭС, НҮБ-ын итгэлцлийн сан., Өөрчлөлт миний гарт., Багш нарт зориулсан гарын авлага., УБ хот., 2016он
10. МОНЭС НҮБ-ын итгэлцлийн сан., Өөрчлөлт миний гарт., Сурагчдад зориулсан гарын авлага., УБ хот., 2016 он
11. МОНЭС, Жендэрийн эрх тэгш байдал эмэгтэйчүүдийн эрх., УБ хот., 2017 он
12. Дорнод аймаг, UNDP., Дорнод аймаг мянганы хөгжлийн зорилтууд., Дорнод аймаг., 2008 он
13. Монгол улсын эдийн засаг нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэл
14. Дорнод аймгийн эдийн засаг нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэл
15. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
16. УИХ-ын Тамгын Газар, Швейцарийн хөгжлийн агентлаг, НҮБ-н хөгжлийн хөтөлбөр., Нутгийн өөрийн удирдлагын байгууллагын талаарх иргэдийн хандлагын суурь түвшин тогтоох судалгааны тайлан., УБ хот., 2015 он
17. МОНЭС, Эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаар төрийн бус байгууллагуудаас 2012-2015 онд хийсэн судалгаа, мониторингийн тайлангууд., УБ хот., 2016 он
18. MERIT, Олборлох салбарт олон нийтийн хэлэлцүүлэг хийх удирдамж., УБ хот, 2017 он
19. Жендэрийн эрх тэгш байдал, 2017 он, УБ хот, Монголын Эмэгтэйчүүдийн Сан
20. ЛЭОС-Дорнод. (2018). Ажлын байран дахь хүний эрхийн зөрчил. Чойбалсан.
21. ЛЭОС-Дорнод. (2018). Ажлын байран дахь хүний эрхийн зөрчил. Чойбалсан.
22. ИНБ-уудын зөвлөл, Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үзүүлэлтэд нөлөөлж буй зарим хүчин зүйлс судалгаа, Дорнод аймаг, 2019 он
23. Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийж хэрэгжүүсэн ажлын үр дүнгийн өнөөгийн байдал., О.Байгалмаа., 2017 он. Чойбалсан хот
24. Статистик мэдээлийн нэгтгэл 2019. 12 сарТөрийн албан хаагчийн сургалт хөгжил, нийгмийн баталгааг дэмжих хөтөлбөр
25. Дорнод аймгийн нийгэм эдийн засгийн байдал.
26. ГБХЗХГ. (2020). ЖЭБТХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан. 2018-2020 он. Дорнод.
27. ЗДТГ. (2019). ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан . Дорнод

28. ИНБЗөвлөл (2017). ЖЭТБХ дэд хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд зохион байгуулсан тайлан, Чойбалсан хот.
29. ИНБЗ-Дорнод (2019). Хувийн компаны эзэмшил газарт түрээсээр хөдөлмөр эрхэлж буй түрээслэгчдийн ажиллах нөхцөл. Чойбалсан хот.

Цахим эх сурвалж

1. http://www.1212.mn/
2. http://www.dornod.gov.mn
3. http://www.dornod.khural.mn
4. http://www.kherlen.dd.gov.mn
5. http://www.gender.gov.mn

ХАВСРАЛТ

1. Баримт бичгийн жагсаалт
2. Иргэдээс авах асуулгын хуудас -1
3. Иргэдээс авах асуулгын хуудас – 2
4. Чанарын судалгааны удирдамж - 1
5. Ганцаарчилсан ярилцлагын ажлын хуудас -1,2
6. Бүлгийн ярилцлагын удирдамж- 1,2
7. Баримт бичгийн агуулгын матриц
8. Үйл ажиллагааны зураг

**Хавсралт-1**

**АЖИЛЛАХ АРГА БАРИЛ, АРГА ХЭРЭГСЭЛ. /Баримт бичгийн жагсаалт/**

Оролцоот хяналт шинжилгээ үнэлгээний ажлын зорилго, зорилтын хүрээнд 2 үндсэн асуудлыг орон нутгийн жендэрийн тулгамдсан асуудал гэж үзсэн. Үүнд:

- Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн ажил олгогч болон ажиллагсдын ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг болон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, ажлын байрны нөхцөл байдлыг тодорхойлох
- Эрэгтэйчүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг тодорхойлох

Дээрх асуудлын өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэхдээ ОХШҮ-ний аргачлалыг хэрэглэнэ. Үүнд: Баримт бичгийн шинжилгээ, асуулгын арга, чанарын судалгааны арга /Бүлгийн ярилцлага болон ганцаарчилсан ярилцлага/, ажиглалтын арга тус тус хамаарна

**1.БАРИМТ БИЧГИЙН ШИНЖИЛГЭЭ**

**Зорилго:** Орон нутагт хэрэгжиж буй хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд болон төрийн байгууллага болон хувийн хэвшлийн байгуулагуудын дүрэм, журам, тайлан мэдээнд жендэрийн эрх тэгш байдал хангагдаж буй байдлыг тодорхойлно.

**Шинжилгээ хийх баримт бичгийн жагсаалт**

| Бичиг баримт | Код |
|---|---|
| 1. Монгол улсын Хууль тогтоомж | |
| 1.1 ЖЭТБХ тухай хууль болон Үндэсний хөтөлбөр | 1 |
| 2. Захиргааны хэм хэмжээний акт, бичиг баримт | |
| 2.1. ЖЭТБХ дэд хөтөлбөр<br>2.2. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2018-2020<br>2.3. Хөтөлбөрийн санхүүгийн тайлан<br>2.4. Аймгийн ИТХ-ын нийгмийн чиглэлийн хөтөлбөрүүдэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, 2018-2020<br>2.5. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын тайлан: 2018,2019 оны ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэнд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний тайлан<br>2.6. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэнд хийсэн хөндлөнгийн үнэлгээний тайлан, 2018-2020 он<br>2.7. Засаг даргын мөрийн хөтөлбөрийн биелэлт 2016-2020 он<br>2.8. Аймгийн 2018, 2019 оны үндсэн чиглэлийн биелэлт | 2 |
| 3.Байгууллагын дүрэм, журам, тайлан | |
| 3.1. ЭМГ, БОЭТ-н жилийн ажлын төлөвлөгөө, тайлан мэдээ (2018-2020 он)<br>3.2. Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн талаарх мэдээлэл (2018-2020 он)<br>3.3.Хувийн хэвшлийн болон ААН, байгууллагын дүрэм, дотоод журам, төлөвлөгөө, хүйсийн тэнцвэртэй байлын тухай тайлан (2018-2020 он)<br>3.4. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан талаарх тайлан, мэдээ<br>3.5. “Аз жаргал” төвийн үйл ажиллагаа, төсвийн тайлан мэдээ<br>3.6.Өргөдөл гомдол шийдвэрлэсэн мэдээлэл (Аймаг, сумын ИТХ-ын нутгийн удирлага, өргөдөл. гомдол, хяналт үнэлгээний бодлогын хороо, аймаг, сумын ЗДТГ, ХЭҮК-ийн аймгийн салбар зөвлөл, аймгийн ҮЭХ, аймгийн Ажил олгогчдын эздийн холбоо)<br>3.7.Ажлын байран дахь хүний эрхийн зөрчлийг шийдвэрлэсэн талаарх мэдээлэл (Хууль хяналтын байгууллага) | 3 |

**Хавсралт-2**

**БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГЫН МАТРИЦ**

| № | Баримт бичгийн нэр | Дугаар огноо | Хуудас | Эшлэл | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1.1 | ЖЭТБХ тухай хууль | 2011 оны 2 дугаар сарын 2-ны өдөр | 11 дугаар зүйл<br><br>13 дугаар зүйл | Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгаа<br>Эрүүл мэндийн салбар дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгаа | 11.1-11.9 дүгээр заалтууд үнэлгээний асуудалд хамаарна.<br>13.1. 13.2.<br>13.4. 13.5 эдгээр заалтууд үнэлгээний асуудалд хамаарна. |
| 1.2 | ЖЭТБХҮндэсний хөтөлбөр | Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолын хавсралт | 2 дугаар бүлэг<br><br>3дугаар бүлэг<br><br>6дугаар бүлэг | Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа<br>Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа<br>Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ | 2.2.1 2.2.2 2.2.3 2 .2.5 хүртэлх заалтууд 3.1.1-3.1.6 хүртэлх заалтууд.<br>3.1.9-3.1.13 дугаар заалтууд<br>3.2.6-3.2.8хүртэл заалтууд<br>3.3.13 3.5.4<br>6.3.2. 6.4 |
| 1.3 | ЖЭТБХ дэд хөтөлбөр | 2018.04.25 | Зорилт 1<br><br>Зорилт 3<br><br>Зүйл 4 | 3.1 Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн цогц арга хэмжээ<br>3.3.4 Аймаг орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжилд жендэрийн эрх тэгш оролцоог дэмжиж хөгжлийн үр шимээс эрэгтэй эмэгтэй хүн тэгш боломжийг нэмэгдүүлэх\<br>Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт | 3.1.3<br><br>3.3.1 3.3.4<br><br>4.1.1 4.1.3 4.1.4 |
| 2.1 | ЖДХ-ийн хэрэгжилтийн тайлан, 2018-2020 он | 2018-2020 он | | | ОХШҮ-ний чиглэсэн асуудлын хүрээнд хийсэн ажлын талаарх мэдээллийг цуглуулах |
| 2.2 | Хөтөлбөрийн санхүүгийн тайлан | 2018-2020 он | | | ОХШҮ-ний чиглэсэн асуудлын хүрээнд 4-н жилийн хугацаанд зарцуулсан төсвийн тоо хэмжээ, үр нөлөөг тодорхойлох |
| 2.3 | Аймгийн ИТХ-аас нийгмийн чиглэлийн хөтөлбөрүүдэд хийсэн хяналт-шинжилгээ, | 2020 он | | | ОХШҮ-ний чиглэсэн асуудлын хүрээнд хийсэн хяналт, шинжилгээ үнэлгээний үр дүнд анализ хийх |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | үнэлгээний тайлан, 2018-2020 | | | | |
| 2.4 | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын тайлан: 2018- 2020 оны ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэнд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний тайлан | 2019-2020 | | | ОХШҮ-ний чиглэсэн асуудлын хүрээнд хийсэн хяналт, шинжилгээ үнэлгээний үр дүнд анализ хийх |
| 2.6 | ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэнд хийсэн хөндлөнгийн үнэлгээний тайлан, 2018-2020 он. | 2018-2020 он | | | ОХШҮ-ний чиглэсэн асуудлын хүрээнд хийсэн хяналт, шинжилгээ үнэлгээний үр дүнд анализ хийх |
| 2.7 | Засаг даргын мөрийн хөтөлбөрийн биелэлт, 2016-2020 он | 2018-2020 он | | | ОХШҮ-ний чиглэсэн асуудлын хүрээнд хийсэн ажлын талаарх мэдээллийг цуглуулах |
| 2.8 | Аймгийн 2018-2020 оны үндсэн чиглэлийн биелэлт | 2018-2020 он | | | ОХШҮ-ний чиглэсэн асуудлын хүрээнд хийсэн ажлын талаарх мэдээллийг цуглуулах |
| 3.1 | ЭМГ, БОЭТ-ийн жилийн ажлын төлөвлөгөө, тайлан мэдээ (2018-2020 он) | 2018-2020 он | | | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан эрэгтэйчүүдийн талаарх тоо мэдээ, чанарын дүгнэлт, зарцуулсан төсөв, төсвийн гүйцэтгэл |
| 3.2 | Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн талаарх мэдээлэл (2018-2020 он) | 2018-2020 он | | | Цэргийн насны эрэгтэйчүүдийн үзлэгийн тоо, харьцуулсан дүгнэлт |
| 3.3 | Хувийн хэвшлийн болон ААН, байгууллагын дүрэм, дотоод журам, төлөвлөгөө, хүйсийн тэнцвэртэй байдлын тухай | 2018-2020 он | | | Жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, төсөвлөлт, хяналтын талаарх мэдээлэл цуглуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | тайлан (2018-2020 он) | | | | |
| 3.4 | Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан талаарх тайлан, мэдээ | 2018-2020 он | | | Эрэгтэйчүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар мэдээлэл цуглуулах |
| 3.5 | “Аз жаргал” төвийн үйл ажиллагаа, төсвийн тайлан мэдээ | 2018-2020 он | | | Үйлчилгээ авсан өсвөр насны хөвгүүдийн тоо, үйлчилгээний төрөл, хэлбэр, зарцуулсан төсөв |
| 3.6 | Өргөдөл гомдол шийдвэрлэсэн мэдээлэл (Аймаг, сумын ИТХ-ын нутгийн удирлага, өргөдөл, гомдол, хяналт үнэлгээний бодлогын хороо, аймаг, сумын ЗДТГ, Хууль хяналтын байгууллага, ХҮЭК-ийн салбар хороо, аймгийн ҮЭХ, аймгийн Ажил олгогчдын эздийн холбоо) | 2018-2020 он | | | ОХШҮ-ний чиглэсэн асуудлын хүрээнд иргэдээс ирсэн өргөдөл гомдлын тоо, шийдвэрлэлтийн өнөөгийн байдлыг тодорхойлох |

**ДҮГНЭЛТ ЗӨВЛӨМЖ**

**Чиглэсэн асуудал 1**: **Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн ажил олгогч болон ажиллагсдын ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг болон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, ажлын байрны нөхцөл байдлыг тодорхойлох ажлын хүрээнд**

a.**Хэрэгжсэн үйл ажиллагаа, гүйцэтгэл, үр дагавар**

- Ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх талаар заалтуудыг 6 хувийн хэвшлийн байгууллагууд дотоод журамдаа оруулж тусгах талаар чиглэл өгсөн.
- Хөдөлмөрийн хэвийн болон хэвийн бус нөхцөл, улирлын чанартай ажлын байранд ажиллаж буй ажиллагсдын хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, бүтээмжийг тооцох, цалин хөлсний зохистой тогтолцоог бүрдүүлэх зорилгоор хувийн хэвшлийн 12 байгууллагын 350 ажиллагсдад мэдээлэл, арга зүйн зөвлөгөө өгсөн.
- “Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа ба үүрэг оролцоо” сэдэвт хэлэлцүүлэгт 12 байгуулллагын 100 ажилтан, албан хаагчид хамрагдсан./Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгох, эрэгтэй эмэгтэй ажилтанд адил хэмжээний хөлс олгох, иргэнийг ажилд авахад хүйсээр ялгаварлахгүй байх, ажлын байран дахь хүчирхийллээс сэргийлэх тухай/

b. **Хэрэгжээгүй орхигдсон үйл ажиллагаа, яагаад, ямар үр дагавартай**

ЖЭТБХ дэд хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд:

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн чадавхийг бэхжүүлэх

- Төрийн байгууллагын удирдах ажилтан албан хаагчдын дунд жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсвийн талаар сургалт мэдээллийн ажиллагаа зохион байгуулах
- Орон нутгийн нийгмийн чиглэлийн төсөл хөтөлбөрүүдийн уялдаа холбоог хангах, жендэрийн мэдрэмжтэй төсөл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх
- Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлж тогтвортой байдлыг хангах ажлын хүрээнд сургагч багш бэлтгэх, өсвөр насны хүүхдийн жендэрийн талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр голчлон ажилласан байна.

Харин бүх нийтэд жендэрийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд аж ахуйн нэгж байгуллага иргэдэд зориулсан жендэрийн сургалт мэдээллийн ажиллагаа маш бага хийгдсэн байна. Мөн хувийн хэвшлийн байгууллагуудын ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгох, эрэгтэй эмэгтэй ажилтанд адил хэмжээний цалин хөлс олгох, иргэдийг ажилд авахад хүйсээр ялгаварлахгүй байх, ажлын байран дахь хүчирхийллээс сэргийлэх ажлыг төр ИНБ-уудтай хамтран хийх гэсэн заалт хэрэгжээгүй байна

**Зөвлөмж**

- Жендэр болон жендэрийн эрх тэгш байдал, жендерийн мэдрэмжтэй төлөвлөлт, төсөвлөлтийн талаар хувийн хэвшлийн болон ААН удирдах ажилтан болон ажиллагсдын ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх талаар сургалт, мэдээллийн ажиллагаа зохион байгуулах

- Хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн харилцаанд жендэрээр ялгаварлан гадуурхах, Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжид зөвшөөрснөөс бусад тохиолдолд эрэгтэй, эмэгтэй хүйсийн аль нэгэнд давуу эрх олгох, хязгаарлалт тогтоох, эмэгтэй, эрэгтэй ажилтанд ажил, гэр бүлийн үүргээ хослуулах, хүүхэд төрүүлэх, асрах нөхцөл бололцоо олгох, эрүүл мэндээ хамгаалах, хөдөлмөрийн аюулгүй нөхцөлд ажиллах, ижил ажилд адил цалин, нэмэгдэл хөлс тогтоох, хүүхэд асарсан болон гэр бүлийн байдлын шалтгаанаар ажилтныг ажлаас халахыг хориглосон талаарх заалтыг байгууллагын дүрэм, дотоод журам, хөдөлмөрийн гэрээнд тусгаж өгөх

- Аж ахуйн нэгж болон хувийн хэвшлийн байгууллагуудын ажлын байр болон хөдөлмөрийн харилцаанд түгээмэл байдаг ажлын байрны орон тооны зар мэдээнд нас, хүйс заах, аль нэг хүйсийг давуу гэж үзэх, ажил хөдөлмөр гүйцэтгэсэн өдрийн хөдөлмөрийн хөлсийг олгохгүй байх, хүний нөөцийн бүртгэл судалгаа, хувь хүний ур чадвар, амжилтыг үл харгалзан ажилтныг албан тушаал дэвшүүлэх, шагнаж урамшуулах, ажилтан авахдаа хүйсийн харьцааны тэнцвэртэй байдлыг харгалзахгүй байх, хөдөлмөрийн харилцаанд гарсан зөрчлийн талаарх өргөдөл,гомдлыг барагдуулахгүй байх, үл ойшоох зэрэг жендэрийн сөрөг асуудлуудыг гаргуулахгүй байх талаар урьдчилан сэргийлэх ажлуудыг төр, ИНБ-уудын зүгээс хийх, энэ талаар сургалт мэдээлэл, уулзалт хэлэлцүүлгийн ажиллагаа зохион байгуулах

**Чиглэсэн асуудал 2: Эрэгтэйчүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг тодорхойлох чиглэлээр хэрэгжсэн үйл ажиллагаа**

а.Хэрэгжсэн үйл ажиллагаа, гүйцэтгэл, яагаад, ямар үр дагавартай

- Эрчүүдийн эрүүл мэндийг дэмжих тусгай урологи тасгийг Бүсийн оношлогоо эмчилгээний төвийг түшиглэн нээн ажиллуулахаар холбогдох байгууллагуудад албан тоот хүргүүлж, нөлөөллийн ажлуудыг хийж
- Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн мэс заслын их эмчийг урологийн чиглэлээр мэргэшүүлэн сургаж, тусламж, үйлчилгээг үзүүлж эхэлсэн ба андрологи буюу эрэгтэйчүүдийн эмчийг тусгайлан бэлтгэх улмаар кабинет нээн ажиллуулах чиглэл барин ажиллаж байна. (орон нутгийн төсвөөр)
- Эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд", "Бэлгийн замаар дамжих халдварт өвчин" сэдвээр сургагч багш бэлтгэж, түгээн дэлгэрүүлсэн( орон нутгийн төсвөөр 21 төрийн байгууллагын 56 эрэгтэй ажилтан, албан хаагчид сургагч багшаар бэлтгэгдэж 856 албан хаагчдад сургалтыг түгээсэн байна.)
- Аз жаргал төв, сургалтаар 14-18 насны өсвөр үе, залуучуудад нөхөн үржихүйн мэдлэг, мэдээлэл, тусламж үйлчилгээ үзүүлсэн. (орон нутгийн төсвөөр 8220 хүнд хүрч ажилласан байна)

| | |
|---|---|
| | • Их Дээд сургууль, ЕБС болон Политехникын коллеж, МСҮТ-ийн хөвгүүдийг төрөлжсөн мэргэжлийн эмч нарын эрт илрүүлэг үзлэг, шинжилгээнд 100 хувь хамруулсан.( Өсвөр үе, залуучуудыг эрүүл мэндийг дэмжих" төслийн хүрээнд 30 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулж 1598 хөвгүүд хамрагдсан байна.)<br><br>**b. Хэрэгжээгүй орхигдсон үйл ажиллагаа, яагаад, ямар үр дагавартай**<br>• Эрэгтэйчүүд судлал, эрэгтэйчүүдэд үзүүлэх цогц үйлчилгээний эхлэл тавигдсан байна Эрэгтэйчүүдийн өмнө тулгамдаж буй олон талт асуудлыг цогцоор нь судлах хэрэгцээ шаардлагыг бодлогын түвшинд тодорхойлж чадаагүйгээс энэ үйл ажиллагаа орхигдсон байна. Энэ үйл ажиллагааг орхигдуулснаар эрэгтэйчүүдэд шаардлагатай байгаа цогц үйлчилгээг тодорхойлох боломжгүй юм.<br>• Эрэгтэйчүүд болон хөвгүүдэд зориулсан кабинетийг байгуулан эрүүл мэндийн үзлэг оношилгоо, сэтгэл зүйн зөвлөгөө бусад үйлчилгээг нэмэгдүүлэх<br>Эрэгтэйчүүд, хөвгүүдэд зориулсан кабинетийг байгуулах бодлого, шийдвэр гараагүй, түүнд зарцуулах төсвийн судалгаа хангалттай хийгдэж танилцуулагдаагүй, энэ асуудалд төрийн анхаарлыг хандуулахыг иргэд шаардлагыг хангалттай сайн тавиагүй байна. Мөн салбарын байгууллагын идэвх оролцоо хангалтгүй байсан байна. Эдгээр шалтгааны улмаас кабинет байгуулах зорилгоор эхлүүлсэн ажлынн эцсийн үр дүн тодорхойгүй, үр ашиггүй нөөцийн зарцуулалт болсон байна.<br><br>**Зөвлөмж:**<br>Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгмийн харилцаанд ижил тэгш оролцох боломжийг нэмэгдүүлэх, нийгмийн үйлчилгээг хүртэх боломж хүйсийн хувьд зөрүүтэй байгаагаас үүсэх сөрөг үр дагаварыг судлан тодорхойлж урьдчилан сэргийлэх, стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Иймд жендэрийн эрх тэгш байдлыг хангахад шаардлагатай байгаа эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, эрэгтэйчүүдийн өмнө тулгарч буй цогц асуудлыг судлан тодорхойлох үйл явцыг орон нутгийн их сургуулийн хүний нөөцөд тулгуурлан зохион байгуулж урьдчилан сэргийлэх болон хариу үйлчилгээг хөгжүүлэхэд салбарын байгууллагын санаачилгыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.<br><br>Иймээс бидний хийх хяналт шинжилгээ үнэлгээний ажил нь эдгээр асуудлын өнөөгийн нөхцөл байдлыг үнэн зөв тодорхойлж олны анхааралд хүргэхэд тус дөхөм болно |

**Хавсралт-3**

## ИРГЭДЭЭС АВАХ АСУУЛГЫН ХУУДАС- 1

Жендэрийн үндэсний хороо, Азийн хөгжлийн банк Иргэний нийгмийн оролцоотой жендэрийн тэгш байдлыг хангах техник туслалцааны дэмжлэгтэйгээр аймгийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээний аргачлалаар үнэлэх ажлыг Дорнод аймгийн иргэний нийгмийн байгууллагуудын зөвлөл зохион байгуулж байна.

Энэхүү санал асуулга нь хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжийн хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөдөлмөрийн харилцаа нь жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байж, ажлын байранд жендэрийн эрх тэгш байдлыг хангаж буй эсэхийг тодорхойлох зорилготой тул таны өгч буй хариултууд үнэ цэнэтэй мэдээлэл болно. Мэдээллийн нууцыг Монгол улсын “Статистикийн тухай”, “Хувь хүний нууцын тухай” хуулиудын дагуу бусдад задруулахгүй байх үүргийг судалгааны багийн гишүүд хүлээнэ.

| **Хяналтын хэсэг** | **Бичих** |
|---|---|
| Аймгийн нэр | |
| Сумын нэр | |
| Багийн нэр | |
| Мэдээлэл цуглуулагчийн нэр, утас | |
| Мэдээллийг шалгасан судлаачийн нэр, утас | |

| **Судалгаа эхэлсэн** | | |
|---|---|---|
| Сар, өдөр | | |
| Цаг | | |
| Минут | | |
| **Судалгаа дууссан** | | |
| Цаг, минут | | |

1. **Таны нас .........................** (бичнэ үү?)
2. **Таны хүйс** a. Эрэгтэй b. Эмэгтэй
3. **Таны боловсрол?**
   1. Дээд
   2. Тусгай дунд
   3. Бүрэн дунд
   4. Бүрэн бус дунд
   5. Бага
   6. Боловсролгүй

**4. Та хэд дүгээр багт харъяалагддаг вэ? .....................................................**(бичнэ үү?)

**5. Танай өрхийн ам бүлийн тоо: ..................................................................** (бичнэ үү?)

**6.Таны ажилладаг байгууллага дараах ангиллын алинд нь хамаарах вэ?**

a. Төрийн өмчит уул уурхайн аж ахуйн нэгж
b. Хувийн өмчит уул уурхайн аж ахуйн нэгж
c. Төрийн өмчит ХХК
d. Барилгын салбар
e. Нийтийн худалдаа
f. Нийтийн хоол
g. Бусад…………………………………………………………………………(бичнэ үү?)

**7. Таны эрхэлж буй ажил**

a. Удирдах ажилтан
b. Нарийн мэргэжлийн
c. Туслах
d. Үйлчилгээний
e. Гэрээт
f. Бусад……………………………………………………………………...(бичнэ үү?)

**8. Таны ажилласан жил: ……………………………………………………………**(бичнэ үү?)

**9. Таны гэр бүлийн байдал:**

a. Гэрлээгүй
b. Гэрлэсэн
c. Салсан
d. Бэлэвсэн

**ҮНДСЭН АСУУЛГА**

1. **Жендэр хэмээх ойлголтыг аль нь илэрхийлж байна вэ?**
a. Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах тухай ойлголт
b. Эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшин дэх оролцоог нэмэгдүүлэх тухай ойлголт
c. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгэм, соёлын ялгаатай болохыг тайлбарласан ойлголт
d. Хаана ч эрэгтэй, эмэгтэй хүмүүс тооны хувьд тэнцвэртэй байлгах тухай ойлголт
e. Нийгэм дэх эрэгтэй эмэгтэй хүмүүсийн тэгш эрх, тэгш боломж, тэш оролцоо, тэгш байдал, эрх тэгш шийдвэрийн тухай ойлголт
f. Бусад ........................................................................................................(бичнэ үү?)

**2. Дараах бодомжуудыг уншаад зөв, буруу болохыг зохих нүдэнд нь ✓ тэмдэглэнэ үү?**

| Бодомж | Зөв | Буруу |
|---|---|---|
| 1.Өрхийн тэргүүн эрэгтэй хүнийг илүү хүндэтгэх ёстой. | | |
| 2. Сайн эхнэр бол нөхрийнхөө үгэнд орох ёстой | | |
| 3. Эр хүн бол өрх гэр бүлээ авч явагч, тэжээгч | | |
| 4.Залуу эмэгтэйчүүд жирэмсэн болж, хүүхэдтэй болох тул ажилд авах хэрэггүй | | |

**3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах нь таны амьдралд хэр нөлөөтэй гэж үзэж байна вэ?**
a. Эерэг нөлөөтэй
b. Ямар ч нөлөөгүй
c. Сөрөг нөлөөтэй
d. Мэдэхгүй

**4. Та байгууллагынхаа хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлыг дараах шалгуур үзүүлэлтүүдээр хэмжиж үнэлнэ үү?.**

| Үзүүлэлтүүд | Маш сайн | Сайн | Дунд | Муу | Маш муу |
|---|---|---|---|---|---|
| 1.Хөдөлмөрийн эрүүл, аюулгүй байдал | 5 | 4 | 3 | 2 | 1 |
| 2.Эрүүл мэндийг хамгаалах дэмжлэг | 5 | 4 | 3 | 2 | 1 |
| 3.Ажлын ачааллын тэнцвэржүүлэлт | 5 | 4 | 3 | 2 | 1 |
| 4.Албан тушаал ахих боломж | 5 | 4 | 3 | 2 | 1 |
| 5.Ажлын байрандаа хөгжих боломж | 5 | 4 | 3 | 2 | 1 |
| 6. Үзэл бодлоо илэрхийлэх | 5 | 4 | 3 | 2 | 1 |
| 7.Шударгаар хөдөлмөрөө үнэлүүлэх, шагнал, урамшуулал авах | 5 | 4 | 3 | 2 | 1 |
| 8.Нийгмийн хамгааллын тусламж дэмжлэг хүртэх | 5 | 4 | 3 | 2 | 1 |
| 9.Мэдээллийн ил тод байдал | 5 | 4 | 3 | 2 | 1 |
| 10. Ажил, ар гэрийн тэнцвэрийг хангах зохицуулалт хийсэн байдал | 5 | 4 | 3 | 2 | 1 |

**5. Танай байгууллагын хөдөлмөрийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг алдагдуулсан дараах нөхцөл байдаг уу?.**

| Үзүүлэлтүүд | Их | Дунд | Бага | Байхгүй | Мэдэхгүй |
|---|---|---|---|---|---|
| 1.Цалин хөлсийг ялгаатай тогтоох | 5 | 4 | 3 | 2 | 1 |
| 2.Ажлын байрны дарамт, ялгаварлан гадуурхах | 5 | 4 | 3 | 2 | 1 |
| 3.Хууль бусаар ажлаас халах, чөлөөлөх, ажилд авах | 5 | 4 | 3 | 2 | 1 |
| 4. Авлига хээл хахууль өгөх, авах | 5 | 4 | 3 | 2 | 1 |
| 5. Ажилчдын санал бодол шийдвэрт үл тусах | 5 | 4 | 3 | 2 | 1 |

**6. Танай байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд дараах хэм хэмжээнээс аль нь туссан байдаг вэ?. (олон сонголт хийж болно)**
a. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаархи ажил олгогч болон ажилтны эрх үүрэг хариуцлагын тухай
b. Ажлын байранд жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах тухай
c. Иргэнийг ажил авахад хүйсээр ялгаварлахгүй байх тухай
d. Жендэрийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтын талаар ойлголт, мэдээлэл авах,

сургалтад хамрагдах тухай

e. Ар гэр, хүүхдийн асуудлаар чөлөө авах тухай
f. Уурхайн ААН-ийн хувьд хүйсээр ангилсан ариун цэврийн өрөөгөөр хангах тухай
g. Уурхайн ААН-н хувьд амьдрах байр, кемпээр хангах тухай
h. Уурхайн ААН-ийн хувьд эрэгтэй, эмэгтэй ажилтны росторыг ялгаатай тогтоох тухай
i. Дээрх бүгд тусгагдаагүй
j. Мэдэхгүй

**7. Танай байгууллагын хамтын гэрээ, хэлэлцээрт дараах хэм хэмжээнээс аль нь туссан байдаг вэ?(олон сонголт хийж болно)**

a. Эмэгтэй, эрэгтэй ажилтанд ажил, гэр бүлийн үүргээ хослуулах тухай
b. Хүүхэд төрүүлэх, асрах нөхцөл бололцоо олгох тухай
c. Эрүүл мэнддээ анхаарах, хамгаалах тухай
d. Хөдөлмөрийн аюулгүй нөхцөлд ажиллах тухай
e. Ижил ажилд цалин, нэмэгдэл хөлс ижил хэмжээгээр тогтоох тухай
f. Асуудал шийдэхэд талуудын оролцоог хангах, санал авах тухай
g. Бусад.............................................................................................................(бичнэ үү?)
h. Мэдэхгүй

**8. Байгууллагын хөдөлмөрийн харилцаанд гардаг дараах асуудлуудаас танай байгууллагад аль нь байдаг вэ? (олон сонголт хийж болно)**

a. Ажлын байрны орон тооны зар мэдээнд нас, хүйс заах
b. Мэдээлэл хүртээмжтэй авах боломжоор хангахгүй байх
c. Аль нэг хүйсийг давуу гэж үзэх
d. Ажил хөдөлмөр гүйцэтгэсэн өдрийн хөдөлмөрийн хөлсийг бүрэн олгохгүй байх
e. Хүний нөөцийн бүртгэл судалгаа, хувь хүний ур чадвар, амжилтыг үл харгалзан ажилтныг албан тушаал дэвшүүлэх, шагнаж урамшуулах
f. Шаардлагатай ажлын байр, нөхцөлд ажилтан авахдаа хүйсийн харьцааны тэнцвэртэй байдлыг харгалзахгүй байх
g. Хөдөлмөрийн харилцаанд гарсан хүний эрхийн зөрчлийн талаарх өргөдөл, гомдлыг барагдуулахгүй байх, үл ойшоох

**9. Таны ажил амралтын хоногийн харьцаа аль нь вэ?. (**Уул уурхайн салбарт ажиллаж буй ажилтан хариулна**)**

a. Ажил амралтын тэнцүү хуваарьтай
b. Амрах хугацаанаасаа 7-20 хоногоор илүү ажилладаг
c. Бусад.............................................................................................................(бичнэ үү?)

**10. Таны өөрийн өмнө тулгамдаж буй асуудлаа сонгоно уу?**

a. Хөдөлмөрийн бүтээмж буурах
b. Ажил мэргэжлээс шалтгаалах өвчин тусах
c. Гэр бүлийн тогвортой харилцааг авч үлдэх
d. Ажлын байр солих
e. Бусад …………………………………………………………………………………
(бичнэ үү?)
f. Тулгамдсан асуудал байхгүй

**11. Та Дорнод аймагт Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр хэрэгжиж байгаа талаар сонсож байсан уу?**

a. Тийм
b. Үгүй

**12. Та орон нутагт жендэрийн асуудлаар зохион байгуулсан ямар үйл ажиллагаанд хамрагдсан бэ? Үүнд:**

a. Сургалт
b. Уулзалт, хэлэлцүүлэг
c. Өдөрлөг арга хэмжээ
d. Судалгаа

e. Төсөл
f. Хамрагдаж байгаагүй
g. Бусад ..........................................................................................................(бичнэ үү?)

**13. ОНЖДХ-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд ямар нэгэн үйл ажиллагаа зохион байгуулбал та оролцох уу?**

a. Оролцоно,
b. Оролцохгүй
c. Мэдэхгүй

**14.** Хэрэв оролцох бол ямар хэлбэрээр оролцох вэ?

a. Жендэрийн мэдлэгээ дээшлүүлэх сургалтад хамрагдана
b. Байгууллагын түвшинд ЖЭТБ-ыг хангах хүрээнд ажил олгогч, төр, ИНБ-тай хамтарч төсөл, арга хэмжээ хэрэгжүүлнэ
c. Би гэр бүл, ажлын хүрээнд хувь нэмрээ оруулахаар зорино
d. Монголд жендэрийн асуудал байхгүй тул оролцох шаардлагагүй
e. Хүн бүрт хамаатай асуудал биш, хамаатай хүмүүс, байгууллага нь ажиллах ёстой
f. Мэдэхгүй

**15. Байгууллагынхаа хөдөлмөрийн харилцаанд гарч буй жендэрийн тулгамдсан асуудлыг хэрхэн шийдвэрлэх тухай өөрийн саналаа бичнэ үү.**

..........................................................................................................................................
..........................................................................................................................................
..........................................................................................................................................
..........................................................................................................................................
..........................................................................................................................................
..........................................................................................................................................
..........................................................................................................................................

**Танд баярлалаа.**

**Хавсралт-4**

ИРГЭДЭЭС АВАХ АСУУЛГЫН ХУУДАС- 2

Жендэрийн үндэсний хороо, Азийн хөгжлийн банк Иргэний нийгмийн оролцоотой жендэрийн тэгш байдлыг хангах техник туслалцааны дэмжлэгтэйгээр аймгийн “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээний аргачлалаар үнэлэх ажлыг Дорнод аймгийн Иргэний нийгмийн байгууллагуудаас зохион байгуулж байна.

Энэхүү санал асуулга нь эрэгтэйчүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг зорилтот бүлгээр үнэлүүлж жендэрийн тулгамдсан асуудлыг тодорхойлох зорилготой тул таны өгч буй мэдээлэл үнэ цэнэтэй байх болно. Мэдээллийн нууцыг Монгол улсын “Статистикийн тухай”, “Хувь хүний нууцын тухай” хуулиудын дагуу бусдад задруулахгүй байх үүргийг судалгааны багийн гишүүд хүлээнэ.

| **Хяналтын хэсэг** | **Бичих** |
|---|---|
| Аймгийн нэр | |
| Сумын нэр | |
| Багийн нэр | |
| Мэдээлэл цуглуулагчийн нэр, утас | |
| Мэдээллийг шалгасан судлаачийн нэр, утас | |

| **Судалгаа эхэлсэн** | | |
|---|---|---|
| Сар, өдөр | | |
| Цаг | | |
| Минут | | |
| **Судалгаа дууссан** | | |
| Цаг, минут | | |

**НЭГ.МЭДЭЭЛЭЛ**

**1. Таны нас** ............................................................................................................ (бичнэ үү?)

**2. Таны хүйс** a. Эрэгтэй b. Эмэгтэй

**3. Таны боловсрол?**

a. Дээд
b. Тусгай дунд
c. Бүрэн дунд
d. Бүрэн бус дунд
e. Бага
f. Боловсролгүй

**6. Та хэд дүгээр багт харъяалагддаг вэ?**........................................................ (бичнэ үү?)

**7. Танай өрхийн ам бүлийн тоо:** ..................................................................... (бичнэ үү?)

**8. Таны ажилладаг байгууллага дараах ангилалын алинд нь хамаарах вэ?**

a. Төрийн өмчит уул уурхайн аж ахуйн нэгж
b. Хувийн өмчит уул уурхайн аж ахуйн нэгж
c. Төрийн өмчит ХХК
d. Барилгын салбар
e. Нийтийн худалдаа
f. Нийтийн хоол
g. Бусад……………………………………………………………………………….(бичнэ үү?)

**9. Таны эрхэлж буй ажил**

a. Удирдах ажилтан
b. Нарийн мэргэжлийн
c. Туслах
d. Үйлчилгээний
e. Гэрээт
f. Бусад……………………………………………………………………………..(бичнэ үү?)

**10. Таны ажилласан жил:** ………………………………………………………………..(бичнэ үү?)

**11. Таны гэр бүлийн байдал:**

a. Гэрлээгүй
b. Гэрлэсэн
c. Салсан
d. Бэлэвсэн

**12. Та эрүүл мэндийн даатгалд хамрагдсан уу?**

a. Тийм
b. Үгүй

**ХОЁР. ҮНДСЭН АСУУЛТ**

**1. Жендэр хэмээх ойлголтыг аль нь илэрхийлж байна вэ?**

a. Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах тухай ойлголт
b. Эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшин дэх оролцоог нэмэгдүүлэх тухай ойлголт
c. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгэм, соёлын ялгаатай болохыг тайлбарласан ойлголт
d. Хаана ч эрэгтэй, эмэгтэй хүмүүс тооны хувьд тэнцвэртэй байлгах тухай ойлголт
e. Нийгэм дэх эрэгтэй эмэгтэй хүмүүсийн тэгш эрх, тэгш боломж, тэш оролцоо, тэгш байдал, эрх тэгш шийдвэрийн тухай ойлголт
f. Бусад ............................................................................................ (бичнэ үү)

**2. Дараах бодомжуудыг уншаад зөв, буруу болохыг зохих нүдэнд нь ✓ тэмдэглэнэ үү?**

| Бодомж | Зөв | Буруу |
|---|---|---|
| 1.Өрхийн тэргүүн эрэгтэй хүнийг илүү хүндэтгэх ёстой. | | |
| 2. Сайн эхнэр бол нөхрийнхөө үгэнд орох ёстой | | |
| 3. Эр хүн бол өрх гэр бүлээ авч явагч, тэжээгч | | |
| 4.Залуу эмэгтэйчүүд жирэмсэн болж, хүүхэдтэй болох тул ажилд авах хэрэггүй | | |

**3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах нь таны амьдралд хэр нөлөөтэй гэж үзэж байна вэ?**

a. Эерэг нөлөөтэй
b. Ямар ч нөлөөгүй
c. Сөрөг нөлөөтэй
d. Мэдэхгүй

**4. Та сүүлийн 2 жилд эрүүл мэндийн ямар тусламж үйлчилгээ авсан вэ? Үүнд:**

a. Амбулаторын тусламж үйлчилгээ
b. Стационарийн тусламж үйлчилгээ
c. Өдрийн эмчилгээ
d. Рашаан сувилалын тусламж үйлчилгээ
e. Эмийн үнийн хөнгөлөлт
f. Оношилгоо, шинжилгээ
g. Уламжлалт эмчилгээ
h. Хөнгөвчлөх эмчилгээ
i. Өөр бусад ..............................................................................................(бичнэ үү?)
j. Авч байгаагүй /Энэ хариултыг сонгосон бол 6 дугаар асуулт руу шилжинэ үү./

**5.Та сүүлийн 2 жилд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч байгаагүй шалтгаанаа сонгоно уу.**

a. Зав гардаггүй тул
b. Өвдөх зовиурлах зүйл байдаггүй тул
c. Өвдвөл очно
d. Өвдсөн ч тоохгүй орхидог тул
e. Оочер, үйлчилгээ нь чирэгдэлтэй тул
f. Бусад.............................................................................................. (бичнэ үү?)

**6. Дээрх үйлчилгээг та аль шатлалын эмнэлгээс ихэвчлэн авч байна вэ?**

a. Өрхийн эмнэлэг
b. Аймгийн нэгдсэн эмнэлэг/БОЭТ
c. Улсын 1, 2, 3 дугаар эмнэлэг
d. Хувийн эмнэлэг
e. Бусад……………………………………………………………………………….(бичнэ үү?)

**7. Танд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад хялбар байдаг уу?**

a. Хялбар байдаг /энэ хариултыг сонгосон бол 9 дүгээр асуулт руу шилжинэ үү/
b. Ихэнхдээ төвөгтэй байдаг
c. Төвөгтэй байдаг тул эмнэлэгийн тусламж, үйлчилгээ авдаггүй.

**8. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахад төвөгтэй байдаг бол шалтгааныг нь бичнэ үү?**

.............................................................................................................................

**9. Таны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлсөн хүчин зүйлийг сонгоно уу?**

a. Зохисгүй хооллолт

b. Архи, тамхины хэрэглээ
c. Орлогын хүрэлцээгүй байдал
d. Гэр бүлийн уур амьсгал
e. Бусдын халамж анхаарал
f. Стресс
g. Удамшил
h. Ажлын нөхцөл
i. Эрүүл мэндийн боловсролын талаарх хангалтгүй мэдлэг
j. Ус, хөрс, агаар, байгаль орчны бохирдол
k. Эрүүл мэндийн хувьд ямар ч асуудалгүй

**10. Сүүлийн 2 жилд амь эрсдэхээр ямар нэгэн тохиолдолд өртөж байсан уу?.**
a. Тийм
b. Үгүй /энэ хариултыг сонгосон бол 12 дугаар асуулт руу шилжинэ үү./

11. **Амь эрсдэхээр ямар нэгэн тохиолдолд өртөж байсан бол**
a. Тохиолдлыг бичнэ үү:
……………………………………………………………………………..................................................
b. Тохиолдлын тоо…………………………………………………………………………..

**12. Та бага байхдаа хүнд ажил хийж байсан уу?**
a.тийм
b.үгүй

**13. Одоогийн эрхэлж буй ажлынхаа эрүүл мэндэд нөлөөлөх эрсдлийн түвшинг үнэлнэ үү.**
a. эрсдэлгүй
b. бага зэргийн эрсдэлтэй
c. дунд зэргийн эрсдэлтэй
d. өндөр эрсдэлтэй

**14. Та өөрийн эрүүл мэндийн байдлаас шалтгаалан тусламж, үйлчилгээ авсан БОЭТ-ийн тасгийг сонгоно уу**.(сүүлийн 1 жилийн дотор)
a. Дотор
b. Мэдрэл
c. Шүд, чих, хамар, хоолой,эрүү нүүрний мэс засал
d. Дотоод шүүрэл
e. Мэс засал, гэмтэл
f. Халдварт, сүрьеэ
g. Хавдар
h. Нүд
i. Бусад………………………………………………………………………………….

**15. Та эрэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг үнэлнэ үү?. (**Дорнод аймгийн хүрээнд**)**
a. маш сайн b. сайн c. дунд зэрэг d. муу e.маш муу

**16. Та өөрийн эрүүл мэндээ хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар ямар арга хэмжээ авдаг вэ?**
......................................................................................................................................
......................................................................................................................................

**17. Та орон нутагт Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр батлагдан, хэрэгжиж байгааг сонсож байсан уу?**
a. Тийм
b. Үгүй

**18. Та жендэртэй холбоотой мэдээллийг авдаг уу**?
a. Авдаг
b. Авдаггүй

**19. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн онцлог хэрэгцээнд зориулсан ямар үйлчилгээг бий болгох шаардлагатай гэж үздэг вэ?**
………………………………………………………………………………………………………
……………………………………………………………………………………………………… …

**Хавсралт-5**

## ЧАНАРЫН СУДАЛГАА

Чанарын судалгааны аргаар хувийн хэвшлийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдийн удирдах ажилтан, ажиллагсдын ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг болон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, ажлын байрны нөхцөл байдал, эрэгтэйчүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн тухай фокус бүлгийн хэлэлцүүлэг болон ганцаарчилсан ярилцлага хийж, асуудлын учир шалтгаан, түүнийг шийдвэрлэх боломжуудын талаар тодруулан судлана.

**Чанарын судалгааны хамрах хүрээ, гол мэдээлэгчдийн тоо**

| **Ганцаарчилсан ярилцлага** | **Респондентын тоо** | **Бүлгийн ярилцлага** | **Респондентын тоо** |
|---|---|---|---|
| 1. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн ажил олгогч болон ажиллагсдын ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг болон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, ажлын байрны нөхцөл байдлыг тодорхойлох | | | |
| Аймгийн ИТХ-ын дарга | 1 | Хувийн хэвшлийн ажилчдын төлөөллийн бүлэг | 8 |
| ИТХ-ын өргөдөл, гомдол, хяналт, үнэлгээний бодлогын хорооны дарга | 1 | Аж ахуйн нэгжийн ажилчдын төлөөллийн бүлэг | 8 |
| ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга | 1 | | |
| ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн жендэрийн мэргэжилтэн | 1 | | |
| Аймгийн ҮЭХ-ны дарга | 1 | | |
| Ажил олгогчдын эздийн холбооны тэргүүн | 1 | | |
| Хувийн хэвшил, ААНБайгууллагын удирдлага (Шин Шин ХХК, ДБЭХС ТӨХК, “Их тал” ХХК, “Онхоодой Өндөр” ХХК, НААҮГ) | 6 | | |
| Хүний эрхийн үндэсний комиссын салбар зөвлөлийн ахлах мэргэжилтэн | 1 | | |
| **1. Эрэгтэйчүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг тодорхойлох** | | | |
| Аймгийн ИТХ-ын нийгмийн бодлогын хорооны дарга | 1 | Эрэгтэйчүүдийн төлөөллийн бүлэг (Хувийн хэвшилд ажиллаж буй эрэгтэйчүүдийн бүлэг) | 8 |

| | | | |
|---|---|---|---|
| ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга | 1 | Зорилтот бүлгийн иргэдийн төлөөлөл | 8 |
| ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн, жендэрийн клубын гишүүн | 1 | ИНБ-уудын төлөөллийн бүлэг | 8 |
| Цэргийн штабын дарга | 1 | | |
| БОЭТ-ийн захирал | 1 | | |
| БОЭТ-ийн санхүү эрхэлсэн дэд захирал | 1 | | |
| БОЭТ-ийн чанарын менежер | 1 | | |
| БОЭТ-ийн мэс заслын эмч | 2 | | |
| ЭМГ-ын дарга | 1 | | |
| ЭМГ-ын статистикч, жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн | 1 | | |
| Хувийн эмнэлэгийн удирдлага | 1 | | |
| Орон нутгийн ИНБ-ын төлөөлөл | 3 | | |
| **Нийт** | **28** | **Нийт** | **34** |

**Хавсралт-6**

**ГАНЦААРЧИЛСАН ЯРИЛЦЛАГА**

Ажлын хуудас 3.9

**Ганцаарчилсан ярилцлагын удирдамж**

**Ерөнхий хэсэг**

**Ганцаарчилсан ярилцлагын зорилго:** Хувийн хэвшлийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдийн удирдах ажилтан нарын ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг болон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, ажлын байрны нөхцөл байдлын талаар ганцаарчилсан ярилцлага хийж, асуудлын учир шалтгаан, түүнийг шийдвэрлэх боломжуудын талаар тодруулан судлана.

| | |
|---|---|
| Аймаг, сумын нэр | Дорнод аймаг..................................... |
| Байгууллагын нэр | ...................................................................... |
| Албан тушаал, туршлага | ...................................................................... |
| Эхэлсэн цаг, дууссан цаг, хаана | ...................................................................... |
| Ярилцагч, тэмдэглэл хөтлөгчийн нэр | |

**Үндсэн хэсэг**

1. Орон нутагт хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдал ямар түвшинд байна гэж та боддог вэ?
2. Хувийн хэвшлийн ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгох ЖЭТБ хангах дэд хөтөлбөрт тусгагдсан тодорхой заалтуудын талаар танай байгууллагад юу хийгдэж байна вэ?
3. Танай байгууллагад ЖЭТБХангахад чиглэсэн үйл ажиллагаа төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжиж байна уу?. Хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар ажилтнуудад мэдээлэл хийдэг үү?
4. Хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн харилцаанд жендэрээр ялгаварлан гадуурхах, Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжид зөвшөөрснөөс бусад тохиолдолд эрэгтэй, эмэгтэй хүйсийн аль нэгэнд давуу эрх олгох, хязгаарлалт тогтоох, мөн жирэмсэн, хүүхэд асарсан болон гэр бүлийн байдлын шалтгаанаар ажилтныг ажлаас халахыг хориглосон бөгөөд энэ заалт үр дүнтэй хэрэгжиж байна уу?
5. Танай байгууллагын хөдөлмөр эрхлэлтийн дотоод журам, хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээнд ЖЭТБХ талаар ямар заалтууд орсон байдаг вэ?.

**Төгсгөл хэсэг**

1. “ААН байгууллага нь нийгмийн хариуцлагын хүрээнд дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцож дэмжлэг үзүүлнэ” хэмээн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн 6.3.3-т хэрэгжүүлэхэд оролцогч талуудын чиг үүргийг тусгасан байдаг. Танай байгууллага энэхүү заалтыг хэрэгжүүлэхэд хэрхэн оролцож байна вэ?
2. Танай байгууллагын бодлого, төлөвлөгөө, үйл ажиллагааны төсөвлөлт жендэрийн мэдрэмжтэй хийгддэг үү?.
3. Танай байгууллагын зүгээс хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ЖЭТБХ талаар санаачлан хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, туршлагаасаа хуваалцана уу?.
4. Танай байгууллагын хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд жендэрийн тулгамдсан асуудлыг хэрхэн шийдвэрлэж байна вэ?. Тухайлбал:

Тэмдэглэл (ярилцлагад оролцогчийн зан үйл, хандлагын талаарх мэдрэмж, ярилцлагын үеийн сэтгэгдэл, анхаарах асуудлыг тэмдэглэнэ)

**Тайлбар: Ганцаарчилсан ярилцлагад оролцож буй хүний ажил албан тушаалын чиг үүгийг харгалзан дээрх асуултуудаас сонгож ярилцлага хийнэ.**

**Хавсралт-7**

**ГАНЦААРЧИЛСАН ЯРИЛЦЛАГА**
Ажлын хуудас 3.9

**Ганцаарчилсан ярилцлагын удирдамж**
**Ерөнхий хэсэг**
**Ганцаарчилсан ярилцлагын зорилго:** Эрэгтэйчүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, тулгамдсан асуудал түүнийг шийдвэрлэх боломжуудыг тодорхойлох.

| | |
|---|---|
| Аймаг, сумын нэр | Дорнод аймаг..................................... |
| Байгууллагын нэр | ..................................................................... |
| Албан тушаал, туршлага | ..................................................................... |
| Эхэлсэн цаг, дууссан цаг, хаана | ..................................................................... |
| Ярилцагч, тэмдэглэл хөтлөгчийн нэр | |

**Үндсэн хэсэг**

1. Дорнод аймагт төрийн байгууллагын зүгээс эрэгтэй эмэгтэй хүмүүсийн эрүүл мэндийн онцлог хэрэгцээнд зориулсан үйлчилгээг бий болгоход хэрхэн анхаарч ажиллаж байна вэ?
2. Дорнод аймгийн хэмжээнд хэрэгжиж буй нийгмийн хөтөлбөр төслүүдийн жендэрийн мэдрэмжтэй байдлыг үнэлнэ үү?
3. Дорнод аймгийн хэмжээнд эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах нь жендэрийн тулгамдсан асуудал мөн үү?
4. Бодлогын түвшинд эрэгтэйчүүдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг бууруулахад ямар шийдвэрүүд гарсан бэ?
5. Эрэгтэйчүүдийн дунд зонхилон тохиолдож байгаа өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах санхүүжилтийг орон нутгийн болон улсын төсөвт аль хир тусгадаг вэ?
6. ЖЭТБХ хангах дэд хөтөлбөрийн 3.3.1-д “....Эрэгтэйчүүд болон хөвгүүдэд зориулсан кабинетийг байгуулан эрүүл мэндийн үзлэг оношилгоо, сэтгэл зүйн зөвлөгөө бусад үйлчилгээг нэмэгдүүлэх”” гэсэн заалтын хэрэгжилт ямар түвшинд байна вэ?

**Төгсгөл хэсэг**

1. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн 4.1.4-т “Эрэгтэйчүүд судлал, эрэгтэйчүүдэд үзүүлэх цогц үйлчилгээний эхлэл тавигдсан байна” гэсэн хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг гаргасан байна. Энэ ажлын хэрэгжилт, явцын талаар танилцуулна уу. Энэ асуудлын талаар цаашид хийхээр төлөвлөж буй ямар ажлууд байна вэ?

**Тэмдэглэл (ярилцлагад оролцогчийн зан үйл, хандлагын талаарх мэдрэмж, ярилцлагын үеийн сэтгэгдэл, анхаарах асуудлыг тэмдэглэнэ)**

**Тайлбар: Ганцаарчилсан ярилцлагад оролцож буй хүний ажил албан тушаалын чиг үүгийг харгалзан дээрх асуултуудаас сонгож ярилцлага хийнэ.**

**Хавсралт-8**

**<u>БҮЛГИЙН ЯРИЛЦЛАГА</u>**

**Бүлгийн ярилцлагын удирдамж**
**Ерөнхий хэсэг**

**Бүлгийн ярилцлагын зорилго:** Хувийн хэвшлийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдийн ажилчдын ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг болон ажлын байрны нөхцөл байдал, хөдөлмөрийн харилцаанд тулгарч буй жендэрийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх боломжуудыг тодорхойно.

| | |
|---|---|
| Аймаг нийслэл, сум дүүргийн нэр | ..................................................................... |
| Ярилцлага эхэлсэн, дууссан цаг, хаана | ..................................................................... |
| Бүлгийн ярилцлагад оролцогчдын категори | Хувийн хэвшлийн ажилчдын төлөөллийн бүлэг, Аж ахуйн нэгжийн ажилчдын төлөөллийн бүлэг |
| Чиглүүлэгчийн нэр | ..................................................................... |
| Ажиглагчийн нэр | ..................................................................... |

Танилцуулга
Бүлгийн ярилцлагад оролцогчдын мэдээлэл

| N | Нэр | Нас | Хүйс | Эрхэлдэг ажил | Ажилласан жил |
|---|---|---|---|---|---|
| 1 | ........... | ......... | ........... | ........... | ........... |
| 2 | ........... | ......... | ........... | ........... | ........... |
| 3 | | | | | |

**Үндсэн хэсэг**

1. *Жендэр болон жендэрийн ялгаварлан гадуурхалт гэдгийг юу гэж ойлгож байна вэ?*
2. *ЖЭТБХ дэд хөтөлбөр хэрэгждэг тухай сонсож байсан уу?*
3. *Хувийн хэвшил, аж ахуйн нэгж байгууллагын дотоод журам, хамтын гэрээ болон хөдөлмөрийн гэрээнд ЖЭТБХ тухай хэрхэн тусгасан байдаг вэ?*
4. *Ажлын байрны нөхцөл, хөдөлмөрийн харилцаанд гарч буй жендэрийн тулгамдсан ямар асуудал байна вэ?. Хэрвээ асуудал гарвал түүнийг хэрхэн шийдвэрлүүлэх вэ?*
5. *Байгууллагын дотоод журам, хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээнд ЖЭТБХ ямар заалтуудыг тусгах шаардлагатай гэж үзэж байна вэ?*

**Төгсгөл хэсэг**

1. *ЖЭТБХ талаар байгууллага болон таны зүгээс цаашид юу хийх боломжтой байна вэ?*

**Тэмдэглэл (ярилцлагад оролцогчийн зан үйл, хандлагын талаарх мэдрэмж, ярилцлагын үеийн сэтгэгдэл, анхаарах асуудлыг тэмдэглэнэ)**

**Хавсралт-9**

**<u>БҮЛГИЙН ЯРИЛЦЛАГА</u>**

**Бүлгийн ярилцлагын удирдамж**
**Ерөнхий хэсэг**

**Бүлгийн ярилцлагын зорилго:** Эрэгтэйчүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, тулгамдсан асуудал түүнийг шийдвэрлэх боломжуудыг тодорхойлох.

| | |
|---|---|
| Аймаг нийслэл, сум дүүргийн нэр | ...................................................................... |
| Ярилцлага эхэлсэн, дууссан цаг, хаана | .................................................................... |
| Бүлгийн ярилцлагад оролцогчдын категори | Эрэгтэйчүүдийн төлөөллийн бүлэг (Хувийн хэвшилд ажиллаж буй эрэгтэйчүүдийн бүлэг)<br><br>ИНБ-ын төлөөллийн бүлэг |
| Чиглүүлэгчийн нэр | .................................................................... |
| Ажиглагчийн нэр | .................................................................... |

**Танилцуулга**
**Бүлгийн ярилцлагад оролцогчдын мэдээлэл**

| N | Нэр | Нас | Хүйс | Эрхэлдэг ажил | Ажилласан жил |
|---|---|---|---|---|---|
| 1 | ........... | ......... | ........... | ........... | ........... |
| 2 | ........... | ......... | ........... | ........... | ........... |
| 3 | | | | | |

**Үндсэн хэсэг**

1. *Жендэр болон жендэрийн эрх тэгш байдал гэдгийг юу гэж ойлгож байна вэ?*
2. *ЖЭТБХ дэд хөтөлбөр хэрэгжсэн тухай сонсож байсан уу?*
3. *Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн онцлог хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн үйлчилгээг төрийн зүгээс үзүүлж байна уу?*
4. *Эрэгтэйчүүд эрүүл мэндээ хамгаалах болон үйлчилгээ авахад гарч буй хүндрэл бэрхшээлүүдийн талаар ярилцана уу?*
5. *Эрэгтэйчүүдийн эрүүл мэндэд нөлөөлж буй хүчин зүйл юу байна вэ? (Эерэг болон сөрөг)*
6. *Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад юу хийх шаардлагатай байна вэ?*

**Төгсгөл хэсэг**

1. *Орон нутагт эрэгтэйчүүд болон хөвгүүдэд зориулсан кабинетыг байгуулан эрүүл мэндийн үзлэг оношилгоо, сэтгэл зүйн зөвлөгөө болон бусад үйлчилгээг нэмэгдүүлэхэд хамгийн чухал ямар шийдвэр гаргах шаардлагатай байна вэ?*
1. *Эрэгтэйчүүд судлал, эрэгтэйчүүдэд зориулсан цогц үйлчилгээг хөгжүүлэх тухай та саналаа хэлнэ үү.*

**Тэмдэглэл (ярилцлагад оролцогчийн зан үйл, хандлагын талаарх мэдрэмж, ярилцлагын үеийн сэтгэгдэл, анхаарах асуудлыг тэмдэглэнэ)**